



---

# ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН 2021 ОНЫ УЛСЫН НЭГДСЭН ТАЙЛАН

---

Улаанбаатар хот  
2022 он

# ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН 2021 ОНЫ УЛСЫН НЭГДСЭН ТАЙЛАН

---

<b>Хянасан:</b>	Р.Ганхуяг - ЗУХАГ-ын дарга П.Баянтүмэн - КХ-ийн дарга
<b>Эмхэтгэсэн:</b>	Х.Энхжаргал - КХ-ийн ахлах мэргэжилтэн
<b>Тайлан гаргасан:</b>	А.Энхбаатар - КХ-ийн ахлах мэргэжилтэн Х.Энхжаргал - КХ-ийн ахлах мэргэжилтэн С.Энх-Эрдэнэ - КХ-ийн ахлах мэргэжилтэн С.Ганцэцэг - ЗУХАГ-ын ахлах мэргэжилтэн Г.Мөнхцэцэг - ЗУХАГ-ын ахлах мэргэжилтэн Ж.Баянмөнх - КХ-ийн мэргэжилтэн Э.Энх-Эрдэнэ - КХ-ийн мэргэжилтэн Б.Урантөгс - КХ-ийн мэргэжилтэн Д.Түмэндэмбэрэл - ЗУХАГ-ын мэргэжилтэн Д.Мөнхцэцэг - ССМХ-ийн мэргэжилтэн Р.Отгончимэг - ГЗБХ-ийн мэргэжилтэн Ц.Ламзав - КХ-ийн мэргэжилтэн П.Нямдарь - ХБКХ-ийн мэргэжилтэн

# АГУУЛГА

ОРШИЛ .....	4
-------------	---

## **1. ТАЙЛАНТ ОНД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН.....5**

1.1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас хэрэгжүүлсэн томоохон ажлууд .....	5
1.1.1. Газар зохион байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн чиглэлээр .....	5
1.1.2. Суурь судалгаа, мониторингийн чиглэлээр .....	12
1.1.3. Газрын кадастр, мэдээллийн сангийн чиглэлээр.....	20
1.1.4. Орон зайн мэдээлэл, технологийн чиглэлээр.....	34
1.1.5. Хот байгуулалтын кадастрын чиглэлээр .....	40
1.2. Газрын харилцааны салбарын хүний нөөцийн судалгаа .....	50
1.3. Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар хийсэн хяналт, шалгалт.....	64
1.4. Өргөдөл, хүсэлт, тэдгээрийн барагдуулалтын судалгаа .....	67
1.5. Газрын маргаан, түүнийг шийдвэрлэсэн байдал .....	70
1.6. Газар эзэмших эрх болон өмчийн газраа банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдлын тайлан .....	74
1.7. Газрын зах зээлийн тойм.....	77
1.8. Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын талаарх мэдээ, тайлан .....	87
1.9. Сууц өмчлөгчдийн холбоонд ашиглуулж буй газрын тайлан.....	93
1.10. Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2022 оны төлөвлөгөө .....	95
1.10.1. Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт .....	95

## **2. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТАЙЛАН107**

2.1.Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал, газар ашиглалтын төрөлд гарсан өөрчлөлт, шилжилтийн үндэслэл /Маягт ГТ-1, 5/ .....	119
2.1.1. Хөдөө аж ахуйн газар.....	121
2.1.2. Хот, тосгон, бусад суурины газар.....	124
2.1.3. Зам, шугам сүлжээний газар.....	125
2.1.4. Ойн сан бүхий газар .....	127
2.1.5. Усны сан бүхий газар.....	127
2.2. Улсын тусгай хэрэгцээний газар /маягт ГТ-4/ .....	128
2.3. Газрын нэгдмэл сангийн эрх зүйн байдлын тайлан /Маягт ГТ-2/ .....	132
2.4. Газрын улсын бүртгэлийн тайлан /Маягт ГТ-3/.....	137
2.5. Газарт учруулсан хохирлын тайлан /Маягт ГТ-6/.....	141
2.6. Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайлан /Маягт ГТ-7/.....	146
2.7. Газрын төлбөр ногдуулалт, төлөлтийн тайлан /Маягт ГТ-8/ .....	151
2.8. Газар өмчлөлийн тайлан /Маягт ГТ-9/ .....	158

## **3. ДҮГНЭЛТ.....161** **Хавсралтууд .....**165

## ОРШИЛ

Монгол Улсын Газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангилал бүрийн газрын тоо бүртгэл, газрын улсын бүртгэл, шилжилт хөдөлгөөн, газарт учирсан хохирол, газар хамгаалах, нөхөн сэргээх талаар авсан арга хэмжээ, газрын төлбөр ногдуулалт, төвлөрүүлэлт зэрэг үзүүлэлтийг засаг захиргааны нэгж тус бүрээр тусган Улсын газрын нэгдмэл сангийн тайланг гаргаж, Засгийн газарт танилцуулж байхаар Монгол Улсын Газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2.6-д заасан байдаг.

Дээрх заалтыг үндэслэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас аймаг, нийслэлийн 2021 оны газрын нэгдмэл сангийн тайланг Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Газрын нэгдмэл сангийн тайлан гаргах журам" болон Засгийн газрын 2003 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан тайлангийн ГТ1-ГТ9 маягтуудын дагуу нэгтгэн улсын нэгдсэн тайланг гаргалаа.

Газрын нэгдмэл сангийн Улсын нэгдсэн тайлан нь тайлангийн хугацаанд газрын нэгдмэл сангийн ангилал болон газар өмчлөл, эзэмшил, ашиглалтын эрх зүйн байдал, тэдгээрийн өөрчлөлтийг гаргах, өөрчлөлтөд дүгнэлт өгөх, газрын талаар авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг тодорхойлох, цаашид газрыг өмчлөх, эзэмших, ашиглах, хуваарилах, хамгаалах, нөхөн сэргээх болон газар зохион байгуулалтын бусад арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, газрын нэгдмэл сангийн өгөгдөхүүнд өөрчлөлт оруулах, улс, орон нутгийн статистик мэдээнд ашиглахад суурь материал болдог ач холбогдолтой юм.

# 1

## ТАЙЛАНТ ОНД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

### 1.1. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛСЭН ТОМООХОН АЖЛУУД

#### 1.1.1. Газар зохион байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн чиглэлээр.

Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн цахим системийг хөгжүүлж, [www.egazar.gov.mn](http://www.egazar.gov.mn)-ээр дамжуулан бүхий л салбарууд газар зохион байгуулалт, хот байгуулалт болон бусад орон зайн төлөвлөлтийг боловсруулах ажлыг хоорондоо харилцан уялдаатайгаар хийх боломжийг бүрдүүлээд байна. Мөн энэхүү модуль нэвтэрснээр нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтэн, сумын газрын даамлууд заавал байгууллагын дотоод сүлжээнд нэвтрэх, сүлжээний тохиргоо хийх зэрэг нэмэлт ажил, дэд бүтэц шаардахгүйгээр дурын операторын интернет ашиглан хэдийд ч хаанаас ч төлөвлөгөөгөө хялбар, энгийн байдлаар боловсруулах боломж нээгдлээ /Зураг 1.1.1.1/.



Зураг 1.1.1.1: Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн цахим систем

Мөн 2021 онд нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, аймгийн ГХБХБГ-тай хамтран нийслэл, 21 аймгийн хэмжээнд 31 төрлийн 141 мянган давхарга бүхий хамгаалалтын бүс, зурвас газрын мэдээллийн санг үүсгэж, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хяналт тавихад ашиглаж эхлээд байна.

Улсын хэмжээнд 2204 баримт бичиг бүртгэгдэж, 11386 иргэн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгсөн байна.



Зураг 1.1.1.2: Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн цахим системийн статистик мэдээ

Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2021 оны хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-г баталсан бөгөөд Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулдаг.

Үүний дагуу Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг ирүүлэх тухай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2021 оны 1/2344 тоот албан бичгийг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлж, Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2021 оны хэрэгжилтийн тайланг авч нэгтгэлээ.

Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь нийт 11 зорилтын хүрээнд 130 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Тайлангийн хугацаанд хэрэгжсэн томоохон ажлуудаас дурьдвал салбарын хэмжээнд хуулийн төсөл боловсруулах, Газрын удирдлагын нэгдсэн системийн үйл ажиллагааг тогтворжуулах, орон зайн мэдээллийн суурь өгөгдлийн стандарт батлуулах, холбогдох журам, зааврыг шинэчлэн боловсруулах ажлын хэрэгжилт сайн байна.

Мөн бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, услалтын системийг шинэчлэх, ундны болон ахуйн усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн хил зааг, дэглэм тогтоох, усны эх бүрэлдэх газрын хил заагийг тогтоох, хүн амын усан хангамжийн эх үүсвэрийг шинээр байгуулах, өргөтгөх, шинэчлэх, цэвэрлэх байгууламж шинээр барих, хот суурины орчмын газарт хамаарах голын эргийг тохижуулах, ойжуулалт, ойн зурвас байгуулах, холбоо мэдээллийн дэд бүтцийг сайжруулах зорилтын хэрэгжилт хангалттай байна.

Харин хөв цөөрөм байгуулах газрын судалгаа хийх, сумын төв, суурин газруудын усны нөөцийн эрэл хайгуул хийх, батлан хамгаалах цэргийн анги, хилийн боомтуудын усан хангамжийг сайжруулах, отрын бүс нутаг байгуулах, Халх голын


бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэх, рашаан сувиллын газрыг тохижуулах, их дээд сургуулиудын хотхон байгуулах, нүүлгэн шилжүүлэх, усны эх орчмын газар, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, гүний усны тэжээгдлийн муж, ангийн бүс, тусгай хамгаалалтад авахаар төлөвлөсөн газруудтай давхцалтай уул уурхайн хайгуулын болон ашиглалтын лицензтэй газруудын давхцлыг арилгах, аюултай хог хаягдлын байгууламж барих газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, соёлын өв, түүхийн дурсгалуудын хамгаалалтын бүсийг газар дээр нарийвчлан тогтоох, бүртгэлжүүлэх ажлын хэрэгжилт хангалтгүй байна.

Аймаг, нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах чиглэлээр:

Аймаг, нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил нь Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.7.4-ын 4-т 8 аймгийн /Булган, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Сэлэнгэ, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Ховд, Говь-Алтай/ Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулахаар тусгагдсан.

Нийт 10 аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулаад байгаа бөгөөд цаашид 11 аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах шаардлагатай байна /Зураг 1.1.1.3/. Эдгээр аймгуудаас 2021 онд орон нутгийн төсвөөр нийслэл, Булган, Баянхонгор, Баян-Өлгий аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг эхлүүлэх ажил үргэлжилж байна.

Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Сэлэнгэ, Өвөрхангай буюу нийт 5 аймгийн ерөнхий төлөвлөгөөг олон улсын төсөл, хөтөлбөр болон орон нутгийн санхүүжилтээр 2022 онд хийхээр төлөвлөөд байна. Цаашид Архангай, Говь-Алтай, Ховд аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хийх шаардлага тулгараад байна.




Зураг 1.1.1.3: Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан байдал

*Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах чиглэлээр:*

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажил нь Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.7.4-ын 5-т 54 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахаар тусгагдсан.

Баянхонгор аймгийн Жинст сум, Булган аймгийн Баян-Агт, Баяннуур, Бүрэгхангай, Гурванбулаг, Могод, Сайхан, Рашаант, Төв аймгийн Алтанбулаг, Дорнод аймгийн Цагаан-Овоо, Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Увс аймгийн Өлгий, Цагаанхайрхан нийт 13 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг 2021 онд боловсруулах ажил хийгдсэн байна /Зураг 1.1.1.4/.

Дорнод аймгийн Матад, Хөлөнбуйр, Булган, Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Түмэнцогт, Мөнххаан, Хэнтий аймгийн Норовлин, Баян-Овоо, Баян-Адарга, Завхан аймгийн Алдархаан, Эрдэнэхайрхан, Отгон, Ховд аймгийн Мянгад, Буянт, Эрдэнэбүрэн гэсэн нийт 15 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг 2022 онд олон улсын төсөл хөтөлбөр болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр боловсруулахаар төлөвлөн ажиллаж байна.




Зураг 1.1.1.4: Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулсан байдал



Сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах чиглэлээр:


Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт:

Улсын хэмжээнд сумдын газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний дагуу газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газарт нийт **75156** байршил бүхий **6.2 сая га** газрыг төлөвлөснөөс **31936** байршилд **5.8 сая га** газрыг эзэмшүүлэх болон өмчлүүлэх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.



Зураг 1.1.1.5: Улсын хэмжээний 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт, байршлаар

Нийслэл, сум дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт арга хэмжээний төрлөөр:



Зураг 1.1.1.6: Улсын хэмжээний 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт, арга хэмжээний төрөл /байршлаар/


Энэхүү графикаас харахад иргэн, аж ахуйн нэгжид олгохоор төлөвлөсөн газар нь нийт төлөвлөгөөний **94.4** хувийг дангаараа эзэлж байна.

Газар хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, бэлчээрийн менежментийн төлөвлөсөн арга хэмжээ нь нийт төлөвлөсөн арга хэмжээний **0.9** хувийг эзэлж байгаа нь цаашид төлөвлөгөөг газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээр бүрэн төлөвлөж, Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах шаардлагатай байна.

Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөө боловсруулсан байдал

Улсын хэмжээнд сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн 2022 оны төлөвлөгөөнд нийт **4.9** сая га газрыг төлөвлөсөн байна. Үүнээс хөдөө аж ахуйн ангиллын газарт нийт **2.7** сая га газрыг болон хот, тосгон бусад суурины газарт **128.7** мянган га газрыг, зам шугам, сүлжээний газарт **123.9** мянган га газрыг, бусад ангиллын газарт **1.9** сая га газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалахаар тус тус төлөвлөжээ.

Улсын хэмжээнд сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд арга хэмжээний төрлөөр дараах байдлаар төлөвлөсөн байна. Үүнээс өргөдлийн дагуу олгох нийт **84846** байршилд 92.60%, дуудлага худалдаагаар олгох **3155** байршилд 3.47%, төсөл сонгон шалгаруулалтаар олгох **246** байршилд 0.27%, газар хамгаалах, нөхөн сэргээхээр **833** байршилд 0.92%, газар чөлөөлөх **437** байршилд 0.48%, нийтийн эдэлбэрийн газарт **2113** байршилд 2.33% тус тус төлөвлөжээ.




Зураг 1.1.1.7: 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, арга хэмжээний төрлөөр /байршил, хувиар/

“Монгол Улсын иргэнд 2021 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай” Засгийн газрын 262 дугаар тогтоолын хэрэгжилт

Нийслэлийн хэмжээнд болон Говьсүмбэр аймагт 2021 онд иргэдэд газар өмчлүүлээгүй бөгөөд 2021 оны **262** дугаар тогтоолын хэрэгжилтийг бусад **20** аймгаар нэгтгэн гаргав.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 262 дугаар тогтоолоор Улсын хэмжээнд нийт **33757** иргэнд **3.7** мянган га газрыг өмчлүүлэхээр баталснаас нийт **12897** иргэнд **1.3** мянган га газрыг өмчлүүлсэн байна. Үүнээс гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй 975 иргэнд эзэмших эрхээр олгогдсон **0.1** мянган га, **11915** иргэнд шууд өмчлөх эрхээр **1.2** мянган га, **7** иргэнд аж ахуйн зориулалтаар **3.9** га газрыг үнээр нь тус тус өмчлүүлсэн байна.

Улсын хэмжээнд Засгийн газрын 2021 оны 262 дугаар тогтоолын хэрэгжилт **36.5** хувьтай байна.



Зураг 1.1.1.8: 2021 онд Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газрын хэмжээ /га-аар/

“Монгол Улсын иргэнд 2022 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төсөл

Монгол Улсын хэмжээнд **2022** онд нийт **32391** иргэнд **3.9** мянган га газрыг өмчлүүлэхээс **32357** иргэнд **3.9** мянган га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар, **34** иргэнд **30.50** га газрыг аж ахуйн зориулалтаар тус тус өмчлүүлэхээр төлөвлөсөн байна.

Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлүүлэхээр төлөвлөсөн нийт **3937.1** га газрын **22** хувийг эзэмшиж байгаа газрыг өмчлүүлэх, **78** хувийг өмчлөх эрхээр шууд өмчлүүлэх газар тус тус эзэлж байна.

Нийслэлийн хэмжээнд нийт **5538** иргэний эзэмшиж буй **315.17** га газрыг өмчлүүлэхээр төлөвлөсөн байна.

### 1.1.2. Суурь судалгаа, мониторингийн чиглэлээр.

#### *Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажил*

Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийг тогтсон хугацаанд тогтмол хянах, өөрчлөлтийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, ашиглалтыг тохируулах, үнэлэлт, дүгнэлт өгөх, холбогдох мэдээллийн санг үүсгэн хэрэглэгчдийг мэдээллээр хангах, бэлчээрийн газрын хөрсийг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах суурь мэдээлэл болгох зорилгоор бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг Улсын хэмжээнд 6 дахь жилдээ зохион байгуулан ажиллаж байна.<sup>1</sup>

*Хэрэглээний давуу тал:* Бэлчээрийн газарт фотомониторинг хийх аргын давуу тал нь богино хугацаанд нэг дор олон мэдээллийг цуглуулах, хэрэглэхэд энгийн, зардал багатай, сэргэн ургалт, доройтлын урт, богино хугацааны өөрчлөлтийг харуулдаг оршино.

*Үр дүн:* 2021 оны байдлаар бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг нийслэлийн 6 дүүрэг, 21 аймгийн 320 сумын хэмжээнд 110.8 сая га бэлчээрийн газрын 5199 мониторингийн цэгт зохион байгуулан ажилласан байна /Хүснэгт 1.1.2.1/.

*Хүснэгт 1.1.2.1: Бэлчээрийн мониторингийг төлөөлж буй талбайн хэмжээ.*

№	Аймаг	Сумын тоо	Мониторингийн нийт цэгийн тоо	Талбайн хэмжээ /га/
1	Архангай	18	355	3,742,769
2	Баянхонгор	19	311	8,291,722
3	Баян-Өлгий	12	304	3,250,968
4	Булган	16	212	2,185,626
5	Говь-Алтай	18	345	8,040,281
6	Говьсүмбэр	3	46	468,527
7	Дархан-Уул	3	27	146,306
8	Дорнод	13	256	9,711,851
9	Дорноговь	14	228	8,976,565
10	Дундговь	15	233	7,045,553
11	Хэнтий	17	352	5,695,197
12	Ховд	17	203	5,564,012
13	Хөвсгөл	23	395	3,728,768
14	Сэлэнгэ	17	98	1,608,226
15	Сүхбаатар	13	252	8,111,259
16	Төв	26	264	5,229,240
17	Өмнөговь	15	193	10,141,057


<sup>1</sup> 2015 оноос эхлэн Швейцарийн хөгжлийн агентлаг Ногоон-Алт төслийн дэмжлэгтэйгээр “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажил”-ыг хэрэгжүүлсэн байна.

18	Увс	19	348	6,153,256
19	Завхан	23	440	6,732,066
20	Орхон	1	8	28,009
21	Өвөрхангай	18	293	5,790,992
22	Улаанбаатар	6	36	208,103
<b>ДҮН</b>		<b>326</b>	<b>5199</b>	<b>110,850,353.2</b>


*Бэлчээрийн газрын төлөв байдлын өөрчлөлт:* 2017 оны бэлчээрийн газрын төлөв байдал, мониторингийн үр дүнг 2021 он хүртэлх үр дүнтэй харьцуулахад бэлчээрийн төлөв байдлын доройтлын хэмжээ нэмэгдсэн байна /Хүснэгт 1.1.2.1/

Хүснэгт 1.1.2.2: Бэлчээрийн доройтлын ангиллын хувь

№	Бэлчээрийн сэргэх чадавхийн ангилал	2017 он	2018 он	2019 он	2020	2021
1	I-Байгалийн унаган төрхөө алдаагүй	30%	19%	17%	12%	12%
2	II - бага зэрэг доройтсон	55%	38%	35%	43%	45%
3	III - Дунд зэрэг доройтсон	12%	19%	22%	21%	18%
4	IV- Хүчтэй доройтсон	4%	20%	21%	18%	17%
5	V - Маш хүчтэй доройтсон	0%	4%	5%	6%	8%
<b>Нийт хувь</b>		<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>



Зураг 1.1.2.1: Бэлчээрийн доройтлын ангилал, графикаар.



Зураг 1.1.2.2: 2021 оны бэлчээрийн төлөв байдал, сэргэх чадвар


**Бэлчээрийн доройтлын байдал:** 2021 оны байдлаар нийт бэлчээрийн газрын 14.9 сая га талбай буюу 12% нь байгалийн унаган төрхөө алдаагүй, 50.5 сая га талбай буюу 45% нь бага зэрэг доройтсон, 21.4 сая га талбай буюу 18% нь дунд зэрэг доройтсон, 158.2 мянган га талбай буюу 17% нь хүчтэй доройтсон, 7.4 сая га талбай буюу 8% нь маш хүчтэй доройтсон байна.

**Бэлчээрийн даац:** 2021 оны байдлаар улсын хэмжээнд бэлчээрийн мониторингийн үр дүнгээр хонин толгойд шилжүүлснээр бэлчээрийн даацыг гаргасан байна /Хүснэгт 1.1.2.3/.

Хүснэгт 1.1.2.3: Бэлчээрийн даац, аймгуудаар

№	Аймаг	Бодит ургац кг/га	Бэлчээрийн талбай (га)	Тэжээлийн нөөц, кг	Өвөл, хаврын бэлчээрийн даац, хонин толгой	Малын тоо хонин толгой, 2020 он	Зөрүү
1	Архангай	712	3,737,530	2,660,074,873	8,396,701	10,977,676	(2,580,975)
2	Баянхонгор	217	8,215,353	1,780,727,142	9,094,623	6,048,130	3,046,493
3	Баян-Өлгий	88	3,528,989	311,002,751	1,835,908	3,540,173	(1,704,265)
4	Булган	355	2,484,322	882,073,503	2,812,734	6,170,745	(3,358,011)

5	Говь-Алтай	129	8,608,484	1,107,292,093	5,655,220	4,386,306	1,268,914
6	Говьсүмбэр	183	472,347	86,620,882	442,395	653,989	(211,594)
7	Дархан-Уул	812	175,395	142,444,756	519,114	712,465	(193,352)
8	Дорнод	750	8,654,930	6,491,950,404	23,658,711	6,165,704	17,493,007
9	Дорноговь	102	9,106,272	932,336,532	4,761,678	4,125,226	636,452
10	Дундговь	110	7,146,531	789,577,364	4,032,571	5,115,707	(1,083,136)
11	Хэнтий	597	5,009,231	2,990,766,079	10,899,293	8,324,366	2,574,927
12	Ховд	135	5,057,677	681,693,964	3,481,583	4,937,722	(1,456,139)
13	Хөвсгөл	51	4,385,787	225,464,559	711,694	9,433,972	(8,722,278)
14	Сэлэнгэ	524	1,607,335	842,481,373	2,659,348	3,691,414	(1,032,066)
15	Сүхбаатар	360	7,668,350	2,760,329,939	14,097,701	7,186,349	6,911,352
16	Төв	617	5,181,195	3,197,098,071	11,651,232	8,535,028	3,116,204
17	Өмнөговь	223	11,429,634	2,544,099,328	12,993,357	4,187,523	8,805,834
18	Увс	88	4,109,597	362,703,168	1,852,417	5,263,737	(3,411,320)
19	Завхан	288	6,516,019	1,877,727,711	6,843,031	6,051,925	791,106
20	Орхон	360	39,329	14,172,562	51,649	310,509	(258,860)
21	Өвөрхангай	318	5,691,975	1,812,848,374	9,258,674	7,344,499	1,914,175
22	Улаанбаатар	113	213169.5	24088153.5	87784.8	1,248,246	(1,160,461)



Зураг 1.1.2.3: 2021 оны жилийн бэлчээрийн даац.


Бэлчээрийн хөрс хамгаалах, нөхөн сэргээлт хийх ажил

Бэлчээрийн фото мониторингийн ажлын тухайн оны үр дүнг ашиглан бэлчээрийн хөрс хамгаалах, нөхөн сэргээлт хийх үйл ажиллагааг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах боломж бүрдсэн байна.

Хүснэгт 1.1.2.4: Бэлчээрийн хөрс хамгаалах, нөхөн сэргээх ажил

№	Аймаг	Хөрс хамгаалах, нөхөн сэргээлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн ажил						Нийт талбайн хэмжээ, га
		Бэлчээр чөлөөлсөн	Булгийн эх хамгаалж хаших	Бэлчээр усжуулсан	Бэлчээр өнжөөж сэлгэсэн	Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажил	Худаг гаргах, засварлах	
1	Архангай	64485.1				7500	1	71985
2	Баянхонгор	850335.1		11056	1389554	50200	3	2301145
3	Баян-Өлгий		0	23	97205	4000	9	101228
4	Булган	1600	1		101967.7	134932.8	13	238501
5	Говь-Алтай			317514	24445	7250		349209
6	Говьсүмбэр	34300	3	1000	34300		2	69603
7	Дорнод	3	3	3	15233.6	33000	38	48243
8	Сүхбаатар	151200	0	19100	5	65000	31	235305
9	Төв	79600				15000	52	94600
10	Дархан-Уул							0
11	Сэлэнгэ	15	3		24		3	42
12	Завхан	357878	40341	33247.5	459835.5	304165.5	11	1195468
13	Дундговь			23570		55700		79270
14	Өвөрхангай	27.14	0	3074.94	422.92	14.62	44	3540
15	Өмнөговь	3140	15	83250	1130		61	87535
16	Дорноговь							0
17	Хэнтий			192168	15504	58000	35	265672
18	Орхон				17			17
19	Хөвсгөл	389148.7	6		245700	32000		666855
20	Ховд	337383	4			5500	8	342887
21	Увс		1	4590	365682.6		14	370273
22	Нийслэл							0
<b>ДҮН</b>		<b>2'269'115.0</b>	<b>40'376.6</b>	<b>688'596.4</b>	<b>2'751'026.3</b>	<b>772262.9</b>	<b>325</b>	<b>6'521'377.3</b>





Зураг 1.1.2.4: Бэлчээрийн хөрс хамгаалах, нөхөн сэргээлт хийх ажлын хувь.

Нийслэл, 21 аймгийн хэмжээнд нийт 6.5 сая га талбайд бэлчээрийн хөрс хамгаалах нөхөн сэргээлтийн ажлыг 2021 онд зохион байгуулсан байгаа бөгөөд 2.3 сая га талбайг чөлөөлсөн, 40.4 мянган га талбайг хашиж хамгаалсан, 688.6 мянган га талбайд бэлчээр усжуулсан, 2.7 сая га талбайг өнжөөж сэлгэсэн, 772.2 мянган га талбайд хортон мэрэгчтэй тэмцэх ажлуудыг тус тус хийсэн байна.

*“Зайнаас тандан судлалын аргаар бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, мониторинг хийх аргачлал” боловсруулах ажил*


Манай орны хувьд өргөн уудам газар нутаг, байгаль, цаг уурын онцлогоос хамаарч бэлчээрийн газрын төлөв байдлыг тогтмол, хяналт мониторинг хийх нь цаг хугацаа, хөрөнгө мөнгө их шаарддагаас гадна ажиллах боловсон хүчний хүртээмж төдийлөн хангалттай биш байдаг. Тиймээс зайнаас тандан судлалын арга зүй, цаг хугацаа, орон зай, спектрийн өндөр нарийвчлал бүхий хиймэл дагуулын мэдээ ашиглах, арга зүйг нэвтрүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага байсан.

Бэлчээрийн газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд төрийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлж, бэлчээрийн газрын мониторингийн судалгаанд зайнаас тандан судлалын болон ургамлын хээрийн судалгааны аргыг хослуулан бэлчээрийн газрын биомассыг тодорхойлох, улмаар бэлчээрийн даацыг тогтоон, даац хэтрэлтийг үнэлэх болон бүх түвшний газар зохион байгуулалтын төлөвлөлт, газрын мониторингийн мэдээллийн санг анхдагч болон хяналтын мэдээллүүдээр хангах, газрын мониторингийн цахим системийн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилготой.

Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээний цэгүүдэд зайнаас тандан судлалын арга буюу спектрометрийн хэмжилтийг ургамлын хээрийн судалгаатай хослуулан туршиж, бэлчээрийн төрх байдлыг сар, улирал, жилээр тодорхойлж, бэлчээрийн чадавх, нөлөөлөл, бэлчээрийн даацыг бүрэн тодорхойлох боломж бүрдэж байна.

Улс, бүс, аймаг, сумын бэлчээрийн газрын мониторингийн судалгаанд Landsat, Sentinel болон бусад хиймэл дагуулын мэдээг ашиглана /Зураг 1.1.2.5/.

## Бэлчээрийн мониторингийн зайнаас тандах арга зүй



Зураг 1.1.2.5: Бэлчээрийн мониторингийн зайнаас тандан судлах арга зүй


Зайнаас тандан судлалын технологийг ашиглан хүрч очиж ажиллахад хүндрэлтэй өргөн уудам бэлчээрийн газарт зайнаас тандан судлалын аргаар мониторинг хийх шинэ аргачилсан зааврыг энэ чиглэлээр урт хугацаанд судалгаа шинжилгээ хийж ирсэн эрдэмтэн, судлаач нартай хамтран боловсруулж, Улсын хэмжээнд спектрометрийн багажаар 265 цэгт хэмжилт хийж, суурь өгөгдөл мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх ажлыг практикт туршиж, гүйцэтгэж, аргачлалыг боловсруулан гаргасан.

Зайнаас тандан судалгааны аргыг бэлчээрийн газрын мониторингийн үйл ажиллагаанд нэвтрүүлснээр дараах ач холбогдолтой юм. Үүнд:

- Аймаг, сум, ургамал газарзүйн мужлал бүрээр бэлчээрийн төрөл, ашиглалтын хэлбэрээс хамааран төлөв байдал, чанарын өөрчлөлтийг таамаглах, илрүүлэх, өөрчлөлтийг үнэлэх боломжтой болно.
- Бэлчээрийн мониторингийн байнгын ажиглалтын үр дүнд үндэслэн ургамалжилтын өөрчлөлт, төлөв байдлыг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ.
- Бэлчээрийн мониторингийн байнгын ажиглалтын үр дүнд үндэслэн ургамлан нөмрөгийн төлөв байдлыг хянах, бэлчээр-хадлангийн газрын талхлагдлаас сэргийлэх, сөрөг нөлөөллийн учир шалтгааныг тайлах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд ашиглах боломж бүрдэнэ.
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн явцад газарт учирсан доройтлын төрөл, бохирдлыг хянах бүрэн боломжтой болно.

Бэлчээрийн төлөв байдал, чанарын мониторингийн ажил гүйцэтгэх, бэлчээрийн газрын өөрчлөлтийн явцыг хянах, цаг тухайд нь илрүүлэх, доройтол, талхлагдлаас

урьдчилан сэргийлэх, бэлчээр ашиглалтын даац, ачааллыг тохируулах, үнэлэлт дүгнэлт өгөх, мэдээллийн сан үүсгэх, хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх зорилгоор бэлчээрийн газрын өөрчлөлтийг зайнаас тандан судлалын аргаар үнэлэх, мониторингийн сүлжээний цэгт судалгаа хийхэд тус аргачлалыг ашиглах юм.



Зураг 1.1.2.6: Бэлчээрийн биомассын 2021 оны 8 сарын зураг (цн/га)


Бэлчээрийн болон хот суурин газрын мониторингийн үндэсний сүлжээний 500 цэгт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх ажил

Бэлчээрийн болон хот суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа (газрын төлөв байдал, чанарын мониторингийн сүлжээний цэгт) хийх ажлыг 2021 онд бэлчээрийн газрын мониторингийн 500 цэгт хийж гүйцэтгэсэн.

Газрын төлөв байдал, чанарын мониторингийн үндэсний сүлжээний хөдөө аж ахуй, хот, тосгон бусад суурины газрын ажиглалтын цэгүүдэд бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг гүйцэтгэх, мониторингийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, нэгтгэх, мэдээллийн санг баяжуулахад энэхүү ажлын зорилго оршино.

Үр дүн: Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа (газрын төлөв байдал, чанарын мониторингийн 500 сүлжээний цэгт)-ны ажлын үр дүнг хүлээн авснаар дараах үр дүнгүүд гарсан. Үүнд:

1. “Зайнаас тандан судлах аргаар бэлчээрийн газрын мониторинг хийх аргачилсан заавар” боловсруулахад шаардлагатай хээрийн судалгааг хийсэн.
2. Бэлчээрийн мониторингийн 500 цэгийн ургамлын спектрометрийн хэмжилтийн өгөгдөл, зураглал, мэдээллийн санг үүсгэсэн.
3. Бэлчээрийн мониторингийн байнгын ажиглалтын 500 цэг тус бүрээр хянан баталгааны дүгнэлт, сүлжээний зураг, хувийн хэргийг боловсруулсан байна.



Зураг 1.1.2.7: Бэлчээрийн мониторингийн судалгаа хийсэн чиглэл, бэлчээрийн нэгж талбарын сүлжээний зураг.


### 1.1.3. Газрын кадастр, мэдээллийн сангийн чиглэлээр.

#### Газрын кадастрын мэдээллийн систем

Монгол Улсын Засгийн газраас 2021-2024 онд “Цахим үндэстэн” болох зорилт дэвшүүлсний хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь 2021 оныг “Газрын харилцааны цахим шилжилт, эрх зүйн шинэтгэлийг эрчимжүүлэх жил” болгон зарлаж, үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан.

Газрын цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилгоор Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийн иргэд, олон нийтэд зориулсан цахим систем /[www.egazar.gov.mn/](http://www.egazar.gov.mn/)-ийг 2021 оны 10 дугаар сарын 01-нээс албан ёсоор хэрэглээнд нэвтрүүлсэн.

[www.egazar.gov.mn](http://www.egazar.gov.mn) веб хандалтат цахим хуудаснаас газартай холбоотой нээлттэй, баталгаат мэдээллийг авахаас гадна газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн төрийн танилт, нэвтрэлтийн ДАН системийг ашиглан нэвтэрч өөрийн газартай холбоотой 18 төрлийн мэдээллийг авах бөгөөд Газрын албанд иргэн, хуулийн этгээд газар эзэмших, өмчлөх, ашиглах эрхтэй холбоотой 17 төрлийн өргөдлийг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар илгээх боломжтой болсон.



Зураг 1.1.3.1: Egazar.gov.mn веб системийн хандалт, үйлчилгээний статистик

Дээрх цахим системийг ашигласнаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тулгардаг байсан газартай холбоотой олон асуулт, асуудал шийдвэрлэгдэхээс гадна төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмж илүү сайжирч хийх ажлын ачаалал буурах ач холбогдолтой. Тухайлбал, нэг иргэн зөвхөн өргөдлийн явцаа мэдэхийн тулд Газрын албанд 0.5 - 1 цагийг, түүнд үйлчилж буй албан хаагч 10 минутыг зарцуулдаг байсан бол цахимаар өөрийн хүссэн газраасаа хандаж ердөө 2-3 минутын дотор үйлчилгээгээ авах боломжтой боллоо.

Цахим системд 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаанд 4532983 хандалт бүртгэгдсэн байна. Мөн гар утасны “Egazar” аппликэйшнийг Андроид болон IOS платформ дээр хэрэглээнд гаргасан өдрөөс хойш нийт 70474 хэрэглэгч хандаж мэдээ, мэдээлэл, үйлчилгээ авсан байна.

Газар эзэмших, ашиглах эрх, Улсын бүртгэлийн дугаар олгох үйл ажиллагааг автоматжуулав.

Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмших, ашиглах эрх олгож, улсын бүртгэлийн Э болон А дугаар олгох үйл ажиллагааг цахимжуулан (www.egazar.gov.mn) тухайн дугаарууд нь 1 секундын дотор олгогддог болсон. Үүний үр дүнд иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээ түргэн шуурхай болж, 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хойш нийт **19043** Э болон А дугаар автоматаар олгогдсон байна.

7	10: Улсын Бүртгэл руу илгээсэн	Өргөдлийг амжилттай УБЕГ руу илгээлээ	2022-02-11 09:11:17
8	11: Улсын Бүртгэл зөвшөөрч дугаар олгосон	УБЕГ зөвшөөрч дугаар олгосон	2022-02-11 09:11:17

Зураг 1.1.3.2: Улсын бүртгэлийн ерөнхий газарт Э дугаарын хүсэлт илгээж олгогдсон байдал /хугацаа 1 секунд/

Газартай холбоотой өргөдөл хүсэлтийг цахимаар илгээх боломжтой болсон.

Иргэн, хуулийн этгээд газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэх, эзэмшиж буй газраа өмчлөх, барьцаанд бүртгүүлэх, чөлөөлөх, зориулалт өөрчлөх, талбайн хэмжээ өөрчлөх, хэсэгчлэн шилжүүлэх зэрэг нийт **13** хүсэлтийг Газрын цахим систем болон гар утасны аппликейшныг ашиглан цахимаар илгээх боломжтой болсон.


Та Тухайн Газар Дээр Өгөх Хүсэлтийн Төрлөө Сонгоно Уу!

#	Хүсэлтийн төрөл	
1	7: Газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх	Хүсэлт өгөх
2	8: Газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаанд бүртгүүлэх, чөлөөлөх	Хүсэлт өгөх
3	9: Эзэмшиж ашиглаж буй газрын зориулалт өөрчлөх	Хүсэлт өгөх
4	10: Газар ашиглах, эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах	Хүсэлт өгөх
5	12: Газар эзэмших ашиглах эрхийн гэрчилгээ нөхөн авах	Хүсэлт өгөх
6	13: Эзэмшиж ашиглаж буй газрын талбайн хэмжээ өөрчлөх	Хүсэлт өгөх
7	23: Эзэмшил газраа хэсэгчлэн шилжүүлэх	Хүсэлт өгөх
8	28: Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх дуусгавар болгох	Хүсэлт өгөх
9	30: Эзэмшиж буй газраа өмчлөх	Хүсэлт өгөх
10	35: Газар эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн дугаар авах	Хүсэлт өгөх
11	36: Газрын кадастрын мэдээллийн санд барилга, хаяг дугаар бүртгүүлэх	Хүсэлт өгөх

Зураг 1.1.3.3: Цахимаар хүсэлт илгээх төрөл/

Газрын гэрээ, гэрчилгээ, кадастрын зургийг иргэд цахимаар хэвлэж авах боломжтой болов.


Иргэн, хуулийн этгээдийн газрын гэрээ, гэрчилгээ, кадастрын зураг баталгаажуулахад нийт 10 гарын үсэг зурагддаг байсан бөгөөд сардаа нийт 8000 гаруй гарын үсэг зуруулах шаардлага үүсдэг байсан. Үүнээс шалтгаалж нэг иргэний баримт бичгийг баталгаажуулах хугацаа 30-60 хоног шаарддаг байв. Харин одоо иргэн, хуулийн этгээд газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ, кадастрын зураг, гэрээг QR кодоор баталгаажуулан цахимаар 1 минутад үнэгүй авах боломж бүрдсэн бөгөөд нийт **28980** удаа цахимаар үйлчилгээ үзүүлж, иргэн, хуулийн этгээдийн **600** сая гаруй төгрөгийг хэмнэсэн байна.



Зураг 1.1.3.4: Цахимаар гэрээ хэвлэгдсэн байдал

Egazar.gov.mn системийн хөгжүүлэлтийг тогтмол хийж, иргэд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулав.

Цахим системээс газрын гэрээ, гэрчилгээ, кадастрын зураг хэвлэх боломжийг бүрдүүлснээр өнөөдрийг хүртэлх хугацаанд 2700000 иргэн, сард 750000 иргэн, өдөрт 7551 иргэн уг системээр үйлчлүүлж байна.



Зураг 1.1.3.5: Цахимаар гэрчилгээ, кадастрын зураг хэвлэгдсэн байдал

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам” шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн газар эзэмших, ашиглах эрхтэй холбоотой өргөдөл, хүсэлтийг www.egazar.gov.mn цахим системээс хүлээн авч бүртгэн, шийдвэрлэн ажиллаж байна.

Мөн иргэн, хуулийн этгээд дээрх цахим хаягаас газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ, газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ, кадастрын зургийг нууцлал бүхий

кодоор баталгаажуулан авах боломжтой болсон бөгөөд 2021 оны 12 дугаар сарын байдлаар нийт 2700000 иргэн, сард 750000 иргэн, өдөрт 7551 иргэн уг системээр дамжуулан үйлчилгээ авсан байна.



Зураг 1.1.3.6: Цахим системээр дамжуулан үйлчилгээ үзүүлснээр хэмнэгдсэн зардал.

Мэдээллийг ил тод болгож, хуулийн этгээдийн нэрийг нээлттэй байршуулав.

Egazar.gov.mn цахим системд бүртгэлтэй газар эзэмших, ашиглах эрхийн мэдээллийг нийтэд нээлттэй харах, шалгах боломжийг бүрдүүлсэн бөгөөд газар эзэмшиж, ашиглаж буй төрийн байгууллага болон хуулийн этгээдийн нэрийг нээлттэй байршуулав.




Зураг 1.1.3.7: Эзэмших, ашиглах эрхийн мэдээлэл

Газрын цахим системийг төрийн үйлчилгээний цахим систем /e-mongolia/-д холбож, лавлагаа мэдээллийг цахимжуулав.




Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй холбоотой лавлагаа, үйлчилгээ, хүсэлт гэсэн нийт 42 үйлчилгээг “Хур” системд холбож, төрийн үйлчилгээний цахим систем /e-mongolia/-аас авах боломжтойгоор байршуулсан.

Мөн нууцлал бүхий кодтой тухайн мэдээллийг холбосноор эрхийн шилжилт хөдөлгөөний түүхчилсэн мэдээллийн лавлагааг цахимаар авах боломж бүрдсэн.



Зураг 1.1.3.8: E-Mongolia.mn-ээс гарч буй үйлчилгээний жагсаалт


*“Хаягийн нэгдсэн систем”-ийг хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болов.*



Зураг 1.1.3.9: Хаягийн нэгдсэн систем

Хаягийн нэгдсэн системийг олон улсын жишгийн дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд гудамж, зам, талбайн нэршил, гудамжны эхлэл төгсгөл, орц гарцад үндэслэн хот суурин газрын 50530 гудамжтай холбогдсон 1079711 нэгж талбар, 689888 барилгад шинээр хаягийг автоматаар олгоод байна.

Мөн Монгол Улсын хэмжээний 1:100000 масштабтай газар усны нэрийн тоон зургийн 258,650 газар, усны нэрийг ашиглан улсын хэмжээнд 181,027 өвөлжөө, хаваржаа, газар тариалангийн газрын нэгж талбарт шинээр хаяг олгоод байна.




Зураг 1.1.3.10: 1:100000 масштабтай байр зүйн зурагт суурилан хаяг олгосон байдал

### Газрын нэгдмэл сангийн цахим систем

“Төрийн өмчийн газрыг зурагжуулж бүртгэн Газрын кадастрын мэдээллийн санд оруулж баталгаажуулах” ажлын хүрээнд Газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэлгэрэнгүй ангиллуудын хил зааг, хэмжээ, байршлыг шинэчлэн тогтоож, зураглан Газрын нэгдмэл сангийн цахим системийг байгуулаад байна.

Уг цахим систем байгуулагдсанаар салбар хоорондын уялдааг хангах, газрын нэгдмэл сангийн тайланг тайлагнах, газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал өөрчлөх үйл ажиллагаа бүрэн цахим хэлбэрт шилжиж, иргэд, олон нийтэд нээлттэй мэдээллээр хангах боломжтой болсон.



Зураг 1.1.3.11: Газрын нэгдмэл сангийн цахим систем

Мөн Газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг арилгах, төрийн өмчийн газрын газар ашиглалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, хамгаалах, хууль бус газар ашиглалтыг зогсоох, төрийн өмчийн газрыг зориулалтын дагуу ашиглаж буй байдалд хяналт тавих зорилгоор төрийн өмчийн хариуцагчтай гэрээ байгуулах ажлыг цахимжуулсан.

### Газрын үнэлгээний цахим систем


Газрын үнэлгээний цахим системийг 21 аймаг 330 сум, нийслэл, дүүргийн хэмжээнд бүрэн нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2021 онд инженерийн болон хүрээлэн буй орчны, нийгмийн дэд бүтцийн 14 газрын үнэд нөлөөлөх хүчин зүйлсийг оруулж, нийт 880505 нэгж талбарт үнэд нөлөөлөх хүчин зүйлсийн утга бодуулан дүн шинжилгээ хийсэн.

Газрын үнэлгээний мэдээллийн системд дараах үнэд нөлөөлөх хүчин зүйлсийн мэдээллийг шинэчлэн сервис үйлчилгээгээр авдаг болсон. Үүнд:

1. Орон зайн өгөгдлийн дэд бүтцээс:
  - Бохир усны шугам
  - Цэвэр усны шугам
  - Дулааны шугам
  - Авто зам
2. Кадастрын мэдээллийн сангаас:
  - Эмнэлэг
  - Сургууль
  - Цэцэрлэг
  - Төрийн үйлчилгээний байгууллага
  - Худалдааны төв
  - Ахуйн үйлчилгээний төв

Газрын үнэлгээний мэдээллийн системд дараах үнэд нөлөөлөх хүчин зүйлсийн мэдээллийг шинээр сервис үйлчилгээгээр авдаг болсон. Үүнд:

1. Орон зайн өгөгдлийн дэд бүтцээс:
  - Цахилгааны шугам
  - Нийтийн тээврийн буудал
  - Худаг



Зураг 1.1.3.12: Үнэлгээний системд бүртгэсэн нийгмийн дэд бүтцийн мэдээлэл

Газрын үнэлгээний цахим системийг ашиглан улсын хэмжээнд хот, тосгон, бусад суурин газрын нийт 21738 нэгж талбарт газрын зах зээлийн үнэлгээ хийж, үр дүнг ашиглан 880504 нэгж талбарт масс үнэлгээ бодуулж, газрын үнэлгээний бүсчлэл болон 1 га газрын суурь үнийг боловсруулсан.

Ойн сан бүхий газрын эдийн засгийн үнэлгээ хийх аргачлал боловсруулан газрын үнэлгээний системд оруулж 4 тойрог /муж/ 31 төрлөөр үнэлж ойн сан бүхий газрын эдийн засгийн үнийг тооцоолон гаргасан.

Усны сан бүхий газрын чанарын болон эдийн засгийн үнэлгээ хийх аргачлалыг боловсруулан газрын үнэлгээний системд оруулсан бөгөөд 29 тойргоор усны сан бүхий газрын эдийн засгийн үнэлгээг боловсруулсан.

Харин хөдөө аж ахуйн газрын тариалангийн газрын үнэлгээг боловсруулахаар 482 нэгж талбарын чанарын оноог тооцож, 1179 нэгж талбарыг масс үнэлгээгээр үнэлж, тариалангийн газрыг 5 тойргоор газрын эдийн засгийн үнэлгээг тооцсон.

Хүснэгт 1.1.3.1: Үнэлгээний системийн мэдээлэл /аймаг, нийслэлээр/

Но.	Аймаг, Нийслэл	Зах зээлийн үнийн мэдээ	Нэгж талбарын үнийн мэдээ	Хот суурин газрын масс үнэлгээ	Нийгмийн дэд бүтцийн тоо
1	Улаанбаатар	4267	8042	291522	1981
2	Дорнод	1179	1171	47426	400

3	Сүхбаатар	214	349	11775	39
4	Хэнтий	226	246	27478	81
5	Төв	678	1566	56024	480
6	Говьсүмбэр	316	285	16899	29
7	Сэлэнгэ	186	278	53322	236
8	Дорноговь	380	783	36163	462
9	Дархан-Уул	434	876	28186	154
10	Өмнөговь	154	464	41322	222
11	Дундговь	375	332	25996	220
12	Орхон	877	1028	21976	165
13	Өвөрхангай	882	1258	32981	548
14	Булган	196	627	22602	843
15	Баянхонгор	601	1099	16506	1266
16	Архангай	131	162	23702	101
17	Хөвсгөл	124	149	31393	1086
18	Завхан	370	502	18410	196
19	Говь-Алтай	214	339	10921	240
20	Баян-Өлгий	1031	1310	30884	67
21	Ховд	190	226	17222	80
22	Увс	477	646	17795	1073
<b>Нийт</b>		<b>13502</b>	<b>21738</b>	<b>880505</b>	<b>9969</b>

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын “Газрын харилцааны цахим шилжилт, эрх зүйн шинэтгэлийг эрчимжүүлэх” нэрэмжит жилийн хүрээнд иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх зорилгоор Монголын нотариатчдын танхимтай “Мэдээлэл харилцан солилцох тухай гэрээ”-г байгуулан гэрээний дагуу хоёр байгууллагын дундын мэдээллийн санг байгуулж шаардлагатай мэдээллүүдийг тухай бүр солилцож, газар эзэмших эрхийн гэрчилгээ, кадастрын зураг, гэрээний баталгаажуулах кодтой холболтыг хийж хэрэглээнд нэвтрүүлсэн.

Ингэснээр газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийг нотариатын байгууллагаас дундын мэдээллийн сангаар дамжуулан шууд авч газрын үнэлгээний цахим системд ашиглах бүрэн боломжтой болсон.



Газрын кадастрын мэдээллийн сан




Нотариатчдын танхим

Зураг 1.1.3.13: Монголын нотариатчдын танхимтай байгуулсан дундын мэдээллийн сан

*Газрын биржийн цахим систем*

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр түргэн, шуурхай, ил тодоор зохион байгуулах, газрын барьцаа, түрээсийн бүртгэл хийх, газрын зах зээлийн үнийн мэдээ цуглуулж нэгдсэн мэдээллийн сан бий болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээ, статистик мэдээллээр иргэд, олон нийтэд үйлчлэх, зорилгоор Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг хэрэглээнд нэвтрүүлсэн.



*Зураг 1.1.3.14: Газрын биржийн цахим систем /www.mle.mn/*

Уг системийг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, 330 сумын газрын даамлууд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд тус систем нь Байгууллагын орон зайн өгөгдлийн дэд бүтэц, Газрын кадастрын нэгдсэн мэдээллийн сан, Газрын үнэлгээний мэдээллийн сан болон холбогдох бусад байгууллагын мэдээллийн сантай холбогдон ажиллах боломжийг бүрдүүлсэн.

Иргэд, хуулийн этгээд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтад байршил харгалзахгүй оролцож, олон шат дамжлагагүй, түргэн шуурхай үйлчилгээг авах боломжтой болсон.

Газрын биржийн цахим системд 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 8,848 газрын дуудлага худалдаа, 485 газрыг эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 53,835 газрын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг бүртгэж оруулсан.


Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааг танхимаар зохион байгуулж байх үед жилд дунджаар 4 тэрбум төгрөг улсын төсөвт ордог байсан бол Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг ашиглан дуудлага худалдааг цахимаар зохион байгуулдаг болсноор дуудлага худалдаанаас Улсын төсөвт орох

орлогын хэмжээ 3.6 хувиар нэмэгдэж, 2021 оны байдлаар дуудлага худалдааны орлого 14.7 тэрбум төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Мөн дуудлага худалдаанд оролцогчийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд Газрын биржийн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэхээс өмнөх үетэй харьцуулбал 4 дахин нэмэгдсэн байна.


Хүснэгт 1.1.3.2: Дуудлага худалдаа зохион байгуулсан тоо, оролцогч, орлогын хэмжээ /2016-2021 он/

Он	Зохион байгуулсан тоо	Үүнээс		Нийт оролцогч	Үүнээс		Нийт орлого	Үүнээс	
		Цахим	Танхим		Цахим	Танхим		Цахим	Танхим
2016	672	32	640	281	68	213	2.4	0.3	2.1
2017	583	118	465	494	204	290	4.3	2.1	2.2
2018	1,179	683	496	1,933	1,531	402	8.5	5.2	3.3
2019	1,801	1367	434	2,136	1,773	363	10.2	6.3	3.9
2020	2,282	1968	314	3,590	3,245	345	10.4	7.6	2.8
2021	2,360	2062	198	4,410	4,120	290	14.7	13.5	1.2



Зураг 1.1.3.15: 2009-2021 онд улсын хэмжээнд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын төсөвт орсон орлого /сая.төг/


Тус системээс иргэн, хуулийн этгээд газартай холбоотой бүх төрлийн мэдээ, мэдээллийг авч, өөрийн газар өмчлөх, эзэмших эрхээ дуудлага худалдаагаар бусдад шилжүүлэх болон худалдах, түрээслэх зар мэдээллээ уг системд оруулж бусдад арилжаалах боломжтой бөгөөд нийт 11699 иргэн, хуулийн этгээд үйлчилгээ авсан байна.



Зураг 1.1.3.16: Газрын биржийн цахим системийг ашиглан дуудлага худалдаа зохион байгуулсан байдал.

Газрын биржийн цахим системд 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 53835 газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээ бүртгэгдээд бөгөөд үүнээс тайлант онд 23235 үнийн мэдээг нэмж бүртгэсэн. Энэ нь өмнөх онтой харьцуулбал 4 дахин их газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг бүртгэсэн байна.


Бүртгэгдсэн газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээнээс гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 19773, худалдаа үйлчилгээний зориулалттай 1499, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай 1440, хөдөө аж ахуйн газраас бусад үйлдвэрлэлийн зориулалттай 523 үнийн мэдээ тус тус эзэлж байна.



Зураг 1.1.3.17: Газрын биржийн цахим системд газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ бүртгэсэн байдал.



Нийт бүртгэсэн үнийн мэдээний хамгийн их хувийг буюу 35 хувийг нийслэлд, 10 хувийг Дархан-Уул аймагт, 8 хувийг Өвөрхангай аймагт бүртгэгдсэн газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ эзэлж байна.



Зураг 1.1.3.18: Газрын биржийн цахим системд газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ бүртгэсэн байдал

Мөн Газрын биржийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, салбар хоорондын уялдаа, хяналтын тогтолцоог хангах үүрэг бүхий Газрын биржийн удирдах зөвлөлийн хурлыг 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Барилга, хот байгуулалтын яамны хурлын зааланд танхимаар зохион байгуулсан.

Газрын биржийн удирдах зөвлөлд Барилга, хот байгуулалтын яам, Сангийн яам, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монголын банкны холбоо, Монголын Нотариатчдын танхим, “Монголын үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын нэгдсэн холбоо” ТББ-ын холбогдох албан тушаалтнууд багтдаг бөгөөд зөвлөлийн гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож, Газрын цахим биржийг ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг цахимаар зохион байгуулах, улсын хэмжээнд ил тод нэгдсэн зохион байгуулалтад оруулах, төвлөрсөн мэдээллээр төр, олон нийтийг хангах талаар хэлэлцэж цаашид хийх ажлын төлөвлөгөөг баталсан.

Төлөвлөгөөний дагуу “Журмын хэрэгжилтийг хангах тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 44 дүгээр тушаал гарсан бөгөөд Чөлөөт бүсийн захирагчийн албад болон 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд чиглэл хүргүүлэн дуудлага худалдааны орлого болон дэнчинг төвлөрүүлэн зарцуулах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.

**1.1.4. Орон зайн мэдээлэл, технологийн чиглэлээр.**

Орон зайн суурь 18 өгөгдлийн техникийн үзүүлэлтийн стандарт

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хөгжиж буй орнуудын орон зайн мэдээллийн менежментийн чадавхийг бэхжүүлэх” (Strengthening geospatial information management in developing countries towards implementing the 2030 Agenda) төслийн хүрээнд НҮБ-ын Дэлхийн Орон зайн мэдээллийн менежментийн Зөвлөхүүдийн хорооноос баталсан дэлхийн хэмжээний тулгамдсан гол асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай орон зайн мэдээллийн бүрдүүлэлт, зохион байгуулалт, үр дүнтэй хэрэглээнд чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулахад шаардлагатай орон зайн 14 суурь мэдээллийн жагсаалтаас сэдэвлэж, өөрийн орны онцлогтой уялдуулан орон зайн 18 суурь өгөгдлийн хүрээг тодорхойлоод байна.

Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах цогц арга хэмжээний төлөвлөгөөний томоохон арга хэмжээнүүдийн нэг болох “Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх” ажлын хүрээнд байгууллагын суурь орон зайн 18 дэд сан бүрт зориулан өгөгдлийн үзүүлэлтийн /UML/ стандартыг боловсруулж, 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Монгол Улсын Шадар Сайдын ахалсан Газрын шинэтгэлийн Үндэсний хорооны 5 дугаар хуралдаанаар хэлэлцүүлсэн.Тус хуралдаанаас гарсан шуурхай үүрэг даалгаврын дагуу Газар зүйн мэдээллийн 18 нэр төрлийн стандартын төслүүдийг шуурхай горимоор хэлэлцүүлэх ажлыг хамтран амжилттай зохион байгуулж, Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн С/36 тушаалаар батлуулав.

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**  
2021 оны 07 сарын 09 өдөр Дугаар С/36 Улаанбаатар хот

Үндэсний стандарт шинээр батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9 дугаар зүйлийн 9.1, 9.3, 11 дугаар зүйлийн 11.3.1, 11.3.3, 11.3.4, 25 дугаар зүйлийн 25.3.2, СХЗГ-ын даргын 2020 оны А/267 дугаар тушаалаар батлагдсан Техникийн хорооны хурлын дэг, Газрын салбарын стандартчиллын техникийн хороо (ТХЗБ)-ны 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны нэгдэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хавсралтад дурдсан 18 багц стандартыг улсын хэмжээнд хэрэглэхээр хүлээн зөвшөөрч үндэсний стандартаар шинээр баталсугай.
2. Шинээр баталсан стандартыг улсын мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчинтэйд тооцсугай.
3. Баталсан стандартуудыг сурталчилах ажлыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт зөвлөмжөөрсугай.

ДАРГА Б.БИЛГҮҮН


023029743

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн С/36 дугаар тушаалын хавсралт

Шинээр баталсан стандартын жагсаалт

№	Стандартын нэр	Стандартын дугаар
1	Газар зүйн мэдээлэл, Геодезийн байнгын цэг тэмдэгтийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-1 : 2021
2	Газар зүйн мэдээлэл, Байр зүйн зургийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-2 : 2021
3	Газар зүйн мэдээлэл, Газар зүйн нэрийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-3 : 2021
4	Газар зүйн мэдээлэл, Газар ашиглалтын орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-4 : 2021
5	Газар зүйн мэдээлэл, Газрын бүрхэвчийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-5 : 2021
6	Газар зүйн мэдээлэл, Барилга байгууламжийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-6 : 2021
7	Газар зүйн мэдээлэл, Дэд бүтцийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-7 : 2021
8	Газар зүйн мэдээлэл, Сам тээврийн сүлжээний орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-8 : 2021
9	Газар зүйн мэдээлэл, Инокер-геологийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-9 : 2021
10	Газар зүйн мэдээлэл, Кадастрын нэгж талбарын орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-10 : 2021
11	Газар зүйн мэдээлэл, Орто-зураглалын орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-11 : 2021
12	Газар зүйн мэдээлэл, Өндрийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-12 : 2021
13	Газар зүйн мэдээлэл, Түүх, соёл, археологийн өв орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-13 : 2021
14	Газар зүйн мэдээлэл, Ус зүйн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-14 : 2021
15	Газар зүйн мэдээлэл, Хаягийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-15 : 2021
16	Газар зүйн мэдээлэл, Хил заагийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-16 : 2021
17	Газар зүйн мэдээлэл, Хөрсний орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-17 : 2021
18	Газар зүйн мэдээлэл, Хүн ам, нийгмийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-18 : 2021

Зураг 1.1.4.1: Стандарт баталсан тухай тушаал



Зураг 1.1.4.2: Орон зайн суурь 18 өгөгдөл

Стандартын зорилго нь байрлалд суурилсан орон зайн суурь өгөгдлийг нэгдсэн мэдээллийн системд оруулах, бүрдүүлэх, мэдээллийг тогтмол шинэчлэх, солилцох үйл ажиллагаанд баримтлах өгөгдлийн сангийн бүтэц, агуулга, техникийн үзүүлэлтийг бүрэн хэмжээнд тодорхойлох явдал юм. Энэхүү стандарт нь нэг талаас орон зайн өгөгдлийн санг хариуцагч байгууллага нөгөө талаас орон зайн өгөгдөл, мэдээлэлтэй хамаарал бүхий үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, хувь хэрэглэгч нарын хооронд үүсэх өгөгдөл бүрдүүлэх, боловсруулах, шинэчлэх, хадгалах, солилцох бүх харилцаанд үйлчилж нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгоход ашиглах үндсэн баримт бичиг болно.


Стандартыг баримталсны үр дүнд геопорталаар дамжуулан байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийн цахим үйлчилгээнүүдийг хэрэглээнд нэвтрүүлэх,

нэгдсэн мэдээллийг нэг эх үүсвэрээс ашиглах, үйл ажиллагааны суурь нөхцөлийг бүрдүүлэх, эрчимтэй хөгжих боломжийг олгож байна.

Энэхүү багц стандартын төсөл нь сэдэвчилсэн 18 нэр төрлийн орон зайн суурь өгөгдлийн үзүүлэлт бүхий стандартуудаас бүрдэнэ. Үүнд:

1. Газар зүйн мэдээлэл. Геодезийн байнгын цэг тэмдэгтийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-1 :2021
2. Газар зүйн мэдээлэл. Байр зүйн зургийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-2 :2021
3. Газар зүйн мэдээлэл. Газар зүйн нэрийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-3 :2021
4. Газар зүйн мэдээлэл. Газар ашиглалтын орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-4 :2021
5. Газар зүйн мэдээлэл. Газрын бүрхэвчийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-5 :2021
6. Газар зүйн мэдээлэл. Барилга байгууламжийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-6 :2021
7. Газар зүйн мэдээлэл. Дэд бүтцийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-7 :2021
8. Газар зүйн мэдээлэл. Зам тээврийн сүлжээний орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-8 :2021
9. Газар зүйн мэдээлэл. Инженер-геологийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-9 :2021
10. Газар зүйн мэдээлэл. Кадастрын нэгж талбарын орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-10 :2021
11. Газар зүйн мэдээлэл. Орто-зураглалын орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-11 :2021
12. Газар зүйн мэдээлэл. Өндрийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-12 :2021
13. Газар зүйн мэдээлэл. Түүх, соёл, археологийн өв орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-13 :2021
14. Газар зүйн мэдээлэл. Ус зүйн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-14 :2021
15. Газар зүйн мэдээлэл. Хаягийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-15 :2021
16. Газар зүйн мэдээлэл. Хил заагийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-16 :2021
17. Газар зүйн мэдээлэл. Хөрсний орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-17 :2021
18. Газар зүйн мэдээлэл. Хүн ам, нийгмийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-18 :2021

Стандартын техникийн үзүүлэлтүүдийг Европын холбооны хүрээлэн буй орчинд нөлөөлөх бодлого, үйл ажиллагааг зохицуулах Европын орон зайн мэдээллийн дэд бүтэц INSPIRE (Infrastructure for Spatial Information in Europe) системийн техникийн тодорхойлолт, олон улсын стандартын байгууллага (ISO)-ын TX 211 (ISO/TC 211-Geographic information/Geomatics)-с гаргасан ISO 19100 цуврал стандартуудын үзүүлэлт, шаардлагад тулгуурлаж, Монгол Улсад мөрдөж буй стандарт, норм, дүрэм, журам, орон зайн суурь өгөгдлийн бүтэц, агуулга, ангиллыг үндэслэж, Загварчлалын Нэгдмэл Хэл (UML-Unified Modeling Language) -ийн дагуу нийцүүлэн боловсруулав.



Зураг 1.1.4.3: Стандартын агуулга


Ухаалаг төхөөрөмж, орчин үеийн технологид суурилсан орон зайн өгөгдлийн цогц платформыг дэмжих стандарт, эрх зүйн орчныг бүрдүүлснээр үндэсний хэмжээний бүтээн байгуулалт, оновчтой хөрөнгө оруулалт, орон зайн өгөгдөл, мэдээлэлд суурилсан бизнес, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглээнд нэвтрүүлэх, эдийн засгийг тэлэх бүрэн боломжтой.

Орон зайн 18 суурь өгөгдлийн техникийн үзүүлэлтийн стандарттай <https://estandard.gov.mn/> холбоосоор нэвтэрч, танилцана уу.

Үндэсний орон зайн өгөгдлийн геопортал систем

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050”, Монгол улсын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссаны дагуу орон зайн өгөгдөл, мэдээллийг


бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих, орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч, хэрэглэгчдийн хамтын ажиллагааг зохицуулах, байрлалд суурилсан төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, орон зайн өгөгдөл, мэдээллийн цахим үйлчилгээнүүдийг төрийн байгууллагуудын хэрэглээнд нэвтрүүлж үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлэх, төсвийн үргүй зардал, давхардсан хөрөнгө оруулалтыг арилгах зорилгоор Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн **ГЕОПОРТАЛ** системийг хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болсон.



Зураг 1.1.4.4: Геопортал систем /www.nsd.gov.mn/

Геопорталын цахим систем хэрэглээнд орсноор иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын бизнесийн үйл ажиллагаанд таатай нөлөө үзүүлж, боломж нөхцөлийг нэмэгдүүлэх төдийгүй төрийн бодлого, шийдвэрийг нэгдсэн байдлаар зөв зүйтэй төлөвлөх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж улсын эдийн засаг, инновацыг хөгжүүлэх, дэмжихэд чухал нөлөө үзүүлж, нийгмийн хөгжилд томоохон түлхэц үзүүлэх чухал ач холбогдолтой.

Салбарын хэмжээнд бүрдүүлж буй орон зайн өгөгдөл, мэдээллийг Стандартчлал, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 сарын 09-ний өдрийн С/36 тушаалаар батлагдсан MNS 6925-1-18:2021 18 өгөгдлийн үзүүлэлтийн дагуу улсын хэмжээний байр зүйн болон газрын дээрх, доорх инженерийн дэд бүтцийн мэдээлэл, инженер, геологи, газар хөдлөлт, геоморфологи, өндрийн тоон загвар, хиймэл дагуулын зураг, газар зүйн нэр, газрын бүрхэвч, газар ашиглалт, зам тээвэр, ус зүйн сүлжээ зэрэг 620 GB вектор өгөгдөл, 30 TB растер өгөгдлийн мэдээллийг боловсруулан оруулсан.




Зураг 1.1.4.5: Дэд бүтцийн дэд сангийн интерактив газрын зургийн харагдах байдал

Цахим системд иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын гэсэн үндсэн 3 төрлөөр хандах боломжтой бөгөөд өөрт хэрэгцээтэй мэдээллийг харах, нээлттэй мэдээллээр иргэд, олон нийтэд үйлчлэх, засаг захиргааны нэгжийн хил, нэрэлбэр, байрлал болон төрөл бүрийн ангиллаар хайлт хийж, худалдан авах боломжтой. Тус цахим систем нь төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем, танилт нэвтрэлтийн “ДАН” систем болон цахим төлбөр тооцооны QPAY системд холбогдсон.

Геопортал цахим систем нь Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор улсын хэмжээнд хэрэглээнд нэвтэрсэн Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системтэй орон зайн өгөгдөл мэдээллийг мэдээллийн сан болон сервисээр тухай бүр солилцож нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна.

Геопортал цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангах, байгууллагын дата төвийн дэд бүтэц /сүлжээ, техник хангамж, тоног төхөөрөмж/-ийн чадавхыг сайжруулах ажлын хүрээнд газар зүйн мэдээллийн систем болон өгөгдлийн санг удирдах сервер тоног төхөөрөмж 4 ширхэг, файл хадгалах төхөөрөмж 1 ширхэгийг тус тус суурилуулсан. Мөн байгууллагын болон орон нутгийн албан хаагчдад орон зайн өгөгдөл, мэдээллийг шинэчлэх, засварлах, цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 72 ширхэг суурин компьютер, 22 ширхэг зөөврийн компьютерыг хүлээлгэн өгөв.




Зураг 1.1.4.6: Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтэц

Улсын их хурлын 2021 оны 106 тогтоолоор баталсан Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.2-д “Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч бусад байгууллагын санг нэгдсэн стандартад шилжүүлэх, геопорталаар дамжуулан төрийн бодлого төлөвлөлт, шийдвэр гаргалтын “Нэг газрын зураг”, иргэд, олон нийт, бизнесийн зориулалттай “Нээлттэй газрын зураг” цахим үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлэх” зорилтын хүрээнд хийгдэх платформыг орон зайн өгөгдлийн 18 дэд сангийн мэдээлэлд суурилж хөгжүүлэх юм.

**1.1.5. Хот байгуулалтын кадастрын чиглэлээр.**

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь Хот байгуулалтын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Улсын хот байгуулалтын кадастр”-ыг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцан явуулахаар заасан чиг үүргийн дагуу Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/-ийг Газрын даргын 2020 оны А/137 дугаар тушаалаар 21 аймгийн хэмжээнд нэвтрүүлсэн. 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байна.





Зураг 1.1.5.1: Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/

Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/-ийг шинэчлэн хөгжүүлэх, мэдээллийн санг өргөтгөх чиглэлээр 2021 онд дараах ажлуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн 12 давхаргын 26653 мэдээллийг нээлттэй эх үүсвэрийн программд хөрвүүлэн нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газраас ирүүлсэн 164 давхаргын 570510 мэдээлэл болон Үндэсний статистикийн хорооны 2019 онд хийж гүйцэтгэсэн байшин, орон сууцны тооллогын үр дүнгийн 3 давхаргын 441344 мэдээллийг нэмж мэдээллийн санг өргөтгөсөн.
2. Программ хангамжийн хөгжүүлэлттэй холбоотойгоор хот тохижилтын бүртгэлийн 2 модуль, нийгмийн дэд бүтцийн бүртгэлийн 1 модуль, инженерийн дэд бүтцийн бүртгэлийн 10 модуль тус тус шинээр хөгжүүлж мэдээлэл бүртгэх боломжтой болсон.
3. Барилгын ажлын зөвшөөрлийн үе шатыг цахимжуулах чиглэлээр иргэн, хуулийн этгээд ДАН системээр нэвтэрч хүсэлт гаргах, газартай холбоотой мэдээллийг татаж шалгах, ерөнхий төлөвлөгөөний бүсчлэлтэй давхцуулан шалгах, архитектур төлөвлөлтийн даалгаврыг цахим хэлбэрээр авах нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд шинээр техникийн нөхцөл, зураг төсөл магадлал, захиалагчийн хяналтын явцуудыг нэмж хөгжүүлсэн.
4. Хот байгуулалтын кадастрын цахим системийг Газрын кадастрын мэдээллийн систем, Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем, Хаягийн мэдээллийн нэгдсэн систем, Орон зайн өгөгдлийн дэд бүтэцтэй холбох ажлуудыг хийсэн.

Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/ дээр хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламж, хот тохижилт, ногоон байгууламж, нийгмийн дэд бүтэц, инженерийн дэд бүтэцтэй холбоотой болон бусад мэдээллүүдийг олон нийтэд нээлттэй гаргасан.

Энэхүү ажлын үр дүнд Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/-ийг улсын хэмжээнд нэвтрүүлэх боломж бүрдлээ. Танилт нэвтрэлтийн ДАН систем, Газрын кадастрын мэдээллийн системтэй холбосноор барилга байгууламж барих хүсэлтэй иргэн, хуулийн этгээд 1 материалаа 8 удаа хувилж байгууллагуудад өгөх шаардлагагүй болсон.

*Инженерийн шугам сүлжээ*


Хот байгуулалтын кадастрын цахим системд 2021 оны байдлаар 21 аймгийн төвийн сумын хэмжээнд нийт 3924 байршилд 432873 м урт ус хангамжийн шугам сүлжээ, 3971 байршилд 263863.59 м урт дулаан хангамжийн шугам сүлжээ, 5753 байршилд 264675.71 м урт ариутгах татуургын шугам сүлжээний мэдээлэл бүртгэгдсэн байна.

*Хүснэгт 1.1.5.1: Цахим системд бүртгэгдсэн инженерийн шугам сүлжээний мэдээлэл*

№	Аймгийн нэр	Инженерийн шугам сүлжээ /м/		
		Дулаан хангамжийн шугам	Ариутгах татуургын шугам	Ус хангамжийн шугам
1	Архангай	5024	12757	23490
2	Баян-Өлгий	20450	17637	35404
3	Баянхонгор	20686.6	22708.71	-
4	Булган	15032	14549	5809
5	Говь-Алтай	4458	5936	15356
6	Говьсүмбэр	9546	10398	23350
7	Дархан-Уул	10112	36222	25678
8	Дорноговь	19586	-	41764
9	Дорнод	7000	12006	11600
10	Дундговь	15730	25303	61773
11	Завхан	8133	7037	8425
12	Орхон	13843	31973	24652
13	Өвөрхангай	3398	22	24873
14	Өмнөговь	40365	22170	48124
15	Сүхбаатар	-	-	-
16	Сэлэнгэ	34842	19210	19116
17	Төв	223	3753	20600
18	Увс	4322	20	-
19	Ховд	5379	10007	11417
20	Хөвсгөл	10319	1631	5127
21	Хэнтий	15415	11336	26315
<b>Дүн</b>		<b>263863.6</b>	<b>264675.7</b>	<b>432873</b>

Барилга байгууламж

Хот байгуулалтын кадастрын цахим системд 21 аймгийн төвийн сумын хэмжээнд 2021 оны байдлаар нийт 7947 барилгын мэдээлэл бүртгэгдсэн байна.



Зураг 1.1.5.2: Цахим системд бүртгэгдсэн барилга байгууламжийн мэдээлэл

Тохижилт, ногоон байгууламж

Бүх аймгийн төвийн сумын хэмжээнд нийт 640 байршилд 2998722.23 м<sup>2</sup> /287.82 га/ талбайн ногоон байгууламжийн мэдээлэл бүртгэгдсэн байна.


Цахим системд бүртгэгдсэн ногоон байгууламжийг төрлөөр авч үзвэл нийт ногоон байгууламжийн 91 хувь буюу 493 байршилд 2734571 м<sup>2</sup> талбайг нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, 6 хувь буюу 115 байршилд 176 161 м<sup>2</sup> талбайг хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламж, үлдсэн 3 хувь буюу 32 байршилд 87991 га талбайг тусгай зориулалтын ногоон байгууламж эзэлж байна.

Хүснэгт 1.1.5.2: Цахим системд бүртгэгдсэн ногоон байгууламжийн мэдээлэл

№	Аймгийн нэр	Ногоон байгууламж /м <sup>2</sup> /			
		Нийт	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж	Хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламж	Тусгай зориулалтын ногоон байгууламж
1	Архангай	131456.8	73040	58416.8	-
2	Баян-Өлгий	15948	1299	14649	-
3	Баянхонгор	378651.95	374839	3812.95	-
4	Булган	72800.9	62480.9	10320	-
5	Говь-Алтай	1384	1298.5	85.5	-
6	Говьсүмбэр	325524	325518	6	-
7	Дархан-Уул	626804.6	607114	19691	-
8	Дорноговь	71224	3221	11417	56586
9	Дорнод	67600	67600	-	-

10	Дундговь	479745	460190	-	19555
11	Завхан	18943	18943	-	-
12	Орхон	120500	120500	-	-
13	Өвөрхангай	40566	27704	1012	11850
14	Өмнөговь	101361	81336	20025	-
15	Сүхбаатар	69690	67600	2090	-
16	Сэлэнгэ	3852.53	3852.53	-	-
17	Төв	258711.95	252118	6593.85	-
18	Увс	0	-	-	-
19	Ховд	36398	36398	-	-
20	Хөвсгөл	0	-	-	-
21	Хэнтий	177560.5	149519	28041.5	-
<b>Дүн</b>		<b>2998722.23</b>	<b>2734571</b>	<b>176161</b>	<b>87991</b>

Бүх аймгийн төвийн сумын цахим системд бүртгэгдсэн мэдээллээс харахад нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ дунджаар 0.2-30 м<sup>2</sup> байна.



Зураг 1.1.5.3: Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ

Тохижилт

Хүснэгт 1.1.5.3: Цахим системд бүртгэгдсэн тохижилтын мэдээлэл

№	Аймгийн нэр	Тохижилт					
		Явган хүний зам /м/	Дугуйн зам /м/	Гудамж, талбайн гэрэлтүүлэг /м/	Дурсгалын хөшөө, баримал /ш/	Усан оргилуур /ш/	Авто зогсоол /м <sup>2</sup> /
1	Архангай	14449	2624	1500	5	3	17837.4

2	Баян-Өлгий	-	-	1700	-	2	-
3	Баянхонгор	13380.6	1221	11064	7	4	8380.4
4	Булган	2924.3	-	24935	13	2	40673
5	Говь-Алтай	8006.4	-	-	11	-	-
6	Говьсүмбэр	7205.1	1816.5	2782	6	5	21924
7	Дархан-Уул	6672	-	19524	-	4	-
8	Дорноговь	13945	9723	21746	7	2	51417
9	Дорнод	543	-	3130	18	-	1677
10	Дундговь	-	-	9500	9	2	12430
11	Завхан	-	-	-	3	-	-
12	Орхон	13061	4218	15847	16	3	4722
13	Өвөрхангай	80687	126592	16866	50	1	23950
14	Өмнөговь	110000	-	5042	23	3	-
15	Сүхбаатар	0	-	20835	24	-	-
16	Сэлэнгэ	883	2830	-	3	1	-
17	Төв	-	-	517	3	2	-
18	Увс	-	-	-	-	-	-
19	Ховд	9735	7370	-	11	2	5810
20	Хөвсгөл	-	-	-	-	-	-
21	Хэнтий	24116.7	1360	24937.1	55	10	5744.35
<b>Дүн</b>		<b>305608.1</b>	<b>157754.5</b>	<b>179925</b>	<b>264</b>	<b>46</b>	<b>194565</b>

Бүх аймгийн төвийн сумын хэмжээнд нийт 344 байршилд 305 608.1 м урт явган хүний зам, талбай, 125 байршилд 157754.5 м урт дугуйн замын мэдээлэл бүртгэгдсэн байна. Норм дүрэмд явган хүний хөдөлгөөн 50 хүн/цагаас бага байвал хоёр талын явган хүний замын зорчих зурвасыг 1м өргөнтэй төлөвлөж болно гэж заасан байдаг /БНБД 30.01.04/. Бүртгэгдсэн мэдээллээс харахад явган хүний замын өргөн дунджаар 1-2 м, дугуйн замын өргөн 0.5-2.5 м байна.

Бүх аймгийн төвийн сумын хэмжээнд 221 байршилд 194565.2 м<sup>2</sup> /19.45 га/ талбайн авто зогсоол, 352 байршилд 179925 м урт гудамж, талбайн гэрэлтүүлэг, 264 дурсгалын хөшөө, баримал, 46 усан оргилуурын мэдээлэл бүртгэгдсэн байна.

Хот байгуулалтын кадастрын цахим системийг ашиглан хот суурины тохижилт, ногоон байгууламжийн эрэлт, хэрэгцээ, норм ба дүрмийн харьцуулсан судалгаа хийх, тохижилт, ногоон байгууламжийн хомсдол бүхий байршлыг тодорхойлох, шинээр бий болгох боломжтой болон орчин нөхцөлийг сайжруулах газрын байршил, хэмжээг тогтоох бүрэн боломжтой. Мөн хот, суурины тохижилт, ногоон байгууламжид шаардлагатай хөрөнгийн урьдчилсан тооцоог гаргах, орчин нөхцөлийг сайжруулах, төлөвлөх, түүнийг хэрэгжүүлэх үе шатны төсөл, хөтөлбөр боловсруулахад суурь мэдээлэл болно.

### Нийгмийн дэд бүтэц


Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, нэгдсэн эмнэлгийн барилгын хүртээмжийн судалгаа

#### Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга

Хот байгуулалтын кадастрын цахим системд 2021 оны байдлаар 21 аймгийн төвийн сумын хэмжээнд зориулалтын дагуу ашиглагдаж буй нийт 242 сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 261 барилгын мэдээлэл бүртгэгдсэн байна.

Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30.01.04/-ийн хүчин чадал, ашиглалтын хувиар тооцвол 21 аймгийн төвийн сумын дунджаар сургуулийн өмнөх боловсролын байгууллага 65.71 хувийн хүртээмжтэй байна.

Аймгийн төвийн сумын сургуулийн өмнөх боловсролын байгууллагын зориулалттай барилгын хүчин чадал ба ачааллын ялгавар, Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хүчин чадлаар нь авч үзвэл:




Зураг 1.1.5.4: Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүртээмжийн судалгаа

Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30.01.04/-д сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын хүчин чадал нь 1000 хүнд 90 хүүхэд байхаар тооцдог. Тухайн сумын 2019-2020 оны хичээлийн жилд цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо, ашиглагдаж буй барилга байгууламжийн төслийн хүчин чадлын ялгаврыг графикт харуулсан. Жишээ нь: Орхон аймгийн Баян-Өндөр суманд 5389 хүүхэд, Хөвсгөл аймгийн Мөрөн суманд 2462 хүүхэд гарч байгаа нь ийм тооны хүүхдийн хүчин чадал бүхий цэцэрлэг шаардлагатай байгааг илтгэж байна.

#### Ерөнхий боловсролын сургуулийн барилга

Хот байгуулалтын кадастрын цахим системд 2021 оны байдлаар 21 аймгийн төвийн сумын хэмжээнд зориулалтын дагуу ашиглагдаж буй нийт 129 ерөнхий боловсролын сургуулийн 168 барилгын мэдээлэл бүртгэгдсэн байна.

Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30.01.04/-ийн хүчин чадал, ашиглалтын хувиар тооцвол 21 аймгийн төвийн сумын дунджаар ерөнхий боловсролын сургууль 79.30 хувийн хүртээмжтэй байна.




Зураг 1.1.5.5: Ерөнхий боловсролын сургуулийн хүртээмжийн судалгаа

Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30.01.04/-д ерөнхий боловсролын сургууль 1000 хүнд 210 сурагч байхаар тооцдог. Тухайн сумын 2019-2020 оны хичээлийн жилд сургуульд хамрагдсан хүүхдийн тоо, ашиглагдаж буй барилга байгууламжийн төслийн хүчин чадлын ялгаврыг графикт харуулсан. Жишээ нь: Орхон аймгийн Баян-Өндөр суманд 8566 сурагч, Дархан-Уул аймгийн Дархан суманд 8265 сурагч гарч байгаа нь ийм тооны сурагчийн сургуулийн хичээлийн байр шаардлагатай байгааг илэрхийлнэ. Мөн хангамжийн төвшин, хөрөнгө оруулалтын дүнг графикаас харахад Өмнөговь аймгийн Даланзадгад сум хамгийн өндөр буюу 102 хувийг эзэлж байгаа хэдий ч 1049 сурагчийн сургуулийн хичээлийн байрын хэрэгцээ, шаардлагатай байгаа нь тухайн орон нутгийн нийт хүн амд тооцооны нормоос давсан сурагчийн ачаалал байгааг харуулж байна.

Нэгдсэн эмнэлгийн барилга

Хот байгуулалтын кадастрын цахим системд 2021 оны байдлаар 21 аймгийн төвийн сумын хэмжээнд зориулалтын дагуу ашиглагдаж буй нийт нэгдсэн эмнэлгийн 50 барилгын мэдээлэл бүртгэгдсэн байна.

Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30.01.04/-ийн хүчин чадал, ашиглалтын хувиар тооцвол 21 аймгийн төвийн сумын дунджаар нэгдсэн эмнэлэг 43.76 хувийн хүртээмжтэй байна.



Зураг 1.1.5.6: Нэгдсэн эмнэлгийн хүртээмжийн судалгаа

Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30.01.04/-д нэгдсэн эмнэлэг 1000 хүнд 8 ор байхаар тооцдог. Аймгийн нэгдсэн эмнэлгийн шатлалаар үйлчлэх хүрээг сумын хүн амаар бус аймгийн нийт хүн амаар тооцсон болно. Жишээ нь: Хөвсгөл аймаг нийт 134318 хүн амтай, нэгдсэн эмнэлгийн ашиглагдаж буй барилгын анхны хүчин чадал 250 ор байна. Төлөвлөлтийн нормоор тус аймгийн нэгдсэн эмнэлэг 1074 орны хүчин чадалтай байх ёстой 824 орны дутагдалтай дүн гарч байна.

Хот байгуулалтын кадастрын цахим системийн барилга барих хүсэлт

Хот байгуулалтын кадастрын цахим системээр иргэн, хуулийн этгээд барилга барих хүсэлт гаргахаас эхлээд архитектур төлөвлөлтийн даалгавар, барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гаргах зэрэг шат дараалсан үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн.

Хүсэлтийн дэлгэрэнгүй мэдээлэл

← ӨМНӨХ      ДАРААХ →      ХАДГАЛАХ

Дугаар: 1107210003

Илгээсэн огноо: 2021-11-12

Нэгж талбарын дугаар: 1681910210

Газар олгогч: Дүүргийн Засаг даргын захирамж

Хүсэлтийн Төлөв: **Улсын комиссын акт батлагдсан**

1234567891011121314

Хүсэлт илгээх    Архитектур төлөвлөлтийн даалгавар    Эх загвар зураг    Техникийн нөхцөл    Ажлын зураг    Тэг тэнхлэг    Зураг төсөв магадлан    **Барилгын ажлын зөвшөөрөл**    Захиалагчийн гүйцэтгэлийн техникийн хяналт    Барилгын мэдээлэл    Улсын комисс    Хаяг    ББА гэрчилгээ

Түлхүүр үг	Утга
Барилгын ажлын зөвшөөрлийн дугаар	
1. Барилга байгууламжийн байршлын талаарх мэдээлэл	
2. Газрын эрхийн бүртгэлийн мэдээлэл	
3. Барилгын ажлын зөвшөөрлийн хүчинтэй хугацаа	

Зураг 1.1.5.7: Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/-ийн хүсэлтийн дэлгэрэнгүй мэдээллийн хэсэг



21 аймгийн хэмжээнд 2021 оны байдлаар 1091 барилга байгууламж барих хүсэлтийг цахим системээр хүлээж авснаас 6 барилгын ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарсан байна.

Хүснэгт 1.1.5.4: Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/-ээр хүлээн авсан хүсэлтийг шийдвэрлэсэн байдал


Д/д	Аймаг	Эдэлбэр газрын мэдээлэл	Архитектур төлөвлөлтийн даалгвар	Эх загвар зураг	Тэг тэнхлэг	БЭЗ	Гүйцэтгэлийн зураг	Барилгын мэдээлэл	Улсын комиссын акт
1	Архангай	20	10	2	0	9			
2	Баян-Өлгий	8	31	0	2	28			
3	Баянхонгор	21	33	6	1	13			
4	Булган	16	14	0	0	10			
5	Говь-Алтай	8	1	0	0	0			1
6	Говьсүмбэр	6	7	0	0	1			
7	Дархан-Уул	19	32	1	1	23			
8	Дорноговь	4	18	1	2	9			
9	Дорнод	23	31	0	0	23			
10	Дундговь	27	16	2	0	4			1
11	Завхан	3	3	1	0	2			
12	Орхон	52	41	7	0	9			
13	Өвөрхангай	26	19	4	1	41			
14	Өмнөговь	22	27	4	0	2			
15	Сүхбаатар	5	5	0	0	11			
16	Сэлэнгэ	18	3	1	0	8			
17	Төв	31	27	3	1	4			
18	Увс	10	9	18	1	15			
19	Ховд	6	0	2	4	30	1		3
20	Хөвсгөл	36	39	2	0	2			
21	Хэнтий	14	32	2	0	8			1



Зураг 1.1.5.8: Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/-ээр хүлээн авсан хүсэлтийг шийдвэрлэсэн байдал


## 1.2. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН СУДАЛГАА

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь Барилга, хот байгуулалтын Сайдын “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр шинэчлэн батлах тухай” 2019 оны 22 дугаар тушаалаар баталсан стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт заасны дагуу агентлагт 10 нэгж, нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймагт Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумдад Газрын даамал гэсэн бүтэцтэйгээр ажиллаж байна /Зураг 1.2.1/.



Зураг 1.2.1 Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын бүтэц

Газрын харилцааны салбарт Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт 86, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албанд 223, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 400, сумдад Газрын даамал 362, нийт 1071 албан хаагч ажиллаж байна /Зураг 1.2.2/.




Зураг 1.2.2: Улсын хэмжээнд газрын салбарт ажиллаж байгаа албан хаагчдын тоо

Газрын харилцааны салбарын хэмжээнд агентлаг, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /сумдын газрын даамал/, нийслэл, дүүргийн Газар


зохион байгуулалтын албанд ажиллаж буй төрийн албан хаагчдын дэлгэрэнгүй мэдээлэл, судалгааг дараах үзүүлэлтүүдээр гаргасан болно.

*Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын хүний нөөцийн судалгаа*


Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт ажиллаж буй албан хаагчдыг насны үзүүлэлтээр ангилж үзэхэд 35-44 насны албан хаагчид дийлэнх хувийг эзэлж байна.




Зураг 1.2.3: Агентлагт ажиллаж байгаа албан хаагчид /насны байдлаар/



Зураг 1.2.4: Агентлагт ажиллаж байгаа албан хаагчдын ажилласан жил, төрийн албанд ажилласан жил



Зураг 1.2.5: Агентлагт ажиллаж байгаа албан хаагчдын нас, хүйсийн байдлаар



Зураг 1.2.6: Агентлагт ажиллаж байгаа албан хаагчдын боловсролын байдал


Салбарын хэмжээнд 2020-2025 онд хэрэгжүүлэх “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр”, “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдон дагалдан гарсан эрх зүйн баримт бичгийг агентлагийн албан хаагчид, орон нутгийн харьяа байгууллага, газрын мэргэжлийн байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөөг тухай бүр хариуцсан ажлын чиглэлээр тогтмол өгч, салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг удирдан зохион байгуулан ажиллаж ирсэн.

Газрын харилцааны салбарын хэмжээнд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны төрийн албан хаагчдын дэлгэрэнгүй мэдээлэл, судалгааг дараах үзүүлэлтээр гаргасан болно.


*Нийслэл, дүүргийн албан хаагчдын хүний нөөцийн судалгаа*

Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба нь Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны Б/62 дугаар тушаалаар байгууллагын бүтэц, орон тоог баталж, тус алба нь 8 хэлтэс, 9 дүүргийн Газар зохион байгуулалтын алба, нийт 223 ажилтан, албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 358, 359, 2021 оны 61 дүгээр тогтоолоор нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны 184 албан хаагчид хамаарах 57 албан тушаалын тодорхойлолтыг жишиг байдлаар хянаж зөвшөөрөн, батлагдсан. /Зураг 1.2.7/.




Зураг 1.2.7: Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны бүтэц


Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, дүүргийн Газар зохион байгуулалтын албанд нийт 223 албан хаагч ажиллаж байна. /Зураг 1.2.8, 1.2.9/.



Зураг 1.2.8: Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны хэлтэс, албан хаагчийн тоо




Зураг 1.2.9: Дүүргийн Газар зохион байгуулалтын албадын албан хаагчийн тоо



Зураг 1.2.10: Нийслэлийн хэмжээнд газрын салбарт ажиллаж байгаа албан хаагчдын хүйсийн харьцаа


Насны ангиллаар нь авч үзвэл 21-25 насны 10 албан хаагч буюу 4.4%, 26-30 насны 27 албан хаагч буюу 12,1%, 31-35 насны 56 албан хаагч буюу 25.1%, 36-40 насны 52 албан хаагч буюу 23.3%, 41-45 насны 50 албан хаагч буюу 22.4%, 46-50 насны 17 албан хаагч буюу 7.6%, 51-55 насны 6 албан хаагч буюу 2.7%, 56-с дээш насны 5 албан хаагч буюу нийт албан хаагчийн 2.4% байна. Үүнээс үзэхэд 31-35 насны албан хаагч хамгийн их буюу 30.3 хувийг эзэлж байна /Зураг 1.2.11/.




Зураг 1.2.11: Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдын насны ангилал

Ажилласан жилээр нь авч үзвэл нийт албан хаагчдын 25.5% нь буюу 57 албан хаагч төрийн албанд 1-5 жил ажилласан байгаа бол 6-15 жил төрийн албанд ажиллаж байгаа 96 албан хаагч байгаа нь нийт албан хаагчдын 43.2%-ийг эзэлж байна. Мөн

төрийн албанд 16-20 жил ажилласан 42 албан хаагч буюу 18.8%, 21-ээс дээш жил ажилласан 28 албан хаагч буюу 12.5%-ийг эзэлж байна. Судалгаанаас харахад нийт албан хаагчдын 138 албан хаагч буюу 74.5 хувь нь төрийн албанд 6-аас дээш жил ажилласан албан хаагчдаас бүрджээ.



Зураг 1.2.12: Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдын төрийн албанд мэргэшсэн байдал /ажилласан жилээр/




Зураг 1.2.13: Албан тушаалын ангилал, зэрэглэл

Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдын 184 буюу 82.5% нь төрийн захиргааны албан хаагч, 39 буюу 17.5% нь төрийн үйлчилгээний албан хаагч байна.


Төрийн захиргааны албан хаагчид ТЗ-5-аас ТЗ-11 хүртэл албан тушаалын зэрэглэлтэй байна.

Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны 223 албан хаагчид 100% дээд боловсролтой, үүнээс 72% бакалавр зэрэгтэй, 28% магистр зэрэгтэй албан хаагчид байна /Зураг 1.2.14/.



Зураг 1.2.14: Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдын боловсролын түвшин


Газрын харилцааны ажлын байранд шаардагддаг ArcGis, AutoCad, LM програм хангамжийг нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдын 100% нь дундаас дээд түвшинд эзэмшсэн байна /Зураг 1.2.15/.



Зураг 1.2.15: Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдын ур чадвар


Гадаад хэлний мэдлэгээр 18 албан хаагч 2 буюу түүнээс дээш хэлний мэдлэгтэй, нийт албан хаагчдын 52% Англи, 12% Орос хэлийг эзэмшсэн бусад буюу Солонгос, Хятад, Герман, Япон хэлийг 36% нь эзэмшсэн байна /Зураг 1.2.16/.





Зураг 1.2.16: Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдын хэлний мэдлэг

Албан хаагчдын 81% нь газар эзэмших, өмчлөх, ашиглах эрхтэй байна. нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны 83% банк, санхүүгийн байгууллагад зээлтэй, 17% нь зээлгүй байна /Зураг 1.2.17/



Зураг 1.2.17: Нийслэл, дүүргийн албан хаагчдын нийгмийн асуудал


Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар

Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт”, 276 дугаар тогтоолоор “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл” тус тус шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл жагсаалтыг агентлагийн даргын 2019 оны Б/123 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.

Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 360 дугаар тогтоолоор 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 336 албан хаагчид хамаарах захиргааны албан хаагчийн 15 албан тушаалын тодорхойлолтыг жишиг байдлаар хянаж, батлагдсан.


21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт ажиллаж байгаа албан хаагчдын хүний нөөцийн судалгааг дараах байдлаар ангилж үзвэл:

Нийт албан хаагчдын 27% нь 18-30 насны, 46% нь 31-40 насны, 15% нь 41- 50 насны, 12 % нь 51-с дээш насныхан байна /Зураг 1.2.18/.




Зураг 1.2.18: Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нийт албан хаагчдын насны харьцуулалт

Нийт албан хаагчдын 215 буюу 54% нь эрэгтэй, 185 буюу 46% нь эмэгтэй, албан хаагчдын 85% нь тухайн орон нутгийн уугуул иргэд ажиллаж байна /Зураг 1.2.19/.




Зураг 1.2.19: Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагчдын хүйсийн харьцаа болон тухайн орон нутгийн уугуул иргэн эсэх

Аймгийн Газрын харилцааны салбарт 6-15 жил төрийн албанд ажиллаж байгаа албан хаагчид хамгийн их буюу 42 %-ийг эзэлж байна /Зураг 1.2.20/.



Зураг 1.2.20: Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын албан хаагчдын төрийн албанд мэргэшсэн байдал /ажилласан жилээр/


21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нийт 400 албан хаагчдаас Төрийн захиргааны албан хаагч 88%, Төрийн үйлчилгээний албан хаагч 12% байна /Зураг 1.2.21/.



Зураг 1.2.21: Албан тушаалын ангилал, төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвтэй эсэх

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын нийт албан хаагчдын 82% нь бакалаврын зэрэгтэй, 8% нь магистрын зэрэгтэй, 9% нь бүрэн болон тусгай дунд боловсролтой байна.


Бүрэн болон тусгай дунд боловсролтой албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэх чиглэлийн үйлчилгээний албан үүргийг гүйцэтгэж байна. /Зураг 1.2.22/.



Зураг 1.2.22: Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагчдын боловсролын түвшин


ArcGis, AutoCad, QuantumGIS, Лэнд менежер гэх мэт ажлын байранд шаардагддаг програм хангамжийг нийт албан хаагчдын 23% нь бүрэн эзэмшсэн, 198 буюу 50% нь сайн эзэмшсэн, дунд зэрэг 27% байгаа бөгөөд мэргэжлийн програм хангамжийн сургалтад хамрагдахаар 2022 оны салбарын “Сургалт, хөгжлийн төлөвлөгөө”-нд тусгаад байна.

Давхардсан тоогоор англи хэлний мэдлэгтэй 283, орос хэлний мэдлэгтэй 47, бусад хэл хэлний мэдлэгтэй 15 албан хаагч ажиллаж байна /Зураг 1.2.23/.



Зураг 1.2.23: Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагчдын ур чадвар

Нийт албан хаагчдын 55% нь эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн газартай, 81% нь санхүүгийн байгууллагад тодорхой хэмжээний зээлтэй байна /Зураг 1.2.24/.




Зураг 1.2.24: Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын албан хаагчдын нийгмийн асуудал

Сумын газрын даамлууд

Сумдын газрын даамлуудыг Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн “Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 253 дугаар тогтоолын 1-д заасны дагуу Газрын даамлын ангилал, зэрэглэлийг өөрчилж туслах түшмэл /ТЗ-3/-ээс дэс түшмэлийн ангилал, зэрэглэл ТЗ-5-д шилжүүлсэн бөгөөд 21 аймгийн сумдад 361 газрын даамал ажиллаж байгаа бөгөөд ажлын онцлог, сумын нутаг дэвсгэр, хүн амын тооноос шалтгаалж суманд газрын даамал харилцан адилгүй ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 361 дүгээр тогтоолоор сумдын газрын даамлын албан тушаалын тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.


Газрын даамлууд кадастрын нэгдсэн сүлжээнд холбогдож мэдээлэл оруулах, газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулахад ARCGIS, AUTOCAD, QGIS, ERDAS IMAGINE, LAND MANAGER зэрэг программуудыг сурч байж холбогдох хууль тогтоомжоор олгогдсон үүргээ хэрэгжүүлэх шаардлагатай байдаг. Дээрх чиглэлээр шаталсан хэлбэрээр сургаж, мэргэшүүлэхэд ихээхэн цаг хугацаа орохоос гадна зардал их гарч байгаа тул санхүүжилтийн 5000-10000 хүн амтай суманд 2 газрын даамал ажиллуулах асуудлыг судалж, санал боловсруулан шийдвэрлүүлэхээр дээд шатны байгууллагад уламжлаад байна.

Сумын газрын даамлуудыг нас болон хүйсээр нь харьцуулан авч үзэхэд: нийт газрын даамлуудын 37 % нь 18-30 насны, 42% нь 31-40 насны, 12% нь 41 ба түүнээс дээш насны албан хаагчид ажиллаж байна /Зураг 1.2.25/.




Зураг 1.2.25: Сумын газрын даамлуудын насны ангилал

Сумын газрын даамлуудыг ажилласан жилийг нь харьцуулан авч үзэхэд: нийт газрын даамлуудын 16% нь 1 жил хүртэл, 27% нь 2-5 жил, 37% нь 6-15 жил, 14% 16-20 жил бусад 20-оос дээш жил түүнээс дээш насны албан хаагчид ажиллаж байна /Зураг 1.2.26/.




Зураг 1.2.26: Сумын газрын даамлуудын ажилласан жилийн байдал

Нийт албан хаагчдын 48% нь эрэгтэй, 52% нь эмэгтэй албан хаагчид байгаа ба 86 % нь тухайн орон нутгийн уугуул иргэд ажиллаж байна. /Зураг 1.2.27/.




Зураг 1.2.27: Сумын газрын даамлуудын хүйсийн харьцаа, тухайн орон нутгийн уугуул иргэд эсэх

Газрын даамлуудын төрийн албанд 27% нь 2-5 жил, 37% нь 6-15 жил, 20% 16-аас дээш жил ажиллаж байна /Зураг 1.2.28/.




Зураг 1.2.28: Сумын газрын даамлуудын ажилласан жил

Нийт ажилчдын 93% нь бакалаврын зэрэгтэй, 7% нь магистрын зэрэгтэй газрын даамал ажиллаж байна /Зураг 1.2.29/.



Зураг 1.2.29: Сумын газрын даамлуудын боловсролын түвшин


Давхардсан тоогоор англи хэлний мэдлэгтэй 227 буюу 63% хувь нь, орос хэлний мэдлэгтэй буюу 13% хувь нь бусад хэлний мэдлэгтэй 1 % хувь буюу 5 газрын даамал ажиллаж байна /Зураг 1.2.30/.



Зураг 1.2.30: Сумын газрын даамлуудын хэлний түвшин болон програм хангамж эзэмшсэн түвшин

Сумдын газрын даамлууд ажлын байранд шаардагдах ARCGIS, AUTOCAD, QGIS, ERDAS IMAGINE, LAND MANAGER програм хангамжийг тодорхой хэмжээгээр эзэмшсэн ба үүнээс 87 нь бүрэн, 212 нь сайн, 63 нь дунд хэмжээгээр эзэмшсэн байгаа хэдий ч Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалт /Чиглүүлэх богино хугацааны сургалт, Мэргэшүүлэх дунд хугацааны сургалт, Мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт/-д Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу мэргэшүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Нийт албан хаагчдын 211 нь эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн газартай, 269 нь санхүүгийн байгууллагад тодорхой хэмжээний зээлтэй байна /Зураг 1.2.31/.




Зураг 1.2.31: Сумын газрын даамлуудын нийгмийн асуудал

### 1.3. ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

Тайлант онд 21 аймгийн хэмжээнд Газрын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд давхардсан тоогоор нийт 743 удаагийн хяналт, шалгалт хийснээс Төв, Дархан-Уул, Булган аймгууд хамгийн олон удаагийн давтамжтай буюу ихэнх сумдаа хамруулж 69-82 удаа хяналт, шалгалт явуулсан байна.


Харин Орхон, Говьсүмбэр зэрэг цөөн сумтай аймгууд болон Архангай аймаг хамгийн бага давтамжтай буюу 3-4 удаа хяналт, шалгалт хийсэн байна /Зураг 1.3.1/.



Зураг 1.3.1: Газрын харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтын тоо




Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтын тоо, хэмжээ улсын хэмжээнд 2018 оноос эхлэн жил дараалан өссөн үзүүлэлттэй байна /Зураг 1.3.2/.



Зураг 1.3.2: Газрын харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийсэн тоо 2018, 2019, 2020, 2021 он


Орон нутагт хийсэн хяналт, шалгалтын ажлын давтамжаас хамаарч илэрсэн зөрчлийн тоо харилцан адилгүй байна.

Газрын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтаар нийт 14220 зөрчил илэрсэн байна /Зураг 1.3.3/.



Зураг 1.3.3: Газрын харилцааны хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийн тоо /аймаг тус бүрээр/


Үүний 12606 буюу 88.6% нь газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, 834 буюу 5.9% нь эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй газар ашигласан зөрчил эзэлж байгаа бол 161 буюу 1.1% нь төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас хамаарсан зөрчил, 619 буюу 4.4% нь бусад зөрчлүүд тус тус эзэлж байна /Зураг 1.3.4/.



Зураг 1.3.4: Газрын харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийн төрөл, түүний харьцуулалт

Эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр газар ашигласан зөрчил өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна. Харин газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчил болон төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас хамаарсан зөрчил өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

Газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчлийг дотор нь ангилж авч үзвэл 2 жил дараалан ашиглаагүй 2418 /19.2%/, гэрээнд заасан зориулалт бусаар газар ашигласан 925 /7.3%/, газар эзэмших, ашиглах эрхийн хугацаа дууссан 1219 /9.7%/, газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй 8044 /63.8%/ зөрчил тус тус эзэлж байна /Зураг 1.3.5/.



Зураг 1.3.5: Газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх зөрчлийн тоо


Зураг 1.3.5-аас харахад 2 жил дараалан газраа ашиглаагүй зөрчил 50.8%-иар, газар эзэмших, ашиглах эрхийн хугацаа дууссан зөрчил 25.4%-иар, газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй зөрчил 30%-иар буурч, гэрээнд заасан зориулалт бусаар газар ашигласан зөрчил өмнөх оныхоос 537.9%-иар өссөн үзүүлэлттэй байна.

#### 1.4. ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТ, ТЭДГЭЭРИЙН БАРАГДУУЛАЛТЫН СУДАЛГАА

21 аймаг болон нийслэлийн хэмжээнд газар ашиглах, эзэмших, эзэмшиж байгаа газраа өмчлөх, шинээр өмчлөх эрхтэй холбогдон ирүүлсэн өргөдөл хүсэлтийн судалгааг нэгтгэн дүгнэхэд нийт 135935 өргөдөл, хүсэлт ирүүлснээс шинээр газар эзэмших 48382 /35.59%/, шинээр газар ашиглах 1387 /1.02%/, газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх 24743 /18.20%/, газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалах 13183 /9.70%/, газар ашиглалтын зориулалт өөрчлөх 1066 /0.8%/, газар эзэмших, ашиглах гэрээ, гэрчилгээний хугацаа сунгуулах 5769 /4.24%/, эзэмшил газраа бусдад ашиглуулах 95 /0.07%/, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ нөхөн авах 2830 /2.08%/, эзэмшиж байгаа газраа өмчлөх 2607 /1.92%/, өмчилсөн газрынхаа хэмжээг өөрчлөх 2664 /1.96%/, өмчилсөн газраа барьцаалах 3214 /2.36%/, шинээр газар өмчлөх 16156 /11.89%/, өмчлөх эрхээ шилжүүлэх 13087 /9.63%/, газар эзэмших, ашиглах эрхээ хүчингүй болгуулах хүсэлт 676 /0.50%/-ийг тус тус гаргаж ирүүлсэн байна.

Тайлант онд 21 аймаг, нийслэлийн хэмжээнд нийт 135935 өргөдөл, хүсэлт ирснээс 111009 /81.66%/ өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэж, 25166 /18.51%/ өргөдөл, хүсэлт шийдвэрлэгдээгүй байна.


Өргөдөл, хүсэлтийг шийдвэрлээгүй нийтлэг шалтгаан нь тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт шинээр газар эзэмших, өмчлөх хүсэлт гаргасан, бичиг баримтын зөрчилтэй, бичиг баримтын бүрдүүлэлт дутуу, хүсэлт ирүүлсэн газар бусдад олгогдсон газартай давхардсан, инженерийн шугам сүлжээ бүхий газар, авто замын зурвас газарт орсон, үерийн аман дээр газар эзэмших, өмчлөх, ашиглах хүсэлт гаргасан, эзэмшиж байгаа газраа өмчлөхөөр хүсэлт гаргасан боловч Газрын кадастрын мэдээллийн санд кадастрын зураг нь бодит хашаалсан газрын хэмжээнээс зөрүүтэй зэрэг шалтгаанаас өргөдөл, хүсэлтийг шийдвэрлээгүй байна.



Зураг 1.4.1: Өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэсэн болон шийдвэрлээгүй байдал

Өргөдөл хүсэлт, тэдгээрийн барагдуулалтын 2021 оны тайланг 2020 оны дүнтэй харьцуулахад эзэмшиж байгаа газраа өмчлөх хүсэлт 2403, өмчилсөн газрынхаа 179, эзэмшил газраа бусдад ашиглуулах 83, газар эзэмших, ашиглах гэрээ, гэрчилгээний хугацаа сунгуулах 717, газар ашиглалтын зориулалт өөрчлүүлэх 51, хүчингүй болгуулах хүсэлт 735-аар буурч, газар өмчлөх эрх шилжүүлэх 3683, шинээр газар өмчлөх 8041,

өмчилсөн газраа барьцаалах 680, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ нөхөн авах 412, газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалах 7355, шинээр газар ашиглах 46, шинээр газар эзэмших 9224-өөр тус тус нэмэгдсэн байна.



Зураг 1.4.2: Өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлтийн байдлын судалгааг 2020 онтой харьцуулсан байдал

Тайлант онд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт 4515 албан бичиг ирснээс хугацаандаа шийдвэрлэсэн нь 2051 /45,42%/, хариугүй албан бичиг 2199 /48.70%/, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн өргөдөл 265 /5.86%/ байна.

Цаашид Газрын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө зэргийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад танилцуулах ажлыг тогтмол зохион байгуулж байх шаардлагатай юм.

### 1.5. ГАЗРЫН МАРГААН, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ


Газрын зөрчил, маргааны шийдвэрлэсэн байдлыг нэгтгэн үзэхэд нийт гарсан маргаан 2468, үүний дотор газар эзэмшихтэй холбоотой 1069 /43.31%/, газар өмчлөхтэй холбоотой 646 /26.17%/, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэстэй холбоотой 668 /27.06%/, газар ашиглахтай холбоотой 85 /3.44%/ маргаан тус тус гарсан байна.

Хүснэгт 1.5.1: Газрын маргаан, түүнийг шийдвэрлэсэн болон шийдвэрлээгүй тоо

№	Аймгийн нэр	Маргааны тоо				Үүнээс							
		Эзэмших	Өмчлөх	Хилийн цэсийн	Ашиглах	Шийдвэрлэгдсэн				Шийдвэрлэгдээгүй			
						Эзэмших	Өмчлөх	Хилийн цэсийн	Ашиглах	Эзэмших	Өмчлөх	Хилийн цэсийн	Ашиглах
1	Архангай	10	1	9	0	3	1	2	0	7	0	7	0
2	Баянхонгор	27	26	63	0	16	26	35	0	11	0	28	0
3	Баян-Өлгий	78	26	1	7	70	23	0	6	8	3	1	1
4	Булган	214	14	3	0	210	11	1	0	3	4	2	0
5	Говь-Алтай	6	0	16	42	0	0	10	0	6	0	6	42
6	Говьсүмбэр	2	1	0	0	0	0	0	0	2	1	0	0
7	Дархан-Уул	16	11	0	0	5	4	0	0	11	7	0	0
8	Дорнод	18	33	1	1	3	31	1	0	15	0	2	1
9	Дорноговь	87	8	16	0	76	3	9	0	11	0	12	0
10	Дундговь	12	10	21	0	12	10	1	0	0	0	20	0
11	Завхан	18	6	297	0	8	2	18	0	10	4	279	0
12	Орхон	31	17	0	0	30	17	0	0	0	0	0	0
13	Өвөрхангай	5	0	15	0	3	0	14	0	2	0	1	0
14	Өмнөговь	32	321	65	0	18	270	16	0	14	51	48	0
15	Сүхбаатар	4	3	15	0	4	3	0	0	0	0	15	0
16	Сэлэнгэ	59	43	5	11	0	36	3	11	0	7	0	2
17	Төв	81	59	100	1	75	46	72	0	6	13	28	1
18	Увс	43	5	11	0	36	3	11	0	7	0	2	0
19	Ховд	24	2	0	4	11	2	0	3	13	0	0	1
20	Хөвсгөл	69	3	17	1	62	3	12	0	5	5	0	1
21	Хэнтий	70	31	12	9	54	18	10	0	16	13	2	9
22	Улаанбаатар	163	26	1	9	46	7	1	5	117	19	-	4
<b>Дүн</b>		<b>1069</b>	<b>646</b>	<b>668</b>	<b>85</b>	<b>742</b>	<b>516</b>	<b>216</b>	<b>25</b>	<b>264</b>	<b>127</b>	<b>453</b>	<b>62</b>


Нийт 2468 маргаан гарснаас газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхтэй холбоотой 2015 маргааныг шийдвэрлэн, 906 газрын маргааныг шийдвэрлээгүй байна.

Маргааныг шийдвэрлээгүй шалтгаан нь иргэний болон захиргааны шүүх байгууллагад хянагдаж, шүүхийн шийдвэр гараагүй тул маргааныг шийдвэрлээгүй байна.



Зураг 1.5.2: Газрын маргааныг шийдвэрлэсэн байдал

Улсын хэмжээнд гарсан 2021 оны маргааны тоог 2020 оны маргааны тоотой харьцуулахад өмчлөх эрхтэй холбоотой үүссэн маргаан 220, газар ашиглах эрхтэй холбоотой үүссэн маргаан 564 тус тус тоогоор өссөн, газар эзэмших эрхтэй холбоотой үүссэн маргаан 210, хилийн цэсийн асуудлаар үүссэн маргаан 1052-аар буурсан дүнтэй байна.



Зураг 1.5.3: 2020-2021 оны газрын маргааны үзүүлэлт

Бүх шатны шүүх байгууллагад хянагдаж шийдвэрлэгдсэн газартай холбоотой маргааныг судалгааг 2015-2021 оны байдлаар shuukh.mn-ээс түүвэрлэн авч, хүснэгт 1.5.4-д харуулав.

Хүснэгт 1.5.4: Бүх шатны шүүх байгууллагад хянагдаж шийдвэрлэгдсэн газартай холбоотой маргааны судалгаа

Шүүх байгууллага		Газар эзэмших гэрээ, түүнийг байгуулах журмыг зөрчсөн	Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрын талаарх маргаан	Газартай холбогдсон хууль бус шийдвэрийг хүчингүй болгуулах	Газрын тухай хуулиар	Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар бусад	Нийт
Иргэний хэрэг	Анхан шат	43	97	12	199	11	<b>362</b>
	Давж заалдах шат	18	63	10	62	12	<b>165</b>
	Хяналтын шат	1	22	2	19	1	<b>45</b>
Захиргааны хэрэг	Анхан шат	1369					<b>1369</b>
	Давж заалдах шат	788					<b>788</b>
	Хяналтын шат	474					<b>474</b>
<b>Нийт дүн</b>							<b>3203</b>

Газартай холбоотой маргааныг шийдвэрлэсэн байдлыг хүснэгт 1.5.5-аар харуулав.

Хүснэгт 1.5.5: 2021 онд шийдвэрлэгдсэн газартай холбоотой маргааны тоо

Шүүх байгууллага		Газар эзэмших гэрээ, түүнийг байгуулах журмыг зөрчсөн	Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрын талаарх маргаан	Газартай холбогдсон хууль бус шийдвэрийг хүчингүй болгуулах	Газрын тухай хуулиар	Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар бусад	Нийт
Иргэний хэрэг	Анхан шат	9	24	3	23	4	<b>63</b>
	Давж заалдах шат	6	12	2	5	7	<b>32</b>
	Хяналтын шат	0	3	1	1	1	<b>6</b>
Захиргааны хэрэг	Анхан шат	195					<b>195</b>
	Давж заалдах шат	0					<b>0</b>
	Хяналтын шат	0					<b>0</b>
<b>Нийт дүн</b>							<b>296</b>



Бүх шатны шүүх, төрийн байгууллагын хүсэлтийг үндэслэн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын тушаалаар шинжээчийн дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан нийт 42 шинжээчийн дүгнэлтийг холбогдох газарт хүргүүлсэн байна. Үүнд:

- Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс - 22
- Иргэний хэргийн анхан шатны шүүхээс - 15
- Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн - 5

Нийт 447 удаагийн нотлох баримтыг бүх шатны шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэн байна. 2021 оны шинжээчийн дүгнэлт буюу нотлох баримт хүргүүлсэн байдлыг өмнөх 2020 онтой харьцуулан үзэхэд нотлох баримт гаргуулах өргөдөл, хүсэлт 42-оор буурсан, шинжээчийн дүгнэлт гаргах ажил 5-аар өссөн дүнтэй байна.

Дээрх тайлан, мэдээнээс дүгнэхэд газрын маргаан гарч буй шалтгааныг ангилж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

*Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас шалтгаалсан:*

- Газар, эзэмших, ашиглах гэрээ дүгнүүлээгүй;
- Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулаагүй;
- Захирамжаар олгогдсон газрын хэмжээг дур мэдэн нэмэгдүүлсэн;
- Газар дээрээ хил заагаа тэмдэгжүүлж, хашаа бариагүй;
- Гэрээний дагуу газар эзэмшиж ашигладаггүй;

*Холбогдох хууль тогтоомж болон норм дүрэм зөрчсөн:*

- Нийтийн эзэмшлийн зам талбайг зөвшөөрөлгүй эзэмших, ашиглах /хашаа хайс барих/
- 1 давхрын барилгын өргөтгөлийг зөвшөөрөлгүй дур мэдэн өргөтгөл хийх;
- Эрх зүйн харилцаа үүсээгүй байхад бусдын эзэмшиж, өмчилж буй газартай давхардуулан хашаа болон барилга байгууламж барих;
- Эрх зүйн харилцаа үүссэн газрынхаа хил, зааг дотор барилга байгууламжыг баридаггүй, газар доогуур бусдын эзэмшлийн газарт авто гарааш барих;
- Инженерийн шугам сүлжээ, өндөр хүчдэл бүхий газрын хамгаалалтын зурвас газарт буух /хашаа хайс барих/;

*Төрийн байгууллага, эрх бүхий албан тушаалтнаас шалтгаалсан:*


- Эзэмшиж, өмчилж буй газар дээр давхардуулан газар олголт хийх;
- Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт газар олголт хийх;
- Нэгж талбарыг дур мэдэн устгаж, эзэмшигчийн мэдээллийг солих;
- Газар олголтыг хийхдээ хээрийн судалгааг хийхгүй байх;
- Газар эзэмших өмчлөх эрхийг шилжүүлэхдээ санаатай болон санамсаргүйгээр нэгж талбарын мэдээллийг судлахгүйгээр эрхийг шилжүүлэн маргаан гаргах;

### 1.6. ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХ БОЛОН ӨМЧИЙН ГАЗРАА БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД БАРЬЦААЛСАН БАЙДЛЫН ТАЙЛАН

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1. дэх хэсэгт “Газар эзэмших эрхийн гэрчилгээг хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр бусдад шилжүүлж, барьцаалж болно. Эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, барьцаалах үйл ажиллагаа нь зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд явагдана” гэж заасны дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага улсын бүртгэлд бүртгүүлдэг. Мөн “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.8-д эрхийн гэрчилгээ барьцаалах болон эзэмшил газраа бусдад ашиглуулах хүсэлтийг тухайн шатны Засаг дарга зөвшөөрсөн тохиолдолд энэ тухай албан бичгийг үндэслэн Газрын кадастрын мэдээллийн сантай бол мэдээллийн санд, байхгүй бол энэ журмын 5 дугаар хавсралт “Газар ашиглуулсан, барьцаалсан тухай бүртгэл”-д бүртгэж өргөдөл гаргагчид мэдэгдэнэ гэж заасны дагуу Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газраас Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системээр барьцааны бүртгэлийг хийж байгаа бөгөөд 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газрын алба, сумын Газрын даамал газар ашиглуулсан, барьцаалсан бүртгэлийг бүртгэж жилийн эцсээр нэгтгэн тайлан гаргаж байна.

Тухайн бүртгэлээс харахад 2021 онд улсын хэмжээнд 14456 газар эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байна. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан судалгаагаар 40196 Монгол Улсын иргэн өөрийн өмчийн газраа банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байх ба нийт 54652 нэгж талбар /газар эзэмших эрх, өмчийн газар/ буюу Монгол Улсын нийт нэгж талбарын 5.1 хувийг банк, санхүүгийн байгууллага болон иргэн, хуулийн этгээдэд барьцаалсныг бүртгэсэн байна.

Газар эзэмших эрх болон өмчийн газраа барьцаалсан байдлыг улсын хэмжээнд нэгтгэж хүснэгт 1.6.1, зураг 1.6.1-д үзүүлэв.




Зураг 1.6.1: Газар эзэмших эрхийн барьцаа бүртгүүлсэн байдал

Хүснэгт 1.6.1: Газар эзэмших эрх болон өмчийн газраа шинээр барьцаалсан байдал

№	Аймаг, нийслэл	Барьцаалсан нэгж талбарын тоо	Үүнээс	
			Эзэмших	Өмчлөх
1	Архангай	965	267	698
2	Баян-Өлгий	2099	631	1468
3	Баянхонгор	2033	455	1578
4	Булган	957	355	602
5	Говь-Алтай	1452	831	621
6	Говьсүмбэр	441	114	327
7	Дархан-Уул	2351	850	1501
8	Дорнод	956	215	741
9	Дорноговь	1118	659	459
10	Дундговь	637	168	469
11	Завхан	1119	297	822
12	Орхон	2646	471	2175
13	Өвөрхангай	2904	513	2391
14	Өмнөговь	1683	189	1494
15	Увс	1626	309	1317
16	Сүхбаатар	910	181	729
17	Сэлэнгэ	3674	1781	1893
18	Төв	2490	569	1921
19	Ховд	1671	167	1504
20	Хөвсгөл	2693	690	2003
21	Хэнтий	1285	239	1046
22	Нийслэл	18942	4505	14437
<b>ДҮН</b>		<b>54652</b>	<b>14456</b>	<b>40196</b>

Тайлант онд бүртгүүлсэн газар эзэмших эрхээ болон өмчийн газраа барьцаалсан байдлаас харахад нийт барьцаанд байгаа газрын 44 хувь нь гэр бүлийн хэрэгцээний газар байна. Улсын хэмжээнд хөдөө аж ахуйн зориулалттай буюу төмс, хүнсний ногоо тариалан, жимс, жимсгэний усалгаагүй тариалан, үр тарианы усалгаагүй тариалан, өвөлжөө, хаваржааны гэх мэт газрын банк, санхүүгийн байгууллагуудад барьцаалсныг зураг 1.6.2-д үзүүлэв.



Зураг 1.6.2: Банк, санхүүгийн байгууллагуудад барьцаалсан газрын зориулалт ба төрөл

Улсын хэмжээнд шинээр газар эзэмших эрхийг банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан бүртгэлийг сүүлийн 5 жилийн мэдээтэй харьцуулав /Хүснэгт 1.6.2, Зураг 1.6.3/.


Хүснэгт 1.6.2: 2016-2021 онд улсын хэмжээнд шинээр эзэмших эрхийг банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдал

д/д	Аймаг, нийслэл	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
1	Архангай	153	178	59	52	267
2	Баян-Өлгий	107	317	261	244	631
3	Баянхонгор	524	269	89	50	455
4	Булган	160	152	109	160	355
5	Говь-Алтай	561	575	202	81	831
6	Говьсүмбэр	151	85	88	44	114
7	Дархан-Уул	409	328	272	218	850
8	Дорнод	74	87	49	87	215
9	Дорноговь	365	405	491	62	659
10	Дундговь	161	129	84	84	168
11	Завхан	391	91	109	64	297
12	Орхон	130	179	211	112	471
13	Өвөрхангай	313	365	327	336	513
14	Өмнөговь	91	60	96	91	189
15	Увс	859	458	272	44	309
16	Сүхбаатар	82	119	91	55	181
17	Сэлэнгэ	361	704	475	632	1781
18	Төв	67	72	99	148	569
19	Ховд	380	356	238	7	167
20	Хөвсгөл	320	285	305	277	690

21	Хэнтий	173	76	114	45	239
22	Нийслэл	5152	6331	494	2027	4505
<b>Нийт</b>		<b>10984</b>	<b>11621</b>	<b>4535</b>	<b>4920</b>	<b>14456</b>

Тайлант онд газар эзэмших эрхийг банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдал 2020 оныхоос 2.9 дахин өссөн бөгөөд энэ нь Монгол Улсын Засгийн газраас баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө” - ны “Ажлын байрыг дэмжих” зээл олгогдсонтой холбоотой өссөн байна.

Мөн 2021 онд газар эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдлаас харахад 66 хувийг банкинд, үлдсэн 34 хувийг банк бус санхүүгийн байгууллага, хоршоо болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад барьцаалсан байна. Үүнээс хамгийн их хувь буюу 38 хувийг Хаан банкинд, 10 хувийг Хас банкинд, 7 хувийг Төрийн банкинд, 4 хувийг Худалдаа хөгжлийн банк, Голомт банкинд, 3 хувийг бусад банкинд барьцаалсан байна /Зураг 1.6.3/.



Зураг 1.6.3: Газар эзэмших эрхийг банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдал.

Газар эзэмших эрх болон өмчийн газрыг банк, санхүүгийн байгууллагад дундажаар 2.8 жилийн хугацаатайгаар барьцаалсан байна.

### 1.7. ГАЗРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Газрын үнэд байршил, зориулалт, орчин нөхцөл, инженерийн шугам сүлжээ, бичиг баримтын бүрэн эсэх зэрэг хүчин зүйлүүд нөлөөлөхөөс гадна барилга барих тусгай зөвшөөрөл буюу техникийн нөхцөл, газар зохион байгуулалтын болон хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, төрийн засгийн бодлого шийдвэрээс ихээхэн хамаардаг.

Мөн үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх нь инфляцийн эсрэг сайн хамгаалалт болдог тул хөрөнгө оруулагчид энэ төрлийн хөрөнгө оруулалтыг сонирхдог

бөгөөд газар болон үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн талаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлуудыг судлан зах зээлийн бүтэц, оролцогч талуудын оролцоо, үл хөрөнгийн үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлүүдийг судалж, дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай байдаг.

Иймд газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг бүрдүүлж, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан байгуулах зорилгоор Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд тус системийг ашиглан 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргүүдийн Газар зохион байгуулалтын алба, сумдын Газрын даамлууд үйл ажиллагаандаа ашиглаж, газрын зах зээлийн үнийн мэдээг цуглуулж байна.

Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг гэр бүлийн хэрэгцээний зориулалттай /ГХ/, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай /ХАА/, худалдаа үйлчилгээний зориулалттай /ХҮ/, хөдөө аж ахуйн газраас бусад үйлдвэрлэлийн зориулалттай /Ү/ гэсэн 4 төрлөөр цуглуулж байгаа бөгөөд газрын эрхээ шилжүүлж байгаа худалдагчаас, шилжүүлж авч байгаа худалдан авагчаас, түрээслэгч, түрээсүүлэгч болон бусад эх сурвалжаас бүрдүүлж байна.

Газрын биржийн цахим системд 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 53835 газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээ бүртгэгдээд бөгөөд үүнээс тайлант онд 23235 үнийн мэдээг нэмж бүртгэсэн.


Бүртгэгдсэн газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээнээс гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 19773, худалдаа үйлчилгээний зориулалттай 1499, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай 1440, хөдөө аж ахуйн газраас бусад үйлдвэрлэлийн зориулалттай 523 үнийн мэдээ тус тус эзэлж байна.

Хүснэгт 1.7.1. Газрын зах зээлийн үнийн мэдээ цуглуулсан байдал

№	Аймаг/ нийслэл	Нийт үнийн мэдээ	Гэр бүлийн хэрэгцээний газар	Үүнээс						
				Үүнээс		Худалдаа үйлчилгээний газар	Үүнээс		Хөдөө аж ахуйн газар	Үйлдвэрийн газар
				Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй		Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй		
1	Нийслэл	8042	7120	501	6619	349	27	322	208	365
2	Архангай	162	53	6	47	54	17	37	53	2
3	Баян-Өлгий	1435	1342	70	1272	54	10	44	31	8
4	Баянхонгор	857	626	65	561	95	17	78	128	8
5	Булган	743	566	70	496	60	12	48	107	10
6	Говь-Алтай	139	99	31	68	23	5	18	16	1
7	Говьсүмбэр	377	358	0	358	8	0	8	3	8


8	Дархан-Уул	2226	2037	95	1941	116	67	49	66	7
9	Дорноговь	464	388	38	350	51	5	46	17	8
10	Дорнод	511	464	1	463	23	0	23	23	1
11	Дундговь	250	179	22	157	56	21	35	14	1
12	Завхан	522	447	111	336	54	17	37	15	6
13	Орхон	1174	1114	140	974	51	18	33	1	8
14	Өвөрхангай	1808	1632	92	1540	76	18	58	86	14
15	Өмнөговь	676	576	6	568	40	1	39	40	20
16	Сэлэнгэ	758	475	6	469	93	10	83	175	15
17	Сүхбаатар	372	295	35	260	38	4	34	36	3
18	Төв	1572	1152	11	1141	88	3	85	318	15
19	Увс	401	336	23	313	26	9	17	38	1
20	Ховд	193	157	5	152	29	4	25		1
21	Хэнтий	320	192	9	183	71	3	68	42	15
22	Хөвсгөл	232	165	18	147	44	4	40	17	6
<b>Нийт дүн</b>		<b>23235</b>	<b>19773</b>	<b>1355</b>	<b>18415</b>	<b>1499</b>	<b>272</b>	<b>1227</b>	<b>1440</b>	<b>523</b>

Тайлант хугацаанд цуглуулсан газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээ 89 хувийг гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын үнийн мэдээ, 4 хувийг худалдаа үйлчилгээний зориулалттай газрын үнийн мэдээ, 5 хувийг хөдөө аж ахуйн зориулалттай газрын үнийн мэдээ, 2 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай газрын үнийн мэдээ эзэлж байгаа юм.




Зураг 1.7.1: Газрын зах зээлийн үнийн мэдээний эзлэх хувь.

Нийт цуглуулсан үнийн мэдээний хувьд 17835 буюу 76 хувь нь эрх шилжүүлэх гэрээний үнэ, 4345 буюу 19 хувийг худалдахаар санал болгож буй үнэ, 952 буюу 4 хувь нь дуудлага худалдаагаар худалдсан үнэ, 106 буюу 1 хувь нь үнэлэгдсэн болон түрээсийн үнэ тус тус эзэлж байна.



Зураг 1.7.2: Газрын зах зээлийн үнийн мэдээний төрөл



Зураг 1.7.3: Газрын зах зээлийн үнийн мэдээний, эрхийн төрөл

Мөн нийт цуглуулсан үнийн мэдээг эрхийн төрлөөр нь ангилахад 20841 өмчилсөн газрын, 2369 эзэмшил газрын, 29 ашиглаж буй газрын үнийн мэдээ тус тус бүртгэгдсэн байна.




Хүснэгт 1.7.2: 1 метр.кв газрын зах зээлийн дундаж үнэ.

Аймаг/ нийслэл	1 м.кв газрын дундаж үнэ								
	Гэр бүлийн хэрэгцээний газар	Үүнээс		Худалдаа үйлчилгээний газар	Үүнээс		Хөдөө аж ахуйн газар	Тэжээлийн ургамлын, Үр тарианы Төмс, хүнсний ногооны тариалангийн газар	Үйлдвэрийн газар
		Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй		Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй			
Нийслэл	34500	53100	20400	34900	-	34900	1000	-	18200
Архангай	10900	-	10900	20700	25200	11900	1900	130	2030
Баян-Өлгий	5800	15700	5200	13700		10600	1750	380	3600
Баянхонгор	8100	14900	7400	18600	33100	13700	1250	570	2200
Булган	6100	9700	5500	26100	28600	15500	800	210	2150
Говь-Алтай	10300	18400	7000	18600	20200	12000	1060		1900
Говьсүмбэр	3300	-	2800	14500	-	14500	2100	-	2900
Дархан-Уул	13000	13800	12900	22500	25400	20600	770	790	2500
Дорноговь	12900	23700	10800	14500	19300	10300	2070	-	5300
Дорнод	8600	-	8600	4300	-	4300	1700	480	2600
Дундговь	11700	23700	10000	11200	15000	8300	970	-	-
Завхан	13200	19800	10300	22200	23300	10400	3300	490	2800
Орхон	12000	12600	10000	23100	31100	18500	-	-	2300
Өвөрхангай	10900	17700	10800	14900	21900	12800	1200	174	2900
Өмнөговь	13200	-	13000	16600	-	16600	1280	500	2730
Сэлэнгэ	8800	11500	6100	16200	30800	13900	600	150	2400
Сүхбаатар	7000	14900	6500	7800	8500	7700	530	130	2900
Төв	6900	25000	6100	8600	19000	8300	1380	194	2700
Увс	10400	17800	9500	8500	15700	6600	820	380	3560
Ховд	10600	-	10600	14400	30400	12100	480	-	-
Хэнтий	10500	21400	10000	8800	17900	8400	590	200	2400
Хөвсгөл	6700	17500	6600	5600	-	5600	560	270	2590
<b>Дундаж</b>	<b>10700</b>	<b>19482</b>	<b>9100</b>	<b>15700</b>	<b>22800</b>	<b>12600</b>	<b>1480</b>	<b>330</b>	<b>3200</b>

*Гэр бүлийн хэрэгцээний газар:*

Газрын биржийн цахим системд гэр бүлийн хэрэгцээний газрын 19770 үнийн мэдээ бүртгэгдсэн бөгөөд уг мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд газрын үнэ нь байршил, орон нутгийн эдийн засаг, нийгмийн байдлаас хамаарч харилцан адилгүй байна. Иймд аймаг тус бүрээр нь газрын дундаж үнийг тооцож гаргасан.



Зураг 1.7.4: Гэр бүлийн хэрэгцээний 1 метр квадрат газрын дундаж үнэ

Тайлант хугацаанд гэр бүлийн хэрэгцээний газрын дундаж үнэ нийслэл Улаанбаатар хотод хамгийн өндөр бөгөөд байршлаасаа хамаарч харилцан адилгүй байна. Нийслэл Улаанбаатар хотын гэр бүлийн хэрэгцээний 7120 газрын зах зээлийн үнийн мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд хөрөнгө оруулалт хийгдээгүй 1 метр квадрат газрын дундаж үнэ 34,500 төгрөг, хөрөнгө оруулалт хийгдсэн 1 метр квадрат газрын дундаж үнэ 53,100 төгрөг байна. Өөрөөр хэлбэл Улаанбаатар хотод нэг айлын 0,07 га газрын дундаж үнэ хөрөнгө оруулалт хийгдээгүй бол 14,280,000 төгрөг, хөрөнгө оруулалт хийгдсэн бол 37,170,000 төгрөгөөр эдийн засгийн эргэлтэнд орж байна.


Гэр хорооллын газар нь Сүхбаатар, Баянгол дүүрэг болон хотын төвд ойр байх тусам үнэтэй, харин Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт хотын төвөөс холдох тусам үнэ багатай байна.

Мөн аймгуудын хувьд хөрөнгө оруулалт хийгдсэн гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ Дархан-Уул, Дундговь, Говь-Алтай, Өвөрхангай, Орхон, Увс, Хэнтий, Завхан, Дорноговь аймагт 10,300-13,000 төгрөг,

Архангай, Баян-Өлгий, Булган, Хэнтий, Баянхонгор, Завхан, Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Сэлэнгэ, Сүхбаатар, Хөвсгөл, Төв, Ховд аймагт 5,800-8,100 төгрөг байна.

Худалдаа үйлчилгээний зориулалттай газар:

Улсын хэмжээнд худалдаа үйлчилгээний зориулалттай газрын зах зээлийн үнийн 1499 мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна.




Зураг 1.7.5: Худалдаа, үйлчилгээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ

Худалдаа, үйлчилгээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ Улаанбаатар хотын хувьд 34,900 төгрөг, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Булган, Завхан, Өвөрхангай Ховд аймагт 20,000-30,400 төгрөг, Баян-Өлгий, Булган, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Төв, Увс, Хэнтий, Хөвсгөл, Өмнөговь, аймагт 4,300-19,300 төгрөгийн хооронд байна.

Мөн өмнөх онтой харьцуулахад худалдаа үйлчилгээний зориулалттай газрын үнэ тайлант онд өссөн үзүүлэлттэй байна.

*ХАА-н зориулалттай газар*

Улсын хэмжээнд хөдөө аж ахуйн зориулалттай /төмс, хүнсний ногоо тариалан, жимс, жимсгэний усалгаагүй тариалан, үр тарианы усалгаагүй тариалан, өвөлжөө, хаваржааны гэх мэт/ газрын зах зээлийн үнийн 1440 мэдээ цуглуулсан байна.




Зураг 1.7.6: Хөдөө аж ахуйн 1 метр квадрат газрын газрын дундаж үнэ

Хөдөө аж ахуйн зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ Завхан, Говьсүмбэр аймагт хамгийн өндөр буюу 2100 төгрөг, нийслэл, Увс, Төв, Өмнөговь, Өвөрхангай, Завхан, Дорнод, Дорноговь, Баянхонгор, Говь-Алтай, Баян-Өлгий аймагт 1000-2100 төгрөг, бусад аймагт 480-970 төгрөгийн хооронд байна. Хөрс, цаг уурын тааламжтай нөхцөл бүхий Сэлэнгэ аймагт хөдөө аж ахуйн зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ 600 төгрөг байна.

Тэжээлийн ургамлын, үр тарианы төмс, хүнсний ногооны тариалангийн зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ 130-700 төгрөг ба улсын хэмжээнд харьцангуй ойролцоо үнэтэй байгаа. Нийслэл, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Орхон, Ховд аймгуудад тэжээлийн ургамлын, үр тарианы төмс, хүнсний ногооны тариалангийн зориулалтаар бүртгэгдээгүй байна.

Үйлдвэрийн газар

Тайлант онд Улсын хэмжээнд үйлдвэрийн зориулалттай газрын зах зээлийн үнийн 523 мэдээ цуглуулсан бөгөөд үүнээс хамгийн өндөр буюу Улаанбаатар хотын үйлдвэрийн зориулалттай 1 метр квадрат газрын дундаж 18200 төгрөг, хамгийн баг нь Говь-Алтай аймагт 1900 төгрөг байна. Харин бусад аймгуудын хувь 2030-5300 төгрөгийн хооронд байна.




Зураг 1.7.7: Үйлдвэр үйлчилгээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ.

Улсын хэмжээнд 2021 оны байдлаар нийт 1151476 газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч бүртгэгдсэн ба үүнээс 23235 нь буюу 2.0 хувь нь газрын зах зээлийн эргэлтэнд орсон байна. Энэ өмнөх оны мэдээтэй харьцуулахад 4.4 хувиар багассан дүнтэй байна.

Хүснэгт 1.7.3: Газар өмчлөгч, эзэмшигчийн эрхийн өөрчлөлт орсон байдал

Он	Газар эзэмших эрхийн өөрчлөлт	Үүнээс		Газар өмчлөх эрхийн өөрчлөлт	Үүнээс		
		Газар эзэмших эрхээ шилжүүлсэн	Газар эзэмших эрхээ барьцаалсан		Газар өмчлөх эрхээ худалдсан	Газар өмчлөх эрхээ бэлэглэсэн	Газар өмчлөх эрхээ барьцаалсан
2016 он	19445	10848	8597	42105	7284	3525	31296
2017 он	21968	10984	10984	52402	9117	3876	39409
2018 он	23585	11964	11621	104954	12036	4007	88911
2019 он	21933	17398	4535	62461	12902	3611	45948
2020 он	21221	16301	4920	49477	13620	3245	32612
2021 он	31051	16595	14456	64553	20896	3461	40196



Зураг 1.7.8: Газар өмчлөгч, эзэмшигчийн эрхийн өөрчлөлт орсон байдал

**291049** га газар буюу ойролцоогоор нийт газар нутгийн 0.2 хувь нь эдийн засгийн эргэлтэнд орсон байна. Харин газар өмчлөх, эзэмших эрхийн санхүүгийн эргэлтийн хэмжээ 1.4 их наяд төгрөг болж буурсан судалгаа гарсан байна.

Тухайн тайлант онд Үндэсний статистикийн хорооны гаргасан 2015 оны зэрэгцүүлэх үнээр Монгол улсын ДНБ<sup>2</sup> 27.0 их наяд төгрөгт ба үүнийг газрын санхүүгийн эргэлтийн

<sup>2</sup> [https://www.1212.mn/stat.aspx?LIST\\_ID=976\\_L05&year=2021](https://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L05&year=2021)

хэмжээтэй харьцуулахад ДНБ-ний 7.56% эзэлж газрын үр өгөөж нэмэгдэж байгаа дүн гарч байна.

Иргэн, хуулийн этгээд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас хэрэглээнд нэвтрүүлсэн Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-д нэвтэрч Газрын кадастрын мэдээллийн сангаас өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа газраа сонгон бусдад худалдах, түрээслэх зар мэдээллээ үнэ, төлбөргүйгээр байршуулж бусдад арилжаалах боломжтой болсон. Газар худалдан авах, хөрөнгө оруулалт хийх гэж буй иргэн, хуулийн этгээд тус системээс Газрын кадастр, Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, Газрын төлөв байдал, Инженер-геологи, Гео-экологийн талаарх газартай холбоотой бүх төрлийн мэдээ, мэдээллийг баталгаатай эх үүсвэрээс авч газарт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлсэн.

### **1.8. ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ДУУДЛАГА ХУДАЛДАА, ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭ, ТАЙЛАН**

Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа, газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг дараах тогтоол, журам аргачлалуудын дагуу улсын хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:

- Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”;
- Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал”;
- Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 182 дугаар тогтоол;
- Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 208 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал”.

#### *Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа*

Улсын хэмжээнд 2021 онд 2260 удаа газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулснаас 960 дуудлага худалдаа хүчинтэй болж, 34766.2 га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлжээ. Энэ нь өмнөх оныхтой харьцуулж үзвэл газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан тоо 840-ээр, эзэмшүүлсэн газрын хэмжээ 6121.64 га-гаар тус тус буурсан ч улсын төсөвт оруулсан орлогын хэмжээ 4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.


Булган, Баян-Өлгий, Баянхонгор, Дорноговь, Дорнод, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Хөвсгөл, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймгууд хамгийн олон буюу 100-аас дээш газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, бусад аймгууд 17-84 хооронд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулсан байна.

Хүснэгт 1.8.1: 2020-2021 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан байдал

№	Аймаг, нийслэл	Дуудлага худалдаа зохион байгуулсан тоо		Талбай /м2/		Төсөвт орсон орлого /мян.төг/	
		2020 он	2021 он	2020 он	2021 он	2020 он	2021 он
1	Архангай	124	79	5936292	4248015	565326.0	279091.0
2	Баян-Өлгий	90	119	299391	464676	182732.4	176129.0
3	Баянхонгор	178	102	21602176	710048	707183.4	231943.0
4	Булган	116	147	2994054	1683352	330755.0	248278.0
5	Говь-Алтай	86	43	1236911	30687	231218.0	71852.0
6	Говьсүмбэр	15	17	186800	1568555	145189.0	1060822.0
7	Дархан-Уул	22	53	174828	539370	139000.0	221216.0
8	Дорноговь	211	137	10152875	9046006	2981539.8	3009684.0
9	Дорнод	94	112	2800566	21048068	192129.0	1195884.0
10	Дундговь	88	52	140777	86469	87058.0	67033.0
11	Завхан	31	117	36155	2763155	33111.6	98976.0
12	Орхон	21	22	699847	338006	214277.0	700556.0
13	Өвөрхангай	56	132	5450055	4008844	233862.0	664321.0
14	Өмнөговь	61	65	511469	845629	358394.0	1284707.0
15	Сүхбаатар	72	133	273298	2058174	354037.4	298072.0
16	Сэлэнгэ	102	183	2321444	2916721	415377.7	681949.0
17	Төв	319	162	33737646	11725964	882681.9	1159728.0
18	Увс	62	37	113415	42570	467271.0	5683.0
19	Ховд	106	55	533832	378823	66128.2	189213.0
20	Хөвсгөл	66	97	549081	775978	224003.1	136346.0
21	Хэнтий	170	196	2064255	12375327	870569.8	947214.0
22	Нийслэл	192	191	1722979	1538907	699789.0	1679450.0
23	Чөлөөт бүс	-	9	-	66000	-	324029.5
<b>ДҮН</b>		<b>2282</b>	<b>2260</b>	<b>95982634</b>	<b>79259344</b>	<b>10381633.3</b>	<b>14732176.5</b>

Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа явуулсан тоог аймаг, нийслэлээр харьцуулан дараах зурагт үзүүлэв /Зураг 1.8.1/.






Зураг 1.8.1: 2020 он, 2021 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа явуулсан тоо


Тайлант онд нийт 2260 удаагийн дуудлага худалдааг зохион байгуулснаас 1306 удаагийн буюу 59.1 хувь нь хүчингүй болсон ба үүнээс 919 удаагийн буюу 67.5 хувь нь оролцогчгүйн улмаас хүчингүй болж, 342 удаагийн буюу нийт зохион байгуулсан дуудлага худалдааны 15.1 хувь нь дуудлага худалдааны үнийг “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-д заасан хугацаанд төлөөгүй байна.

Мөн дуудлага худалдаанд оролцогч ирээгүй тохиолдол 39.8 хувь болж 7.0 хувиар буурсан, 1 оролцогч оролцсон тохиолдол 9.8 хувь болж 0.2 хувиар буурсан, 2 оролцогч оролцсон тохиолдол 24.7 хувь болж 2.5 хувиар нэмэгдсэн, 2-оос дээш оролцогч оролцсон тохиолдол 24.0 хувь болж 3.0 хувиар нэмэгдсэн байна /Зураг 1.8.2/.




Зураг 1.8.2: Дуудлага худалдааны оролцогчийн эзлэх хувь

Шинэчлэн батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-д цахим хэлбэрээр дуудлага худалдааг зохион байгуулахаар журамласны дагуу 2021 онд улсын хэмжээнд дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна /Зураг 1.8.3/




Зураг 1.8.3: 2021 онд цахим хэлбэрээр зохион байгуулсан дуудлага худалдаа

Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар 2021 онд нийт 14 тэрбум 732 сая 176 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээс Улаанбаатар хотод хэмжээнд 1 тэрбум 679.4 сая төгрөг буюу 11.6 хувь, Дорноговь аймгаас 20.9 хувь буюу 3 тэрбум 9.6 сая төгрөг, Төв аймгаас 8.0 хувь буюу 1 тэрбум 159.7 сая төгрөг, Өмнөговь аймгаас 8.9 хувь буюу 1 тэрбум 284.7 сая төгрөгийг тус тус төвлөрүүлснээр тэргүүлж байна /Зураг 1.8.4/.



Зураг 1.8.4: 2020 он, 2021 онд улсын хэмжээнд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын төсөвт орсон орлого /тэрбум төгрөгөөр/

Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааны орлогоос 2020 онд орон нутгийн төсөвт 10.4 тэрбум төгрөг төвлөрүүлж байсан бол уг дүн 2021 онд 4.7 тэрбумаар нэмэгдэж, 14.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд сүүлийн 10 жилд дуудлага худалдааны орлого тогтмол нэмэгдсэн байна /Зураг 1.8.5/.



Зураг 1.8.5: 2010-2021 онд улсын хэмжээнд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын төсөвт орсон орлого /тэрбум.төг/

Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааг танхимаар зохион байгуулж байх үед жилд дунджаар 4 тэрбум төгрөг улсын төсөвт ордог байсан бол Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг 2016 оноос эхлэн хэрэглээнд нэвтрүүлсэнээс хойш дуудлага худалдааг цахимаар зохион байгуулдаг болсноор дуудлага худалдаанаас улсын төсөвт орох орлогын хэмжээ нэмэгдэж 2021 оны байдлаар дуудлага худалдааны орлого 14.7 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. Нийт дуудлага худалдааны орлогын 93.5 хувийг цахимаар зохион байгуулсан дуудлага худалдаанаас, 6.5 хувийг танхимаар зохион байгуулсан дуудлага худалдаанаас бүрдсэн байна.


Газар эзэмшүүлэх эрхийн төсөл сонгон шалгаруулалт

Улсын хэмжээнд 2021 онд нийслэл, Архангай, Дархан-Уул, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Увс, Хөвсгөл, Хэнтий аймагт 58 удаа газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулснаас 31 хүчинтэй болж 318.7 га газрыг эзэмшүүлжээ. Энэ нь өмнөх онтой харьцуулж үзвэл газар эзэмшүүлэх эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан тоо 21-ээр нэмэгдсэн бол эзэмшүүлсэн газрын хэмжээ 159.7 га-аар өссөн байна. /Хүснэгт 1.8.2/.

Хүснэгт 1.8.2: 2021 оны газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтын мэдээ


№	Аймаг, нийслэл	Төсөл сонгон шалгаруулалт явуулсан тоо		Төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлсэн газрын талбайн хэмжээ /м2/	
		2020 он	2021 он	2020 он	2021 он
1	Архангай	-	2	-	-
7	Дархан-Уул	-	12	-	727800
11	Завхан	-	5	-	313200
13	Өвөрхангай	-	4	-	40000
14	Өмнөговь	-	7	-	14600
17	Төв	2	18	112053	1673000
18	Увс	20	2	195051	-
19	Ховд	8	-	53995	-
20	Хөвсгөл	3	1	42207	10000
21	Хэнтий	4	2	1187026	208900
22	Нийслэл	-	5	-	200400
<b>ДҮН</b>		<b>37</b>	<b>58</b>	<b>1590332</b>	<b>3187900</b>

Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт явуулсан тоог аймаг, нийслэлээр харьцуулж харуулав /Зураг 1.8.6/.



Зураг 1.8.6: 2020-2021 онд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт явуулсан тоо

Тайлант онд 58 газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулснаас 15 удаагийн буюу 25.8 хувь нь төсөл ирээгүйн улмаас хүчингүй болжээ /Зураг 1.8.7/.




Зураг 1.8.7: Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан байдал

Газрын тухай хуулийн 33.5.-д “Энэ хуулийн 33.1.2-т заасны дагуу төсөл шалгаруулах хэлбэрээр газар эзэмших эрхийг зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эсхүл гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт зориулж олгоно” гэж 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2018 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн тул сүүлийн жилүүдэд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтын тоо буурсан байна.

Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлсэн хугацааны хувьд авч үзвэл ихэвчлэн 15 жилээр эзэмшүүлсэн байна.

### 1.9. СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНД АШИГЛУУЛЖ БУЙ ГАЗРЫН ТАЙЛАН

Улсын хэмжээнд нийт 1207 Сууц өмчлөгчдийн холбоо үйл ажиллагаа явуулж байгаагаас нийслэлд 1062, орон нутагт 145 бүртгэгдсэн байна. 2009 оноос хойшхи СӨХ-ны бүртгэгдсэн байдлыг дараах зурагт харуулав /Зураг 1.9.1/.



Зураг 1.9.1. СӨХ-ны тоо

Хүснэгт 1.9.1. СӨХ-ны орчны газрын баталгаажилтын явц /Улсын хэмжээнд/

Д/Д	Аймаг	Нийт СӨХ-ны тоо	Тооллогонд хамрагдсан СӨХ-ны тоо	Газар ашиглахаар хүсэлт гаргасан СӨХ-ны тоо	Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажсан	Захирамжаар баталгаажигдсан СӨХ-оос газар ашиглах эрхийн гэрээ байгуулсан	Нийт СӨХ-ны ашиглаж байгаа талбайн хэмжээ /м2/	Үүнээс				
								Маргаантай болон судалж байгаа	Захирамж гарахаар хүлээгдэж байгаа	Ерөнхий төлөвлөгөө хийгдэж байгаа СӨХ-ны тоо	Ерөнхий төлөвлөгөө хийгдсэн СӨХ-ны тоо	
1	Архангай	1	-	-	1	1	47900.0	0	11	0	0	
2	Булган	1	-	-	1	1	32197.9					
3	Говь-Алтай	5	-	-	5	5	51000.0	0	0	0	0	
4	Говьсүмбэр	2	-	-	2	2	123334.0	-	-	-	-	
5	Дархан-Уул	41	37	10	31	19	577706.0	2	5	7	37	
6	Дорнод	15			9	9	160579.0	-	-	-	-	
7	Дорноговь	23	23	3	12	12	255671.4	-	-	2	-	
8	Дундговь	1		1			15700					
9	Орхон	27	6	-	21	21	824500.0	-	-	-	-	
10	Өвөрхангай	4	0	0	0	4	33415.0	-	-	-	-	
11	Өмнөговь	2	-	-	2	2	9351.7	-	-	-	-	
12	Сүхбаатар	1	1	0	1	1	3500.0	-	-	-	-	
13	Сэлэнгэ	19	-	-	19	19	207506.0	-	-	-	-	
14	Хөвсгөл	3		3	2	3	58784.5					
15	Нийслэл	1062	482	40	1062	794	1394771		15			
<b>Нийт</b>		<b>1207</b>	<b>549</b>	<b>58</b>	<b>1153</b>	<b>893</b>	<b>3795915.6</b>	<b>2</b>	<b>31</b>	<b>9</b>	<b>37</b>	

Тайлант оны байдлаар улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт **1207** СӨХ-ны **1153** нь орчны газраа ашиглах эрхээ аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажуулж, **379.6** га газрыг ашиглуулахаар гэрээ байгуулсан байна.

Баянхонгор, Баян-Өлгий, Завхан, Төв, Увс, Ховд, Хэнтий аймгуудад орчны газраа баталгаажуулан ашиглаж буй Сууц өмчлөгчдийн холбоо бүртгэгдээгүй байна.

## 1.10. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН 2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ


### 1.10.1. Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт

*Хот, тосгон, бусад суурин газрын төлөвлөгөөний хэрэгжилт*

Улсын хэмжээнд сумдын газар зохион байгуулалтын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хот, тосгон бусад суурины ангиллын газарт нийт **61475** байршил бүхий **69.9** мянган га газрыг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар нийт **26071** байршилд **29.4** га газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.


*Хүснэгт 1.10.1.1. Хот, тосгон бусад суурины ангиллын газар дахь газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал*

№	Аймаг, нийслэл	Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөө		Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь % байршлаар
		Байршлын тоо	Газрын хэмжээ /га/	Байршлын тоо	Газрын хэмжээ /га/	
1	065: Архангай	750	484.23	451	272.55	60.13
2	064: Баянхонгор	971	4287.27	347	3187.4	35.74
3	083: Баян-Өлгий	5245	531.4	637	67.31	12.14
4	063: Булган	1835	579.47	1253	500.93	68.28
5	082: Говь-Алтай	764	268.37	452	177.98	59.16
6	042: Говьсүмбэр	37	261.57	29	87.9	78.38
7	045: Дархан-Уул	354	107.12	169	12.95	47.74
8	021: Дорнод	1217	33867.35	588	12596.49	48.32
9	044: Дорноговь	1363	1627.73	682	1481.51	50.04
10	048: Дундговь	2092	10304.67	1223	1564.17	58.46
11	081: Завхан	1013	132.66	533	58.95	52.62
12	061: Орхон	1031	90.84	510	53.66	49.47
13	062: Өвөрхангай	3488	397.93	732	129.95	20.99
14	046: Өмнөговь	4874	2913.12	794	1062.25	16.29
15	022: Сүхбаатар	2020	849.28	621	62.41	30.74
16	043: Сэлэнгэ	5217	1849.53	1484	567.65	28.45
17	041: Төв	6431	1644.5	1321	347.92	20.54
18	085: Увс	704	3272.41	296	2853.05	42.05
19	084: Ховд	1225	486.18	720	313.02	58.78
20	067: Хөвсгөл	1372	293.59	834	219.1	60.79
21	023: Хэнтий	2191	3885.87	1762	2782.72	80.42
22	011: Улаанбаатар	17281	1827.58	10633	1032.4	61.53
Нийт		<b>61475</b>	<b>69962.67</b>	<b>26071</b>	<b>29432.27</b>	<b>42.41</b>



Зураг 1.10.1.1: Хот, тосгон бусад суурин газрын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн байршлын тоо





Зураг 1.10.1.2: Хот, тосгон бусад суурин газрын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт /га-гаар/

Дээрх графикаас харахад Сүхбаатар аймгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагадуул уурхайн зориулалтаар ашиглуулахаар нийт 626.94 га газрыг төлөвлөсөн боловч олголт хийгдээгүй, мөн Дорнод аймаг шинээр эзэмшүүлэх тариалангийн газар 1.4 га газрыг, түүх соёлын дурсгалт газрыг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх бүс дэх газар аялал жуулчлалын зориулалттай 14 га газрыг, Сэлэнгэ аймгийн хэмжээнд тариалангийн зориулалттай эзэмшүүлэхээр 675.19 га, амралт, аялал жуулчлалын бүс байгуулахаар 2 га газрыг, Өвөрхангай аймгийн хэмжээнд усалгаатай нөхцөлд төмс, хүнсний ногоо тариалах газрын төлөвлөлт 10.9 га газрыг, Баян-Өлгий аймгийн хэмжээнд уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж 15.42 га газрыг тус тус төлөвлөсөн бөгөөд хэрэгжээгүй байгаа нь 2022 оны жилийн төлөвлөгөөг тооцоо судалгаатай, үндэслэлтэй төлөвлөх шаардлагатай байгааг харуулж байна.

Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний хот, тосгон, бусад суурины ангиллын газарт дараах аймгууд хангалттай сайн хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

Хэнтий аймаг 80.42 хувь, Говьсүмбэр аймаг 78.38 хувь, Булган аймаг 68.28 хувь, Улаанбаатар аймаг 61.53 хувь, Хөвсгөл аймаг 60.79 хувь, Архангай аймаг 60.13 хувь, Говь-Алтай 59.16 хувь, Ховд аймаг 58.78 хувь, Дундговь аймаг 58.46 хувь, Завхан аймаг 52.62 хувь, Дорноговь аймаг 50.04 хувь тус тус хангалттай хэрэгжүүлж ажилласан байна. Харин Орхон аймаг 49.47 хувь, Дорнод аймаг 48.32 хувь, Дархан-Уул аймаг 47.74, Увс аймаг 42.05 хувь, Баянхонгор аймаг 35.74 хувь, Сүхбаатар аймаг 30.74 хувь, Сэлэнгэ аймаг 28.45 хувь, Өвөрхангай аймаг 20.99 хувь, Төв аймаг 20.54 хувь, Өмнөговь аймаг 16.29 хувь, Баян-Өлгий аймаг 12.14 хувьтай тус тус хэрэгжсэн байна.

Аймгуудын нийтлэг төлөвлөн хэрэгжүүлж байгаа арга хэмжээг нэгтгэн харьцуулж үзвэл:


- Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлэх газар 34.71 хувь;
- Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байгаа газрыг өмчлөх газар 7.3 хувь;
- Улсын чанартай зам дагуу өмчлүүлэх газар 15.21 хувь;
- Гэр, орон сууцны хашааны зориулалтаар эзэмшүүлэх газар 57.7 хувь;
- Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд олгох газар 61.07 хувь;
- Худалдаа, үйлчилгээний зориулалтаар олгох газар 49.73 хувь;
- Гэр бүлийн хэрэгцээнд зориулан эзэмших төмс, хүнсний ногооны талбай 28.63 хувь;

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дуудлага худалдаагаар эзэмшүүлэх газар 57.56 хувь тус тус хэрэгжсэн байна.

Нийт хот тосгон бусад суурины газрын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө **42.41** хувьтай хэрэгжсэн байна /Хүснэгт 1.10.1.2/.

Хүснэгт 1.10.1.2: 2020, 2021 онуудын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувийг /байршлаар/ харьцуулсан байдал

№	Аймаг, нийслэл	2020 он /%/	2021 он /%/
1	Архангай	79.37	60.13
2	Баянхонгор	27.16	35.74
3	Баян-Өлгий	39.76	12.14
4	Булган	72.49	68.28
5	Говь-Алтай	58.22	59.16
6	Говьсүмбэр	80.49	78.38
7	Дархан-Уул	83.52	47.74
8	Дорнод	50.8	48.32
9	Дорноговь	50.29	50.04
10	Дундговь	51.52	58.46
11	Завхан	39.7	52.62
12	Орхон	42.79	49.47
13	Өвөрхангай	20.91	20.99
14	Өмнөговь	87.98	16.29
15	Сүхбаатар	32.85	30.74
16	Сэлэнгэ	13.11	28.45
17	Төв	37.15	20.54
18	Увс	48.15	42.05
19	Ховд	20.88	58.78
20	Хөвсгөл	37.82	60.79
21	Хэнтий	45.4	80.42
22	Улаанбаатар	95.4	61.53
	<b>Нийт</b>	<b>50.72</b>	<b>42.41</b>




Зураг 1.10.1.3: 2020, 2021 онуудад газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувийг байршлаар харьцуулсан байдал

*Хөдөө аж ахуйн газрын төлөвлөгөөний хэрэгжилт*

Улсын хэмжээнд сумдын газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний хөдөө аж ахуйн ангиллын газарт нийт **12985** байршил бүхий **5.7** сая га газрыг төлөвлөснөөс **5460** байршилд **5.3** сая га газрыг эзэмшүүлэх болон өмчлүүлэх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. /Хүснэгт 1.10.1.3/

*Хүснэгт 1.10.1.3: Хөдөө аж ахуйн ангиллын газар дахь 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал*

№	Аймаг, нийслэл	Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөө		Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь % байршлаар
		Байршлын тоо	Газрын хэмжээ /га/	Байршлын тоо	Газрын хэмжээ /га/	
1	Архангай	63	5059.19	1	46	1.59
2	Баянхонгор	767	3302773.47	350	3302086.34	45.63
3	Баян-Өлгий	674	174.55	102	10.79	15.13
4	Булган	478	50180.48	359	46898.38	75.10
5	Говь-Алтай	486	16165.98	391	15937.91	80.45
7	Дархан-Уул	23	39.37	17	29.65	73.91
8	Дорнод	1337	189320.9	689	26490.45	51.53
9	Дорноговь	119	160.83	113	153.53	94.96
10	Дундговь	284	70263.19	126	70202.45	44.37
11	Завхан	894	393319.15	295	391686.5	33.00
12	Орхон	9	4.12	8	3.12	88.89
13	Өвөрхангай	508	185290.59	284	182471.65	55.91
14	Өмнөговь	252	308888.75	134	308840.54	53.17
15	Сүхбаатар	248	424473.61	77	424333.52	31.05
16	Сэлэнгэ	561	7490.59	177	6303.75	31.55
17	Төв	2855	159037.74	437	8533.3	15.31
18	Увс	561	447608.02	238	425972.25	42.42
19	Ховд	702	115868.25	417	99898.51	59.40
20	Хөвсгөл	1392	28054.16	682	27489.79	48.99
21	Хэнтий	687	36173.5	542	8133.57	78.89
22	Улаанбаатар	58	301.46	21	3.9	36.21
<b>Нийт</b>		<b>12958</b>	<b>5740647.9</b>	<b>5460</b>	<b>5345525.9</b>	<b>50.36</b>



Зураг 1.10.1.5: Хөдөө аж ахуйн газрын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт, га-гаар

Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөг хөдөө, аж ахуйн ангиллын газарт дараах аймгууд хангалттай сайн хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

Дорноговь аймаг 94.96 хувь, Орхон аймаг 88.89 хувь, Говь-Алтай аймаг 80.45 хувь, Хэнтий аймаг 78.9 хувь, Булган аймаг 75.10 хувь, Дархан-Уул аймаг 73.91 хувь, Ховд аймаг 59.40 хувь, Өвөрхангай аймаг 55.91 хувь, Өмнговь аймаг 53.7 хувь, Дорнод аймаг 51.3 хувь, тус тус хангалттай хэрэгжүүлж ажилласан байна.

Харин Хөвсгөл аймаг 48.99 хувь, Баянхонгор аймаг 45.63 хувь, Дундговь аймаг 44.37 хувь, Увс аймаг 42.4 хувь, Завхан аймаг 33 хувь, Сэлэнгэ аймаг 31.55 хувь, Сүхбаатар аймаг 31.05, Сүхбаатар аймаг 31.05 хувь, Төв аймаг 15.31 хувь, Баян-Өлгий аймаг 15.13 хувь, Архангай аймаг 1.59 хувьтай тус тус хэрэгжсэн байна.

Архангай аймгийн хэмжээнд ХАА-н газрын зориулалтаар нийт 5059 га газрыг төлөвлөн 1 га газрыг эзэмшүүлж, ашиглуулж, хамгаалах арга хэмжээ авсан байна. Үүнээс хортон, мэрэгчтэй тэмцэх бэлчээр 264.96 га, сумын отрын нөөц бэлчээр 2300.4 га, зун-намрын бэлчээр 2218.29 га газрыг төлөвлөсөн боловч жилийн эцсийн байдлаар хэрэгжээгүй байна.


Баян-Өлгий аймгийн хэмжээнд ХАА-ын газрын зориулалтаар нийт 174.55 га газрыг төлөвлөсөн ба жилийн эцсийн байдлаар 10.79 га газрыг эзэмшүүлж, ашиглуулж, хамгаалах арга хэмжээ авсан байна. Эзэмшүүлэх хадлан, тордон сайжруулах хадлан, хашиж хамгаалах хадлан, усалгаатай нөхцөлд төмс, хүнсний ногоо тариалах газаруудыг төлөвлөсөн боловч хэрэгжээгүй байна. Иймээс Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахдаа эхнээсээ үнэн бодит, үндэслэлтэй боловсруулж байх шаардлагатай байна.

Улсын хэмжээнд нийт хөдөө аж ахуйн ангиллын газрын хэрэгжилт **50.28 хувьтай** хэрэгжсэн байна /Хүснэгт 1.10.1.4/.

Хүснэгт 1.10.1.4: 2020, 2021 онуудын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний ХАА-ын ангиллын газрын хэрэгжилт байршлаар хувийг харьцуулсан байдал

д/д	Аймаг, нийслэл	2020 он	2021 он
1	Архангай	87.64	1.59
2	Баянхонгор	44.43	45.63
3	Баян-Өлгий	49.19	15.13
4	Булган	74.16	75.10
5	Говь-Алтай	83.65	80.45
6	Говьсүмбэр	100.00	0.00
7	Дархан-Уул	92.21	73.91
8	Дорнод	69.33	51.53
9	Дорноговь	92.44	94.96
10	Дундговь	44.48	44.37
11	Завхан	68.17	33.00
12	Орхон	0.00	88.89
13	Өвөрхангай	89.49	55.91

14	Өмнөговь	69.96	53.17
15	Сүхбаатар	51.09	31.05
16	Сэлэнгэ	76.29	31.55
17	Төв	10.46	15.31
18	Увс	57.12	42.42
19	Ховд	6.18	59.40
20	Хөвсгөл	24.71	48.99
21	Хэнтий	86.99	78.89
22	Улаанбаатар	0.00	36.21
<b>Нийт</b>		<b>58.09</b>	<b>50.28</b>



Зураг 1.10.1.6: Хөдөө аж ахуйн газрын 2020, 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт байршлаар /хувиар/

Тусгай хэрэгцээний газар, ойн сан, усны сан бүхий газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

Улсын хэмжээнд сумдын газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний тусгай хэрэгцээний газар, ойн сан, усны сан бүхий газарт нийт **436** байршил бүхий **452.6** мянган га газрыг төлөвлөснөөс **243** байршилд **426.3** мянган га газрыг эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний тусгай хэрэгцээний газар, ойн сан, усны сан бүхий ангиллын газарт дараах аймгууд хангалттай сайн хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

Сүхбаатар аймаг 100 хувь, Баянхонгор аймаг 92.31 хувь, Дорнод аймаг 86.21 хувь, Өмнөговь аймаг 84.21 хувь, Өвөрхангай аймаг 79.55 хувь, Хэнтий аймаг 66.67 хувь, Увс аймаг 63.51 хувь, Дундговь аймаг 60.00 хувь, Булган аймаг 52.38 хувь, Завхан аймаг 52.17 хувьтай тус тус хангалттай хэрэгжүүлж ажилласан байна.

Харин Хөвсгөл аймаг 40 хувь, Сэлэнгэ аймаг 38.46 хувь, Баян-Өлгий аймаг 31.58 хувь, Архангай аймаг 26.67 хувь, Төв аймаг 17.65 хувь, Ховд аймаг 16.67 хувьтай тус тус хэрэгжүүлсэн байна.


Нийт Улсын хэмжээнд төлөвлөгөө **55.73** хувьтай хэрэгжсэн байна. /Хүснэгт 1.10.1.5/

Хүснэгт 1.10.1.5: Тусгай хэрэгцээний газар, ойн сан, усны сан бүхий газрын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал


№	Аймаг, нийслэл	Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөө		Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь, байршлаар
		Байршлын тоо	Газрын хэмжээ /га/	Байршлын тоо	Газрын хэмжээ /га/	
1	Архангай	15	16.39	4	5.24	26.67
2	Баянхонгор	13	57368.95	12	55829.76	92.31
3	Баян-Өлгий	19	38.89	6	3.65	31.58
4	Булган	21	89.75	11	75.62	52.38
7	Дархан-Уул	2	35.21	0	0	0.00
8	Дорнод	29	57.05	25	3	86.21
10	Дундговь	5	60.57	3	30.54	60.00
11	Завхан	23	60.93	12	21.78	52.17
13	Өвөрхангай	44	46.07	35	37.05	79.55
14	Өмнөговь	38	124.18	32	96.93	84.21
15	Сүхбаатар	8	343134.25	8	343134.3	100.00
16	Сэлэнгэ	13	39.39	5	3.01	38.46
17	Төв	51	14448.95	9	180.44	17.65
18	Увс	74	2843.02	47	2737	63.51



19	Ховд	12	36.05	2	8.67	16.67
20	Хөвсгөл	10	21.37	4	17.74	40.00
21	Хэнтий	42	34123.21	28	24210.26	66.67
22	Улаанбаатар	17	62.43	0	0	0.00
<b>Нийт</b>		<b>436</b>	<b>452606.66</b>	<b>243</b>	<b>426394.9</b>	<b>55.73</b>



Зураг 1.10.1.7: Тусгай хэрэгцээний газар, ойн сан, усны сан бүхий газрын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн га-гаар




Зураг 1.10.1.8: Тусгай хэрэгцээний газар, ойн сан, усны сан бүхий газрын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн байршлын тоогоор

*Зам, шугам сүлжээний зориулалтаар ашиглуулах газрын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт*


Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөнд нийт **272** байршилд **1263.6** га газар төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар **149** байршилд **488.3** га газрыг ашиглуулсан ба улсын хэмжээнд **54.7** хувьтай биелсэн байна /Хүснэгт 1.10.1.6/.

*Хүснэгт 1.10.1.6: Зам, шугам сүлжээний газрын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал*

№	Аймаг, нийслэл	Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөө		Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь % байршлаар
		Байршлын тоо	Газрын хэмжээ /га/	Байршлын тоо	Газрын хэмжээ /га/	
2	Баянхонгор	7	66.56	4	1	57.14
3	Баян-Өлгий	9	7.71	6	0.32	66.67
4	Булган	18	6.6	13	1.19	72.22
5	Говь-Алтай	5	0.23	4	0.19	80.00
7	Дархан-Уул	5	45.01	4	45	80.00
8	Дорнод	14	5.61	6	0.22	42.86
9	Дорноговь	7	147.68	4	0.49	57.14
10	Дундговь	3	60.09	1	0.02	33.33
11	Завхан	7	10.95	6	10.9	85.71
13	Өвөрхангай	9	0.49	6	0.09	66.67
14	Өмнөговь	73	275.6	55	204.23	75.34
15	Сүхбаатар	4	163.24	2	79.62	50.00
16	Сэлэнгэ	42	96.94	8	0.22	19.05
17	Төв	19	146.05	4	0.05	21.05
18	Увс	12	31.17	5	0.1	41.67
19	Ховд	1	10.99	0	0	0.00
20	Хөвсгөл	5	22.45	1	0	20.00
21	Хэнтий	13	124.94	11	124.88	84.62
22	Улаанбаатар	19	41.34	9	19.85	47.37
Нийт		272	1263.65	149	488.37	54.78



Зураг 1.10.1.9: Зам, шугам сүлжээний зориулалтаар ашиглуулах, хамгаалах газрын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн байршлын тоогоор



Зураг 1.10.1.10: Зам, шугам сүлжээний зориулалтаар ашиглуулах, хамгаалах газрын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт /га-гаар/

*Улсын хэмжээнд нийт газрын нэгдмэл сангийн ангиллын газрын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт*

Улсын хэмжээнд сумдын газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний газрын нэгдмэл сангийн бүх ангилалын газарт нийт **75156** байршил бүхий **6.2** сая га газрыг төлөвлөснөөс **31936** байршилд **5.8** сая га газрыг эзэмшүүлэх болон өмчлүүлэх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна /Хүснэгт 1.10.1.7/.

Мөн 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг дараах аймгууд хангалттай сайн хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

Хэнтий аймаг 79.88 хувь, Говьсүмбэр аймаг 78.38 хувь, Булган аймаг 69.53 хувь, Говь-Алтай аймаг 67.49 хувь, Улаанбаатар хот 61.39 хувь, Ховд аймаг 58.71 хувь, Дундговь аймаг 56.75 хувь, Архангай аймаг 55.07 хувь, Хөвсгөл аймаг 54.73 хувь, Дорноговь аймаг 53.66 хувь, Дорнод аймаг 50.35 хувьтай тус тус хангалттай хэрэгжүүлсэн байна.


Харин Орхон аймаг 49.81 хувь, Дархан-Уул аймаг 49.48 хувь, Завхан аймаг 43.68 хувь, Увс аймаг 43.38 хувь, Баянхонгор аймаг 40.56 хувь, Сүхбаатар аймаг 31.05 хувь, Сэлэнгэ аймаг 28.70 хувь, Өвөрхангай аймаг 26.11 хувь, Өмнөговь аймаг 19.47 хувь, Төв аймаг 18.93 хувь, Баян-Өлгий аймаг 12.63 хувьтай тус тус хэрэгжсэн байна.

Нийт улсын хэмжээнд 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт **42.5** хувьтай хэрэгжсэн байна.

*Хүснэгт 1.10.1.7: Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар*

№	Аймаг, нийслэл	Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөө		Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь % байршлаар
		Байршлын тоо	Газрын хэмжээ /га/	Байршлын тоо	Газрын хэмжээ /га/	
1	Архангай	828	5559.81	456	323.79	55.07
2	Баянхонгор	1758	3364496.25	713	3361104.5	40.56
3	Баян-Өлгий	5947	752.55	751	82.07	12.63
4	Булган	2353	51350.99	1636	47476.12	69.53
5	Говь-Алтай	1255	16434.58	847	16116.08	67.49
6	Говьсүмбэр	37	261.57	29	87.9	78.38
7	Дархан-Уул	384	226.71	190	87.6	49.48
8	Дорноговь	1489	1936.24	799	1635.53	53.66
9	Дорнод	2598	223513.64	1308	39090.16	50.35
10	Дундговь	2384	80688.52	1353	71797.18	56.75
11	Завхан	1937	393523.69	846	391778.13	43.68
12	Орхон	1040	94.96	518	56.78	49.81
13	Өвөрхангай	4049	185735.08	1057	182638.74	26.11
14	Өмнөговь	5243	312254.45	1021	310256.75	19.47
15	Сүхбаатар	2280	768620.38	708	767609.8	31.05
16	Сэлэнгэ	5833	9476.45	1674	6874.63	28.70

17	Төв	9356	175277.24	1771	9061.71	18.93
18	Увс	1351	453754.62	586	431562.4	43.38
19	Ховд	1940	116401.47	1139	100220.2	58.71
20	Хөвсгөл	2779	28391.57	1521	27726.63	54.73
21	Хэнтий	2933	74307.52	2343	35251.43	79.88
22	Улаанбаатар	17382	2235.5	10670	1058.84	61.39
Нийт		75156	6265293.79	31936	5801896.97	42.49



Зураг 1.10.1.11: Улсын хэмжээнд 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт /Байршлаар, хувиар/

Аймгийн хэмжээнд арга хэмжээний төрлөөр нэгтгэж үзэхэд Дорнод аймгийн хэмжээнд нийт 82, Сэлэнгэ аймгийн хэмжээнд нийт 76 арга хэмжээ, Өмнөговь аймгийн хэмжээнд нийт 74 арга хэмжээ, Баянхонгор аймгийн хэмжээнд нийт 72 арга хэмжээ, Төв аймгийн хэмжээнд нийт 70 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн нь хамгийн **их**, харин Говьсүмбэр аймгийн хэмжээнд нийт 6 арга хэмжээ, Орхон аймгийн хэмжээнд нийт 11 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байгаа нь хамгийн **бага**, аймгуудын **дундажийг** авч үзвэл 40-50 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Үүнээс харахад олон арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж байгаа аймгууд нь тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг газрын нэгдмэл сангийн ангиллын газруудыг бүрэн хамруулсан, мөн газар хамгаалах, нөхөн сэргээх болон газар зохион байгуулалтын бусад арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байгаа нь сайшаалтай байна.


Говьсүмбэр, Орхон, Дархан-Уул, Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар, Сэлэнгэ аймгууд нь газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлээгүй байна. Иймээс цаашид газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд зөвхөн эзэмших, ашиглах, өмчлөхөөс бусад зориулалтаар төлөвлөгөөг иж бүрэн хийж байх шаардлагатай байна.

**1.10.2. Улсын хэмжээнд нийт газрын нэгдмэл сангийн ангиллын газрын 2021 оны газар зохион байгуулалтын тодотголын төлөвлөгөөний хэрэгжилт**

Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөнд нийт 21 аймаг, Улаанбаатар хот тодотгол хийж, нийт **3567** байршил бүхий **404.2** мянган га газрыг төлөвлөснөөс **2069** байршилд **58.5** га газрыг эзэмшүүлж хэрэгжүүлсэн байна. Аймгууд нь арга хэмжээний 100 орчим төрлөөр төлөвлөн хэрэгжүүлсэн бөгөөд хамгийн их арга хэмжээг төлөвлөсөн Дорноговь, Сэлэнгэ, Орхон, Булган, Говь-Алтай, Өмнөговь, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгууд тус тус байна.

Хүснэгт 1.10.2.1: Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголын хэрэгжилт, хувиар

№	Аймаг, нийслэл	Газар зохион байгуулалтын 2021 оны тодотголын төлөвлөгөө		Газар зохион байгуулалтын 2021 оны тодотголын төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь, байршлаар
		байршлын тоо	Газрын хэмжээ /га/	Байршлын тоо	Газрын хэмжээ /га/	
1	Архангай	11	13.65	4	5.55	36.36
3	Баян-Өлгий	103	152.97	14	32.09	13.59
5	Говь-Алтай	194	33.97	52	19.03	26.80
6	Говьсүмбэр	10	17	5	6.52	50.00
7	Дархан-Уул	76	352.74	40	109.3	52.63
8	Дорнод	133	34795.85	70	7325.39	52.63
9	Дорноговь	789	19967.84	490	19358.01	62.10
10	Дундговь	22	205.36	20	205.29	90.91
11	Завхан	1	0.38	0	0	0.00
12	Орхон	563	43.57	349	30.07	61.99
13	Өвөрхангай	136	525.22	9	419.68	6.62
14	Өмнөговь	169	322627.7	142	8034.99	84.02
14	Булган	311	4825.36	256	4721.09	82.32
15	Сүхбаатар	156	63.5	23	53.57	14.74
15	Баянхонгор	41	62.77	29	58.88	70.73
16	Сэлэнгэ	564	15823.16	350	13990.36	62.06
17	Төв	39	4463.47	28	3908.95	71.79
19	Ховд	1	0.35	1	0.35	100.00
20	Хөвсгөл	10	14.04	9	13.04	90.00
21	Хэнтий	164	248.91	149	235.74	90.85
22	Улаанбаатар	74	6.38	29	3.81	39.19
	Нийт	3567	404244.2	2069	58531.71	58.00



Зураг 1.10.2.1: Газар зохион байгуулалтын 2021 оны тодотголын төлөвлөгөөний хэрэгжилт /байршлаар, хувиар/

Хөдөө аж ахуйн ангиллын газарт нийт **756** байршил бүхий **55.4** мянган га газрыг төлөвлөснөөс **388** байршилд **27.2** мянган га газрыг эзэмшүүлэх болон өмчлүүлэх, хамгаалах арга хэмжээг тодотгон хэрэгжүүлсэн байна. Аймагууд өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэхээр нийт **147** байршилд **65.4** га төлөвлөснөөс **137** байршилд **59.7** га газрыг тус тус эзэмшүүлсэн байна. Үүний Хэнтий аймаг **97** байршилд, Говь-Алтай аймаг **13** байршилд, Булган аймаг **17** байршилд, Дархан-Уул аймаг **10** байршилд тус тус төлөвлөжээ. Төмс, хүнсний ногоо тарих зориулалтаар шинээр эзэмшүүлэхээр нийт **174** байршилд **178.1** га төлөвлөсөнөөс **17** байршил, **5.8** га хэрэгжсэн байна. Үүнээс Өвөрхангай аймаг **103** байршилд, Сэлэнгэ аймаг **66** байршилд, Орхон аймаг аймаг **4** байршилд, Өмнөговь аймаг **1** байршилд тус тус төлөвлөжээ.

Харин хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор байгуулахаар Сүхбаатар, Өвөрхангай, Булган, Дархан-Уул, Өмнөговь, Төв аймагууд нийт **42** байршил бүхий **127.8** га газрыг төлөвлөснөөс **6** байршилд **43.7** га газрыг тус тус эзэмшүүлсэн байна.

Хот, тосгон бусад суурины ангиллын газарт нийт **2444** байршил бүхий **25.2** мянган га газрыг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар нийт **1433** байршилд **22.9** мянган га газрыг эзэмшүүлж тодотгон хэрэгжүүлсэн байна. Аймагуудын зонхилон төлөвлөсөн арга хэмжээг тодорхойлбол гэр, орон сууцны хашааны зориулалтаар эзэмшүүлэх газрыг Дорноговь, Орхон, Сэлэнгэ, Говь-Алтай, Булган, Баян-Өлгий, Баянхонгор, Өмнөговь аймагууд **1594** байршил бүхий **165.3** га газрыг төлөвлөснөөс **849** байршилд **56.2** га газрыг эзэмшүүлсэн байна.

Худалдаа, үйлчилгээний зориулалтаар олгох газар Дархан-Уул, Дорноговь, Сэлэнгэ, Булган, Баян-Өлгий, Төв аймгууд нийт **49** байршил бүхий **41.7** га газрыг төлөвлөснөөс **35** байршилд **20.5** га газрыг эзэмшүүлсэн байна.

Харин төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд олгох газар Говь-Алтай, Булган, Сэлэнгэ, Дорноговь, Баянхонгор, Төв, Хөвсгөл, Говьсүмбэр, Архангай, Баян-Өлгий аймгууд нийт **173** байршил бүхий **570.2** га газрыг төлөвлөснөөс **146** байршилд **534.7** га газрыг эзэмшүүлсэн байна.

Улсын тусгай хэрэгцээ, зам шугам сүлжээ, ойн сан бүхий газарт **293** байршил бүхий **323513.4** га газрыг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар нийт **219** байршилд **8356.7** га газрыг эзэмшүүлэх хэмжээг Булган, Сэлэнгэ, Өмнөговь, Дорноговь, Баян-Өлгий, Өвөрхангай, Дархан-Уул, Баянхонгор, Хөвсгөл, Говь-Алтай аймгууд хэрэгжүүлсэн байна. Улсын болон орон нутгийн төсөвт хөрөнгөд тусгагдсан зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээнээс бусад тохиолдолд төлөвлөгөөнд тодотгол хийхгүй байхыг анхаарах шаардлагатай байна.

**1.10.3. Улсын хэмжээний 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө**

Улсын хэмжээнд сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн 2022 оны төлөвлөгөөнд нийт **4.9** сая га газрыг төлөвлөсөн байна. Үүнээс хөдөө аж ахуйн ангиллын газарт нийт **2.7** сая га газрыг болон хот, тосгон бусад суурины газарт **128.7** мянган га газрыг, зам шугам, сүлжээний газарт **123.9** мянган га газрыг, бусад ангиллын газарт **1.9** сая га газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалахаар тус тус төлөвлөжээ /Хүснэгт 1.10.3.1/.

Хүснэгт 1.10.3.1: Сумдын газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ /газын хэмжээ га-аар/

№	Аймаг, нийслэлийн нэр	Нийт	Үүнээс			
			Хөдөө аж ахуйн газрын ашиглалт, хамгаалалтын 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан газрын хэмжээ /га-аар/	Хот, тосгон бусад суурины газрын ашиглалт, хамгаалалтын 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан газрын хэмжээ /га-аар/	Зам шугам, сүлжээний газрын ашиглалт, хамгаалалтын 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан газрын хэмжээ /га-аар/	Бусад ангиллын газрын 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан газрын хэмжээ /га-аар/
1	Архангай	2004.2588	659.1685	1247.8571	56.9427	40.2905
2	Баян-Өлгий	98029.1108	97143.9986	760.8331	16.621	107.6581
3	Баянхонгор	2304991.971	1459257.487	2534.5055	5.2872	843194.691
4	Булган	59825.3357	56247.4906	2364.6	1110.7261	102.519
5	Говь-Алтай	47316.382	41546.1533	961.9805	1465.7421	3342.5061
6	Говь-Сүмбэр	397.8875	1.05	396.8375	0	0




7	Дархан-Уул	743.9196	117.8385	146.6032	0.7194	478.7585
8	Дорноговь	16767.9738	183.4536	16292.9768	223.2667	68.2767
9	Дорнод	280735.2219	261465.091	14889.4971	1319.1338	3061.5
10	Дундговь	398429.8434	2524.7812	2854.5998	115004.5085	278045.9539
11	Завхан	12748.9145	12345.9713	323.9242	0.2469	78.7721
12	Орхон	238.4783	77.8316	127.506	0	33.1407
13	Өвөрхангай	231778.9227	228893.6331	2666.2277	129.491	89.5709
14	Өмнөговь	436034.759	159.1671	66834.327	3327.3895	365713.8754
15	Сүхбаатар	418552.0839	169.599	181.9371	5.3038	418195.244
16	Сэлэнгэ	16759.4744	14095.9638	1805.5544	395.5657	462.3905
17	Төв	279403.6829	273086.7895	5244.7678	702.8123	369.3133
18	Увс	134585.7319	131767.0813	2146.348	54.323	617.9796
19	Ховд	7096.7241	5226.21	1382.2912	50.9245	437.2984
20	Хөвсгөл	80414.5921	79591.1848	584.262	13.332	225.8133
21	Хэнтий	44787.514	42351.0392	1992.9701	3.5354	439.9693
22	Улаанбаатар	3823.5908	433.3887	2989.1992	29.2818	371.7211
	<b>Нийт дүн</b>	<b>4875466.373</b>	<b>2707344.372</b>	<b>128729.6053</b>	<b>123915.1534</b>	<b>1915477.242</b>

Улсын хэмжээнд сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд нийт **84638** байршилд төлөвлөсөн байна. Үүнээс хөдөө аж ахуйн ангиллын газарт нийт **14729** байршилд, хот, тосгон бусад суурины газарт **67987** байршилд, зам шугам, сүлжээний газарт **694** байршилд, бусад ангиллын газарт **1228** байршилд тус тус төлөвлөжээ /Хүснэгт 1.10.3.2/.


Хүснэгт 1.10.3.2: Сумдын газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан байршлаар

№	Аймаг, нийслэлийн нэр	Нийт	Үүнээс			
			Хөдөө аж ахуйн газрын ашиглалт, хамгаалалтын 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан байршлын тоо	Хот, тосгон бусад суурины газрын ашиглалт, хамгаалалтын 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан байршлын тоо	Зам шугам, сүлжээний газрын ашиглалт, хамгаалалтын 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан байршлын тоо	Бусад ангиллын газрын 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан байршлын тоо
1	Архангай	2752	214	2519	12	7
2	Баян-Өлгий	4842	2894	1925	5	18
3	Баянхонгор	1792	410	1359	13	10
4	Булган	2664	452	2024	122	66
5	Говь-Алтай	1181	454	634	22	71
6	Говьсүмбэр	315	15	300		0
7	Дархан-Уул	182	76	89	3	14

8	Дорноговь	1218	290	886	40	2
9	Дорнод	4106	1338	2680	14	74
10	Дундговь	2204	334	1808	45	17
11	Завхан	2145	1097	998	6	44
12	Орхон	1163	58	1097		8
13	Өвөрхангай	2948	605	2278	38	27
14	Өмнөговь	3379	175	2938	89	177
15	Сүхбаатар	1556	62	1482	5	7
16	Сэлэнгэ	3345	1319	1734	79	213
17	Төв	10165	1342	8726	48	49
18	Увс	1669	749	805	23	92
19	Ховд	2364	730	1456	25	153
20	Хөвсгөл	2617	1281	1263	49	24
21	Хэнтий	2706	711	1943	15	37
22	Улаанбаатар	29325	123	29043	41	118
<b>Бүгд</b>		<b>84638</b>	<b>14729</b>	<b>67987</b>	<b>694</b>	<b>1228</b>




Зураг 1.10.3.1: 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, га-аар



Зураг 1.10.3.2: 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө байршлаар / Газрын нэгмдэл сангийн ангиллаар хувиар/

Улсын хэмжээнд сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд арга хэмжээний төрлөөр дараах байдлаар төлөвлөсөн байна. Үүнээс өргөдлийн дагуу олгох нийт **84846** байршилд 93.45%, дуудлага худалдаагаар олгох **3155** байршилд 3.47%, төсөл сонгон шалгаруулалтаар олгох **246** байршилд 0.27%, газар хамгаалах, нөхөн сэргээхээр **833** байршилд 0.92%, газар чөлөөлөх **437** байршилд 0.48 %, нийтийн эдэлбэрийн газарт 2113 байршилд 2.33 % тус тус төлөвлөжээ.



Зураг 1.10.3.3: 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө арга хэмжээний төрлөөр

#### 1.10.4. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний нэгдсэн мэдээллийн цахим систем

Барилга хот байгуулалтын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГЗБГЗЗГ хамтран Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний нэгдсэн мэдээллийн системийг нэвтрүүллээ. Энэхүү мэдээллийн систем нь газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих зэрэг үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй, оролцоонд түшиглэсэн болгож байгаагаараа онцлог юм.

Уг ажлыг Монгол Улсын Засгийн Газар, БХБЯ, ГЗБГЗЗГ-аас 2015 оноос эхлэн санаачлан, УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусган /2.81.12. Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим системийг байгуулах/ хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2020 оны 01 дүгээр сард хэрэглээнд нэвтэрсэн.

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системээр дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

1. Улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө,

нийслэл сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон бусад салбарын орон зайн төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

2. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний талаарх мэдээлэл, зураг төслөөр иргэд, олон нийтэд үйлчлэх, тэдний саналыг авч оролцоог хангах.

Энэхүү систем нь зам, шугам сүлжээ, инженерийн барилга, байгууламж, үйлдвэр уурхай, хөдөө аж ахуй хөгжүүлэх газрын байршил гэх мэт улс орны ирээдүйн хөгжлийн чиг хандлагын талаар мэдээллийг улсын хэмжээнд авахаас гадна, өөрийн амьдарч буй орчныг сайжруулах, гэр бүлийн болон бизнесийн зорилгоор газар эзэмших, өмчлөх, ашиглах зэрэг санал хүсэлтээ бүх төрлийн интернэтэд холбогдох боломжтой төхөөрөмжөөр дамжуулан Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, кадастрын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, баталгаажуулах боломж нээгдэх юм.

Тухайн систем нэвтэрснээр газрын харилцааны бүхий л асуудал зөвхөн газар зохион байгуулалтын төлөвлөлтөөр дамжин хэрэгжих нөхцөлийг бий болгох бөгөөд улмаар газрыг төлөвлөлтгүй, эмх замбараагүй олгож, газрын зөрчил, маргаан үүсгэж иргэдийн эрх ашгийг хохироох аливаа асуудалд цэг тавихаас гадна, салбарууд хоорондын уялдаагүй байдлаас үүдсэн давхардсан төлөвлөлт, үргүй зардлыг бууруулж, газарт оруулж буй хөрөнгө оруулалтыг илүү эрсдэлгүй, баталгаатай болгож байгаа юм.

Мөн түүнчлэн газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн төлөвлөгөөний цахим системийг ашиглан хөдөө аж ахуй, байгаль орчин, хот байгуулалт, үйлдвэр уурхай, зам, шугам сүлжээ, батлан хамгаалах зэрэг нийгэм, эдийн засгийн бүхий л салбарын төрийн байгууллагууд хамтран орон зайн хувьд давхардалгүй, харилцан уялдаатай нэгдсэн төлөвлөгөө хийх бүрэн боломжтой.

Тухайн системээс жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөлт, хэрэгжилтийн тайланг сум, дүүргийн хэмжээнд, аймаг, нийслэл, Улсын хэмжээнд тус бүрээр улирлаар, хагас жил, бүтэн жилээр гаргах боломжтой болсон бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрэгжээгүй тохиолдолд биелэлтийг оруулах боломжгүй тул төлөвлөгөөний тайлан мэдээллийг цаг тухай бүрд үнэн бодит гарах нөхцөл бүрдээд байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн төлөвлөгөөний цахим системд [www.egazar.gov.mn](http://www.egazar.gov.mn) хаягаар хандан мэдээлэл авч, саналаа өгөх боломжтой. Үүний тулд эхлээд ДАН системээр дамжуулан нэвтрэх бөгөөд хайлтын хэсгээс саналаа өгөх газрын байрлаж буй аймаг, нийслэл, сум, дүүргийг төлөвлөгөөний төрлийн хамт сонгож, тухайн байршилтай холбоотой бусад төлөвлөгөө, газар ашиглалтын мэдээлэлтэй уялдуулан газрыг эзэмших, ашиглах, өмчлөх, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр саналаа өгөх боломжтой болсон.




# 2

## ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТАЙЛАН

### 2.1. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ҮНДСЭН АНГИЛАЛ, ГАЗАР АШИГЛАЛТЫН ТӨРӨЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, ШИЛЖИЛТИЙН ҮНДЭСЛЭЛ /МАЯГТ ГТ-1, 5/

Монгол Улсын газрын нэгдмэл санд хөдөө аж ахуйн газар 113980.0 мянган га буюу 72.9 хувь, хот, тосгон бусад суурины газар 956.2 мянган га буюу 0.6 хувь, зам, шугам сүлжээний газар 477.2 мянган га буюу 0.3 хувь, ойн сан бүхий газар 14256.6 мянган га буюу 9.1 хувь, усны сан бүхий газар 660.9 мянган га буюу 0.4 хувь, улсын тусгай хэрэгцээний газар 26080.7 мянган га буюу 16.7 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.1/



Зураг 2.1.1: Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын тус бүрийн эзлэх хувь

Газрын нэгдмэл сангийн 2021 оны тайлангийн дүнг 2020 оны дүнтэй харьцуулахад хөдөө аж ахуйн газар 61.8 мянган га-гаар хасагдаж, хот тосгон, бусад суурины газар 38.6 мянган га, зам, шугам сүлжээний газар 2.4 мянган га, ойн сан бүхий газар 0.7 мянган га, улсын тусгай хэрэгцээний газар 20.0 мянган га-гаар тус тус нэмэгдсэн байна. Усны сан бүхий газарт өөрчлөлт ороогүй байна /Хүснэгт 2.1.1/.

Хүснэгт 2.1.1: Улсын газрын нэгдмэл сангийн ангиллын өөрчлөлтийн товчоо /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2020	2021	Өөрчлөлт /мян га/
<b>I</b>	<b>Хөдөө аж ахуйн газар</b>	<b>114041.8</b>	<b>113980.0</b>	<b>-61.8</b>
1	Бэлчээрийн газар	109645.6	109584.6	-61.0
2	Хадлангийн талбай	1708.4	1708.8	0.4
3	Тариалангийн газар	1127.5	1126.2	-1.3
4	Атаршсан газар	211.5	211.6	0.1
5	ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар	87.7	88.9	1.2
6	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	1261.1	1259.9	-1.2
<b>II</b>	<b>Хот, тосгон бусад суурины газар</b>	<b>917.6</b>	<b>956.2</b>	<b>38.6</b>
7	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	81.4	81.2	-0.2
8	Нийтийн эдэлбэр газар	320.8	321.4	0.6
9	Үйлдвэрийн газар	46.5	46.3	-0.2
10	Уурхайн газар	384.1	420.6	36.5
11	Гэр хорооллын газар	84.8	86.7	1.9
<b>III</b>	<b>Зам, шугам сүлжээний газар</b>	<b>474.8</b>	<b>477.2</b>	<b>2.4</b>
12	Авто замын газар	329.3	330.6	1.3
13	Төмөр замын газар	35.4	35.7	0.3
14	Агаарын тээврийн газар	9.6	9.6	0.0
15	Шугам сүлжээний газар	100.5	101.3	0.8
16	Усан тээврийн буудлын газар	0.0	0.0	0.0
<b>IV</b>	<b>Ойн сан бүхий газар</b>	<b>14255.9</b>	<b>14256.6</b>	<b>0.7</b>
17	Ой модоор бүрхэгдсэн газар	12109.0	12108.9	-0.1
18	Ой модыг нь огтолсон газар	133.0	133.0	0.0
19	Мод үржүүлгийн газар	62.3	63.3	1.0
20	Ойн сангийн тэлэн ургах нөөц газар	719.2	719.0	-0.2
21	Ойн сангийн бусад газар	1232.4	1232.4	0.0
<b>V</b>	<b>Усны сан бүхий газар</b>	<b>660.9</b>	<b>660.9</b>	<b>0.0</b>
22	Гол мөрний эзлэх газар	221.3	221.3	0.0
23	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	423.8	423.8	0.0
25	Горхи, булаг, шандны эзлэх газар	13.2	13.2	0.0
24	Мөнх цас, мөсөн голын эзлэх газар	2.6	2.6	0.0
<b>VI</b>	<b>Улсын тусгай хэрэгцээний газар</b>	<b>26060.6</b>	<b>26080.7</b>	<b>20.0</b>
26	Улсын тусгай хамгаалалттай газар	21927.0	21927.0	0.0
27	Улсын хилийн зурвас газар	3110.3	3110.3	0.0
28	Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	124.1	124.1	0.0
29	Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консул, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар	0.0	0.0	0.0




30	ШУ, технологийн туршилт, байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай	36.1	36.1	0.0
31	Аймаг дундын отрын бэлчээр	691.4	691.4	0.0
32	Улсын тэжээлийн сангийн хадлангийн газар	110.9	110.9	0.0
33	Бүтээгдхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай	24.5	24.5	0.0
34	Чөлөөт бүсийн газар	2.1	2.1	0.0
35	Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар	34.2	54.2	20.0
36	Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар	0.0	0.0	0.0
<b>НИЙТ ДҮН</b>		<b>156411.6</b>	<b>156411.6</b>	

### 2.1.1. Хөдөө аж ахуйн газар

Хөдөө аж ахуйн газар 113980.0 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 72.9 хувийг эзэлж байна.

Хөдөө аж ахуйн газарт бэлчээрийн газар 109584.6 мянган га буюу 96.1 хувь, хадлангийн газар 1708.8 мянган га буюу 1.5 хувь, тариалангийн газар 1126.2 мянган га буюу 1.0 хувь, атаршсан газар 211.6 мянган га буюу 0.2 хувь, хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн дэвсгэр газар 88.9 мянган га буюу 0.1 хувь, хөдөө аж ахуйн хэрэгцээнд тохиромжгүй газар 1259.9 мянган га буюу 1.1 хувийг тус тус эзэлж байна.



Зураг 2.1.1.1: Хөдөө аж ахуйн газрын эзлэх хувь

Хүснэгт 2.1.1.1: Хөдөө аж ахуйн газрын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2020	2021	Өөрчлөлт /мян га/
<b>I</b>	<b>Хөдөө аж ахуйн газар</b>	<b>114041.8</b>	<b>113980.0</b>	<b>-61.8</b>
1	Бэлчээрийн газар	109645.6	109584.6	-61.0
2	Хадлангийн талбай	1708.4	1708.8	0.4

3	Тариалангийн газар	1127.5	1126.2	-1.3
4	Атаршсан газар	211.5	211.6	0.1
5	ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар	87.7	88.9	1.2
6	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	1261.1	1259.9	-1.2

*Бэлчээрийн газар*

Бэлчээрийн газар нь 2020 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 61.0 мянган га-аар хасагдсан байна. Энэ нь Баян-Өлгий, Говь-Алтай, Дорнод, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ аймгуудад уурхайн газар шинээр ашиглалтад орсон, мөн зам, шугам сүлжээний газар нэмэгдэж бүртгэгдсэн зэрэгтэй холбоотойгоор бэлчээрийн газар хасагдсан байна.

*Хадлангийн газар*

Хадлангийн газар нийтдээ 0.4 мянган га-гаар нэмэгдсэн байгаа нь Говь-Алтай, Увс, Ховд аймгуудад хадлангийн газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлсэнтэй холбоотойгоор хадлангийн газар нэмэгдсэн байна.

*Тариалангийн газар*

Тариалангийн газар нь 2020 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 1.3 га-гаар хасагдсан байна. Тариалангийн газрын хувьд Дорнод аймагт ихээхэн өөрчлөлт гарсан бөгөөд энэ нь тус аймгийн Халхгол суманд газар тариалангийн зориулалтаар газар эзэмшигч 1 аж ахуйн нэгжийн газарт кадастрын хэмжилт, зураглал хийснийг үндэслэн газрын хэмжээнд өөрчлөлт орсноор 3119.44 га газар тариалангийн газраас бэлчээрт шилжсэн, мөн тухайн аймгийн Чулуунхороот, Баянтүмэн сумдад тус бүр 2000 га, нийт 4000 га газрыг эзэмших эрхийг хүчингүй болгосноос тариалангийн газар хасагдсан байна. Бусад ихэнх аймгуудад атаршсан газраас тариалангийн газарт эргүүлэн ашигласнаар Улсын хэмжээнд тариалангийн газар нэмэгдэж бүртгэгдсэн байна /Хүснэгт 2.1.1.2/.


Хүснэгт 2.1.1.2: Тариалангийн газрын өөрчлөлт /аймгаар/

№	Аймгийн нэр	2020	2021	Зөрүү
1	Архангай	29566.1	29838.1	272.0
2	Баянхонгор	2159.7	2214.1	54.4
3	Баян-Өлгий	2662.0	2714.9	53.0
4	Булган	89579.8	90142.1	562.2
5	Говь-Алтай	5207.4	5604.8	397.4
6	Говьсүмбэр	362.0	352.0	-10.0
7	Дархан-Уул	34261.3	34278.7	17.4
8	Дорноговь	581.2	704.3	123.1
9	Дорнод	102723.7	95698.3	-7025.3
10	Дундговь	703.2	806.6	103.3

11	Завхан	18820.7	19078.5	257.8
12	Орхон	5112.9	5113.6	0.7
13	Өвөрхангай	25577.4	26205.5	628.1
14	Өмнөговь	684.9	720.8	35.9
15	Сүхбаатар	17225.3	17239.8	14.5
16	Сэлэнгэ	316665.5	316813.6	148.2
17	Төв	262701.2	263569.2	868.0
18	Увс	81135.5	81868.6	733.2
19	Ховд	10636.8	11104.5	467.6
20	Хөвсгөл	32838.4	33388.0	549.6
21	Хэнтий	80197.9	80708.3	510.4
22	Нийслэл	8136.7	8005.0	-131.7
<b>Нийт дүн</b>		<b>1127539.7</b>	<b>1126169.5</b>	<b>-1370.2</b>

Тайлангийн 2020 оны дүнтэй харьцуулахад тариалангийн газар хамгийн их нэмэгдсэн нь Төв аймагт 868.0 га, Увс аймагт 733.0 га, Өвөрхангай аймагт 628.1 га, Булган аймагт 562.2 га, Ховд аймагт 549.6 га байна. Эдгээр аймгуудын ихэнхэд нь Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу атаршсан талбайг эргүүлэн үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, таримал ургамал тариалах зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад шинээр эзэмшүүлсэнтэй холбоотойгоор гарсан өөрчлөлт юм.

Тариалангийн газрын зориулалтаар 1990 оноос хойшхи хугацаанд ашиглагдаж буй талбайн Улсын хэмжээний дүнг дараах зурагт үзүүлэв /Зураг 2.1.1.2/.



Зураг 2.1.1.2: Тариалангийн газрын өөрчлөлт /мян.га/

Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар

Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар Улсын хэмжээнд нийтдээ 1.2 мянган га-гаар нэмэгдсэн дүнтэй байна.

Нийт 20 аймгийн хэмжээнд хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар тодорхой хэмжээгээр нэмэгдсэн нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хөдөө аж ахуйн барилга байгууламж болон малчдын өвөлжөө, хаваржааны газар олголт хийгдсэн, шинээр бүртгэл хийгдсэнтэй холбоотой байна.


Нийслэл Улаанбаатар хотод хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар 191.5 га-гаар, Завхан аймагт 241.3 га-гаар хасагдсанаар бүртгэгдсэн байна.

Хөдөө аж ахуйн хэрэгцээнд тохиромжгүй газар 1.3 мянган га-гаар хасагдсан нь Баян-Өлгий аймагт 2020 онд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар олгогдсон газрыг хөдөө аж ахуйн хэрэгцээнд тохиромжгүй газарт бүртгэсэн байсныг залруулан тухайн ангиллаас хасч, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газрын ангилал руу шилжүүлэн бүртгэгдсэнтэй холбогдон гарсан өөрчлөлт байна.

**2.1.2.Хот, тосгон, бусад суурины газар**

Хот, тосгон бусад суурины газар 956.2 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 0.6 хувийг эзэлж байна.

Хот, тосгон, бусад суурины газарт барилга, байгууламжийн дэвсгэр газар 81.2 мянган га буюу 8.5 хувийг, нийтийн эдэлбэр газар 321.4 мянган га буюу 33.6 хувийг, үйлдвэрийн газар 46.3 мянган га буюу 4.8 хувийг, уурхайн газар 420.6 мянган га буюу 44.0 хувийг, гэр хорооллын газар 86.7 мянган га буюу 9.1 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.2.1/.



Зураг 2.1.2.1: Хот тосгон, бусад суурин газрын эзлэх хувь

Хүснэгт 2.1.2.1. Хот, тосгон, бусад суурин газрын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2020	2021	Өөрчлөлт / мян га/
<b>II</b>	<b>Хот, тосгон бусад суурины газар</b>	<b>917.6</b>	<b>956.2</b>	<b>38.6</b>
1	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	81.4	81.2	-0.2
2	Нийтийн эдэлбэр газар	320.8	321.4	0.6
3	Үйлдвэрийн газар	46.5	46.3	-0.2
4	Уурхайн газар	384.1	420.6	36.5
5	Гэр хорооллын газар	84.8	86.7	1.9

Газрын нэгдмэл сангийн 2021 оны тайлангийн дүнгээр барилга байгууламжийн дэвсгэр газар нийт аймгуудад тодорхой хэмжээгээр нэмэгдсэн боловч Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт 19390.4 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зориулалтаар, нийслэлийн Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 509.1 га газар, мөн дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт 2.01 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зориулалтаар, "Туул-Сонгино усны нөөцийн цогцолбор" төслийг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт 5 байршилд нийт 43.6 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зориулалтаар тус тус улсын тусгай хэрэгцээнд авсантай холбоотойгоор барилга байгууламжийн доорхи газраас нийт 2021.2 га газар Улсын тусгай хэрэгцээний газарт шилжсэн байна.


Бусад аймгуудад барилга байгууламжийн дэвсгэр газар нийтдээ 1.8 мянган га, гэр хорооллын газар 1.9 мянган га-аар нэмэгдсэн байгаа нь нийслэл болон аймгуудад барилга барих зориулалтаар болон Монгол Улсын иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар эзэмшүүлж, өмчлүүлж байгаатай холбоотой юм.

Мөн тайлант онд уурхайн газар Говь-Алтай аймагт 6796.9, Дорнод аймагт 485.8, Дорноговь аймагт 18706.9, Дундговь аймагт 513.1, Өмнөговь аймагт 1110.0, Сүхбаатар аймагт 410.6, Сэлэнгэ аймагт 274.8, Төв аймагт 3586.7, Хэнтий аймагт 139.7 га-гаар тус тус нэмэгдсэн байна. Эдгээр аймгуудад 2021 онд уул уурхайн ашиглалтын лицензийг үндэслэн ашигт малтмал олборлох зориулалтаар үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад уул уурхайн зориулалтаар эзэмшүүлэх шийдвэр гаргаж, гэрээ байгуулсан байна.

### **2.1.3.Зам, шугам сүлжээний газар**

Зам, шугам сүлжээний газар 477.2 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 0.3 хувийг эзэлж байгаа бөгөөд 2020 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 0.3 га-гаар нэмэгдсэн байна /Хүснэгт 2.1.3.1/.

Зам, шугам сүлжээний газарт авто замын газар 330.6 мянган га буюу 69.3 хувийг, төмөр замын газар 35.7 мянган га буюу 7.5 хувийг, агаарын тээврийн газар 9.6 мянган га буюу 2.0 хувийг, шугам сүлжээний газар 101.3 мянган га буюу 21.2 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.3.1/.



Зураг 2.1.3.1: Зам, шугам сүлжээний газрын эзлэх хувь

Хүснэгт 2.1.3.1: Зам, шугам, сүлжээний газрын ангиллын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2020	2021	Өөрчлөлт /мян га/
<b>III</b>	<b>Зам, шугам сүлжээний газар</b>	<b>474.8</b>	<b>477.2</b>	<b>2.4</b>
1	Авто замын газар	329.3	330.6	1.3
2	Төмөр замын газар	35.4	35.7	0.3
3	Агаарын тээврийн газар	9.6	9.6	0.0
4	Шугам сүлжээний газар	100.5	101.3	0.8
5	Усан тээврийн буудлын газар	0.0	0.0	0.0

Автозамын газар улсын хэмжээнд нийтдээ 1.3 мянган га-гаар нэмэгдсэн байна. Баян-Өлгий аймаг 234.0 га, Дорнод аймаг 408.8 га, Өмнөговь аймаг 75.3 мянган га, Сэлэнгэ аймаг 186.1 га, нийслэл Улаанбаатар хотод 6.8 га автозамын газрыг шинээр бүртгэсэн байна. Баян-Өлгий аймгийн Өлгий хотыг тойруулан барьж буй 19 км улсын чанартай авто зам болон тус аймгийн 2 сумын хилийн цэс өөрчлөгдсөн, Дорнод аймгийн Баян-Уул сумын 400 га, Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн, Ерөө сумдад автозамын газрыг шинээр бүртгэсэн зэрэгтэй холбоотойгоор автозамын газар нэмэгдсэн байна.

Төмөр замын газар улсын хэмжээнд 0.3 мянган га-гаар нэмэгдсэн байгаа нь Өмнөговь аймагт бэлчээр болон нийтийн эдэлбэр газраас төмөр замын ашиглалтын газрын зориулалтаар ангилал шилжүүлэн бүртгэсэн байна.


Шугам сүлжээний газар ихэнх аймгууд болон нийслэлд цэвэр, бохир ус дамжуулах хоолой, эрчим хүчний шугамыг шинээр барьж байгуулан бүртгэснээр улсын хэмжээнд 0.8 мянган га-гаар нэмэгдсэн дүнтэй байна.

Агаарын тээврийн зориулалтаар ашиглагдаж буй газрын хэмжээнд өөрчлөлт ороогүй байна.

### 2.1.4. Ойн сан бүхий газар

Ойн сан бүхий газар 14256.6 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 9.1 хувийг эзэлж байна.

Ойн сан бүхий газарт ойгоор бүрхэгдсэн газар 12108.9 мянган га буюу 84.9 хувийг, ой модыг нь огтолсон газар 133.0 мянган га буюу 0.9 хувийг, мод үржүүлгийн газар 63.3 мянган га буюу 0.4 хувийг, ой тэлэн ургах нөөц газар 719.0 мянган га буюу 5.0 хувийг, ойн сангийн бусад газар 1232.4 мянган га буюу 8.6 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.4.1/.



Зураг 2.1.4.1: Ойн сан бүхий газрын эзлэх хувь

Хүснэгт 2.1.4.1: Ойн сан бүхий газрын өөрчлөлт /мян.га/


№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2020	2021	Өөрчлөлт /мян га/
<b>IV</b>	<b>Ойн сан бүхий газар</b>	<b>14255.9</b>	<b>14256.6</b>	<b>0.7</b>
1	Ой модоор бүрхэгдсэн газар	12109.0	12108.9	-0.1
2	Ой модыг нь огтолсон газар	133.0	133.0	0.0
3	Мод үржүүлгийн газар	62.3	63.3	1.0
4	Ой тэлэн ургах нөөц газар	719.2	719.0	-0.2
5	Ойн сангийн бусад газар	1232.4	1232.4	0.0

2021 онд Баян-Өлгий, Булган, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв аймгуудад мод үржүүлгийн газрын зориулалтаар газар олгож, тухайн ангиллын газар нь ой модоор бүрхэгдсэн газар болон ой тэлэн ургах нөөц газар болон бэлчээрийн газраас шилжүүлэн нэмж бүртгэсэн байна.

### 2.1.5. Усны сан бүхий газар

Усны сан бүхий газар 660.9 мянган га буюу нийт газар нутгийн 0.4 хувийг эзэлж байна.

Усны сан бүхий газарт мөрөн, гол, горхи 221.3 мянган га буюу 33.5 хувийг, нуур, цөөрөм 423.8 мянган га буюу 64.1 хувийг, горхи, булаг, шанд 13.2 мянган га буюу 2.0 хувийг, мөнх цас, мөсөн гол 2.6 мянган га буюу 0.4 хувийг тус тус эзэлж байна / Зураг 2.1.5.1/.



Зураг 2.1.5.1: Усны сан бүхий газрын эзлэх хувь

Хүснэгт 2.1.5.1: Усны сан бүхий газрын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2020	2021	Өөрчлөлт /мян га/
<b>V</b>	<b>Усны сан бүхий газар</b>	<b>660.9</b>	<b>660.9</b>	<b>0.0</b>
1	Гол мөрний эзлэх газар	221.3	221.3	0.0
2	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	423.8	423.8	0.0
3	Горхи, булаг, шандны эзлэх газар	13.2	13.2	0.0
4	Мөнх цас, мөсөн голын эзлэх газар	2.6	2.6	0.0

Усны сан бүхий газрын хэмжээнд 2021 онд өөрчлөлт ороогүй байна.

## 2.2. УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР /МАЯГТ ГТ-4/

Улсын тусгай хэрэгцээний газрын нийт хэмжээ 26080.7 мянган га талбай буюу улсын нийт нутаг дэвсгэрийн 16.67 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оныхоос 0.01 хувиар өссөн байна.





Зураг 2.2.1: Улсын тусгай хэрэгцээний газрын эзлэх хувь

Улсын тусгай хэрэгцээний газрын ангилалд Улсын тусгай хамгаалалттай газар 21927.0 мянган га буюу 84.07 хувийг, улсын хилийн зурвас газар 3110.34 мянган га буюу 11.92 хувийг, улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар 124.1 мянган га буюу 0.47 хувийг, гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар 0.04 мянган га буюу 0.0001 хувийг, шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай 36.13 мянган га буюу 0.13 хувийг, аймаг дундын отрын бэлчээр 691.41 мянган га буюу 2.65 хувийг, улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай 110.94 мянган га буюу 0.42 хувийг, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай 24.47 мянган га буюу 0.09 хувийг, чөлөөт бүсийн газар 2.11 мянган га буюу 0.008 хувийг, үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар 54.15 мянган га буюу 0.2 хувийг, аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар 0.02 мянган га буюу 0.0001 хувийг тус тус эзэлж байна.


Тайлант онд Улсын хэмжээнд 19945.11 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 307 дугаар тогтоолоор Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрийн 19390.4 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зориулалтаар;
- Засгийн газрын 2021 оны 251 дүгээр тогтоолоор Нийслэлийн Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 509.1 га газар, мөн дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт 2.01 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зориулалтаар;
- Засгийн газрын 2021 оны 280 дугаар тогтоолоор "Туул-Сонгино усны нөөцийн цогцолбор" төслийг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт 5 байршилд нийт 43.6 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн

байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зориулалтаар тус тус улсын тусгай хэрэгцээнд авсан байна.

Хүснэгт 2.2.1: Улсын тусгай хэрэгцээний газрын өөрчлөлт /га-гаар/

Д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	2020	2021	Зөрүү
VI	<b>Улсын тусгай хэрэгцээний газар</b>	26060758.76	26080703.87	19945.11
1	Улсын тусгай хамгаалалттай газар, бүгд	21926998.72	21926998.72	0.0
a	дархан цаазат газар	10919403.00	10919403.00	0.0
б	байгалийн цогцолборт газар	8883939.10	8883939.10	0.0
в	байгалийн нөөц газар	2044351.62	2044351.62	0.0
г	дурсгалт газар	79305.00	79305.00	0.0
2	Улсын хилийн зурвас газар	3110340.89	3110340.89	0.0
3	Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	124097.61	124097.61	0.0
4	Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар	37.62	37.62	0.0
5	Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай	36125.64	36125.64	0.0
6	Аймаг дундын отрын бэлчээр	691413.80	691413.80	0.0
7	Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай	110940.00	110940.00	0.0
8	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай	24470.00	24470.00	0.0
9	Чөлөөт бүсийн газар	2108.40	2108.40	0.0
10	Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар	34203.90	54149.01	19945.11
11	Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар	22.00	22.00	0.0



Зураг 2.2.2: Улсын тусгай хэрэгцээний газрын ангиллын талбайн хэмжээ /га/

Энэхүү өөрчлөлтөөр хөдөө аж ахуйн газраас 15718.65 га, хот тосгон, бусад суурины газраас 3079.65 га, зам, шугам сүлжээний газраас 974.44 га, ойн сан бүхий газрын 172.37 га тус тус Улсын тусгай хэрэгцээний газрын ангилалд шилжсэн байна.


Хүснэгт 1.2.2: Улсын тусгай хэрэгцээний газрын ангилалд шилжсэн газрууд /га/

Газрын нэгдмэл сангийн ангилал		Талбайн хэмжээ /га/
Хөдөө аж ахуйн газар	<b>Бүгд</b>	<b>15718.65</b>
	Бэлчээр	14548.51
	Хадлан	-
	Тариалан	967.23
	Атаршсан газар	-
	ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар	202.91
	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	-

Хот тосгон, бусад суурины газар	<b>Бүгд</b>	<b>3079.65</b>
	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	2021.20
	Уурхайн газар	386.97
	Нийтийн эдэлбэрийн газар	46.47
	Гэр хорооллын газар	625.01
Зам, шугам сүлжээний газар	<b>Бүгд</b>	<b>974.44</b>
	Авто зам	251.63
	Төмөр зам	8.31
	Агаарын тээвэр	506.44
	Шугам сүлжээний газар	208.06
Ойн сан бүхий газар	<b>Бүгд</b>	<b>172.37</b>
	Ойгоор бүрхэгдсэн газар	-
	Ой модыг нь огтолсон газар	-
	Мод үржүүлгийн газар	172.37
	Ой тэлэн ургах нөөц газар	-
<b>Нийт дүн</b>		<b>19945.11</b>


### 2.3. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-2/

Улсын хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт **8.1 сая** га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгоод байна. Үүнээс **68.1 мянган** га-г өмчилж, **7.6 сая** га-г эзэмшиж, **337.1 мянган** га газрыг ашиглаж байна. Мөн бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллага **27.5 мянган** га газрыг тус тус ашиглаж байна /Зураг 2.3.1/.




Зураг 2.3.1: 2021 оны байдлаар өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газар /хувиар/

Тайлант оны газар, өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн нийт талбайг 2020 онтой харьцуулбал **421.0** мянган га-гаар өссөн байна /Зураг 2.3.2/.




Зураг 2.3.2: Нийт өмчлөл, эзэмшил, ашиглалтанд буй газрыг урьд оны дүнтэй харьцуулсан байдал /га-гаар/


Газрын эрхийн төрлөөр 2019 оны үзүүлэлттэй харьцуулахад иргэн, хуулийн этгээдийн өмчлөлийн газар **68.1** мянган га болж **2.2** мянган га-аар /Зураг 2.3.3/, иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж буй газар **7.6 сая** га болж **62.0** мянган га-гаар /Зураг 2.3.4, иргэн, хуулийн этгээдийн ашиглаж буй газар **337.1** мянган га болж **23.1** мянган га-гаар /Зураг 2.3.6/, бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар **27.5** мянган га болж **48.2** га-гаар тус тус өссөн дүнтэй байна /Зураг 2.3.5/.




Зураг 2.3.3: Өмчлүүлсэн газар /га-гаар/



Зураг 2.3.4: Эзэмшүүлсэн газар /га-гаар/



Зураг 2.3.5: Бусад ашиглуулж буй эзэмшлийн газар /га-гаар/




Зураг 2.3.6: Ашиглуулсан газар /га-гаар/

Газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангиллаар авч үзвэл хөдөө аж ахуйн газарт **1.3** сая га, хот тосгон, бусад суурины газарт **659.8** мянган га, зам, шугам сүлжээний газарт **194.2** мянган га, ойн сан бүхий газарт **680.7** мянган га, усны сан бүхий газарт **83.3** мянган га, улсын тусгай хэрэгцээний газарт **5.1** сая га газар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтанд олгогдоод байна /Зураг 2.3.7/.

Хүснэгт 2.3.1: Газрын нэгдмэл сангийн ангилал дахь эрхийн төрлийн өөрчлөлт

д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	Эрхийн төрөл	2020 он	2021 он	Зөрүү
1	Хөдөө аж ахуйн газар	өмчлөгч	135.2	135.2	0
		эзэмшигч	1305985.0	1327993.44	22008.4
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	7035.7	7041.45	5.8
		ашиглагч	8522.4	10036.47	1514.0
		нийт	1321678.3	1345128.89	23450.6
2	Хот, тосгон, бусад суурины газар	өмчлөгч	65701.04	67746.55	2045.5
		эзэмшигч	348960.9	370995.15	22034.2
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	16731.3	16731.3	0.0
		ашиглагч	183758.2	204350.85	20592.7
		нийт	614481.9	659823.82	45341.9
3	Зам, шугам сүлжээний газар	өмчлөгч	0.00	287.00	287.0
		эзэмшигч	157294.7	162378.82	5084.1
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	3367.7	3410.21	42.5
		ашиглагч	27141.8	28160.08	1018.3
		нийт	187804.3	194236.11	6431.8
4	Ойн сан бүхий газар	эзэмшигч	674754.7	674795.36	40.66
		ашиглагч	5943.2	5943.2	0.00
		нийт	680697.9	680738.52	40.62

5	Усны сан бүхий газар	эээмшигч	83263.7	83272.19	8.49
		ашиглагч	0.00	0.00	0.0
		нийт	83263.7	83272.19	8.49
6	Улсын тусгай хэрэгцээний газар	эээмшигч	5003738.4	5016580.35	12841.95
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	329.1	329.1	0.0
		ашиглагч	88605.9	88605.2	-0.7
		нийт	5092672.7	5105514.65	12841.95



Зураг 2.3.7: Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг газрын нэгдмэл сангийн ангиллаар үзүүлсэн байдал /хувиар/




Зураг 2.3.8: Нийт газар өмчлөл, эзэмшил, ашиглалтын газрын хэмжээг 21 аймгийн хэмжээнд үзүүлсэн байдал /га-аар/




## 2.4. ГАЗРЫН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-3/

Улсын хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт **1151476** газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч байгаа нь өмнөх оныхоос нийт дүнгээрээ **41430**-аар өссөн байна /Зураг 2.4.1/.




Зураг 2.4.1: Нийт өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг урьд оны дүнтэй харьцуулсан байдал /тоогоор/

Тайлант онд газар өмчлөгч **663145**, эзэмшигч **486099**, бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага **821**, газар ашиглагч **1411** иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тус тус байна /Зураг 2.4.2/.




Зураг 2.4.2: Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдын хувь


Газрын эрхийн төрлөөр 2020 оны үзүүлэлттэй харьцуулахад газар өмчлөгчийн тоо 663145 болж 15481-ээр /Зураг 2.4.3/, газар эзэмшигчийн тоо 486099 болж, 25751-аар /Зураг 2.4.4/, газар ашиглагчийн тоо 1411 болж 147-аар /Зураг 2.4.5/, бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 821 болж 51-оор /Зураг 2.4.6/ тус тус өссөн дүнтэй байна.




Зураг 2.4.3: Газар өмчлөгч /тоогоор/



Зураг 2.4.4: Газар эзэмшигч /тоогоор/




Зураг 2.4.5: Газар ашиглагч /тоогоор/



Зураг 2.4.6: Бусдын эзэмшил газрыг ашиглагч


Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангиллаар үзүүлбэл хөдөө аж ахуйн газарт **181586**, хот тосгон, бусад суурины газарт **956227**, зам, шугам сүлжээний газарт **7360**, ойн сан бүхий газарт **4654**, усны сан бүхий газарт **70**, улсын тусгай хэрэгцээний газарт **1579** иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байна /Зураг 2.4.7/.




Зураг 2.4.7: Газрын нэгдмэл сангийн ангиллаар үзүүлсэн байдал /эзлэх хувь/

Хүснэгт 2.4.1: Газар эзэмшигч, ашиглагчдын өөрчлөлт /газрын нэгдмэл сангийн ангиллаар/

д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	Эрхийн төрөл	2020	2021	Зөрүү
1	Хөдөө аж ахуйн газар	өмчлөгч	90	133	43
		эзэмшигч	177040	181219	4179
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	170	187	17
		ашиглагч	44	17	-27
		нийт	177344	181586	4242
2	Хот, тосгон, бусад суурины газар	өмчлөгч	647574	658912	11338
		эзэмшигч	274818	296099	21281
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	183	216	33
		ашиглагч	909	1000	91
		нийт	922042	956227	34185
3	Зам, шугам шүлжээний газар	өмчлөгч	0	4100	4100
		эзэмшигч	2822	2896	74
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	29	30	1
		ашиглагч	281	334	53
		нийт	3133	7360	4227
4	Ойн сан бүхий газар	эзэмшигч	4436	4645	209
		ашиглагч	8	9	1
		нийт	4444	4654	210
5	Усны сан бүхий газар	эзэмшигч	68	70	2
		ашиглагч	0	0	0
		нийт	68	70	2
6	Улсын тусгай хэрэгцээний газар	эзэмшигч	1163	1170	7
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	388	388	0
		ашиглагч	22	21	-1
		нийт	1573	1579	6



Зураг 2.4.8: Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдын тоог 21 аймгийн хэмжээнд үзүүлсэн байдал /тоогоор/




Зураг 2.4.9: Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдын тооны өсөлтийг 2003 оноос хойш үзүүлсэн байдал /тоогоор/

## 2.5. ГАЗАРТ УЧРУУЛСАН ХОХИРЛЫН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-6/

Нийслэл, 21 аймгаас ирүүлсэн 2021 оны “Газарт учруулсан хохирлын тайлан”-г ГТ-6 маягтаар хүлээн авч, улсын хэмжээнд нэгтгэн дүгнэв.

Улсын хэмжээнд нийт 6.3 сая га газарт хохирол учирсан байгаа бөгөөд өмнөх оны дүнгээс 748.1 мянган га талбайгаар их байна. Үүнийг ангилан үзвэл тариалангийн 112.5 мянган га, бэлчээр ба бусад өвслөг ургамал газрын 5.9 сая га, хот тосгон, бусад суурин газрын 44.5 мянган га, ойн сан бүхий газрын 229.1 мянган га, усны сан бүхий газрын 1.4 мянган га газарт тус тус хохирол учирсан бол 12.7 мянган га газар ухагдаж эвдэрсэн байна /Зураг 2.5.1/



Зураг 2.5.3: Газарт учруулсан хохирлын хэмжээ.

### 2.5.1. Тариалангийн газар


Тариалангийн газрын хохирлын тайланг салхи, усны элэгдэл эвдрэлд орсон, үржил шим буурсан, хортон шавьжид нэрвэгдсэн, хөрс бохирдсон, химийн бодисоор бохирдсон, бусад гэсэн 8 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийт 112.5 мянган га тариалангийн талбайд хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 1.7 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 25.9 мянган га талбайгаар өссөн байна.

Тариалангийн газарт хамгийн их хохирол учруулсан хүчин зүйл бол мэрэгчид, хортон шавьжийн нөлөө 90.1 мянган га (тариалангийн газрын ангиллын 80%), химийн бодисоор бохирдсон 7.9 мянган га (7.01%) байна.

Хохирол учирсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл үржил шимийн бууралттай 5.9 мянган га, салхины эвдрэлд орсон 3.8 мянган га, усны эвдрэлд орсон 3.1 мянган

га, хөрс бохирдсон 1.0 мянган га, онц аюултай ургамалд нэрвэгдсэн 281 га, бусад 405 га гэсэн дараалалтай байна /Зураг 2.5.2/



Зураг 2.5.2: Тариалангийн газарт учирсан хохирол, га-аар.


### 2.5.2. Бэлчээрийн газар

Бэлчээрийн газрын хохирлын тайланг талхлагдсан, салхи, усны эвдрэлд орсон, намагжсан, элсний нүүлтэд орсон, мэрэгчид, хортон шавьжид идэгдсэн, цөлжсөн, ашигт малтмалын олборлолтод өртсөн, газрын тосны олборлолтоос бохирдсон гэсэн 8 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийт 5.9 сая га бэлчээрт хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 93.6 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 651.6 мянган га талбайгаар их байна.

Бэлчээрийн газарт хамгийн их хохирол учруулсан хүчин зүйл бол мэрэгчид, хортон шавьжийн нөлөөнд нэрвэгдсэн байна. Өөрөөр хэлбэл нийт хохирол учирсан талбайн 54 хувь буюу 3.2 сая га талбай мэрэгчид, хортон шавьжийн нөлөөнд өртсөн байна.

Бусад хохирол учирсан бэлчээрийн газрыг ангилж үзвэл салхи, усны эвдрэлд орсон 1.6 сая га (бэлчээрийн газрын ангиллын 27%), талхлагдсан 704.5 мянган га (11.9%), цөлжсөн 298.9 мянган га (5%), элсний нүүлтэд орсон 65.0 мянган га (1.1%), ашигт малтмалын олборлолтод өртсөн 666.8 га (0.01%), газрын тосны олборлолтоос бохирдсон 3.3 га байна /Зураг 2.5.3/.



Зураг 2.5.3: Бэлчээрт учирсан хохирол, га-аар.

### 2.5.3. Хот тосгон, бусад суурин газар


Хот тосгон, бусад суурин газрын хохирлын тайланг ургамлан бүрхэвчгүй болсон, элсний нүүлтэд орсон, химийн болон цацраг идэвхт бодисоор хордсон, үйлдвэрийн хог хаягдлаар бохирдсон, ахуйн хог хаягдлаар бохирдсон, бусад гэсэн 6 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийт 44.5 мянган га хот суурины газарт хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 0.7 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 323.8 га талбайгаар их байна.

Хот тосгон, бусад суурин газрын бохирдолд нөлөөлсөн гол хүчин зүйл нь хүний үйл ажиллагаанаас шалтгаалан ургамлан бүрхэвчгүй болсон, ахуйн хог хаягдлаар бохирдсон зэрэг байна.

Өөрөөр хэлбэл нийт хохирол учирсан талбайн 49 хувь буюу 21.8 мянган га газар ургамлан бүрхэвчгүй болж доройтсон, 49.7 хувь буюу 22.1 мянган га ахуйн хог хаягдлаар бохирдуулсан, элсний нүүлтэд орсон 320.2 га талбай байна.

Бусад хохирол учирсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл бусад 320.2 га (0.7%) элсний нүүлтэд орсон, үйлдвэрийн хог хаягдлаар бохирдсон 7.57 га (0.01%) гэсэн үзүүлэлттэй байна /Зураг 2.5.4/.




Зураг 2.5.4: Хот, тосгон бусад суурины газарт учирсан хохирол, га-аар.

### 2.5.4. Ойн сан бүхий газар

Ойн сан бүхий газрын хохирлын тайланг түймэрт нэрвэгдсэн, өвчин, хортон шавьжинд идэгдсэн, мод бут, сөөг, загийг устгасан, ашигт малтмалын олборлолтод өртсөн, бусад гэсэн 5 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийт 229.1 мянган га ойн сан бүхий газарт хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 3.6 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 92.5 мянган га талбайгаар их байна. Ойн сан бүхий газарт хамгийн их хохирол учруулсан хүчин зүйл нь ойн түймэр байна. Өөрөөр хэлбэл нийт хохирол учирсан талбайн 61 хувь буюу 140.1 мянган га газар ойн түймэрт нэрвэгдсэн байна.

Бусад хохирол учирсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл өвчин хортон шавьжид идэгдсэн 87.0 мянган га (ойн сангийн ангиллын газрын 37.9%), мод бут, сөөг, загийг устгасан 1.9 мянган га (0.8%)8 ашигт малтмалын олборлолтод өртсөн 140.3 га (0.06%) гэсэн дараалалтай байна /Зураг 2.5.5/.



Зураг 2.5.5: Ойн сан бүхий газарт учирсан хохирол, га-аар.




### 2.5.5. Усны сан бүхий газар

Усны сан бүхий газрын хохирлын тайланг гадаргын болон гүний ус бохирдсон, үйлдвэрийн хордолт, бохирдолтод өртсөн эрэг хавийн газар, ашигт малтмалын олборлолтоос эвдрэлд өртсөн эрэг хавийн газар, бусад гэсэн 4 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийт 1.4 мянган га усны сан бүхий газарт хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 0.02 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 1.2 мянган га талбайгаар их байна.

Усны сан бүхий газрын хамгийн их хохирол учирсан талбай бол гадаргын болон гүний ус бохирдсон 1.2 мянган га буюу тухайн усан сангийн ангиллын газрын 91%, ашигт малтмалын олборлолтоос эвдрэлд өртсөн эрэг хавийн газар 76.4 га талбай буюу тухайн ангиллын газрын 5.6% байна /Зураг 2.5.6/.



Зураг 2.5.6: Усны сан бүхий газарт учирсан хохирол, га-аар.

### 2.5.6. Ухагдаж эвдэрсэн газар

Ухагдаж эвдэрсэн газрыг геологийн эрэл хайгуулын ажлаас, ашигт малтмалын олборлолтоос, батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны улмаас, барилга, инженерийн шугам сүлжээ барих, засвар үйлчилгээ хийх ажлаас, зам тээвэр холбооны барилга засвар, үйлчилгээний ажлаас гэсэн 5 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийт 12.7 мянган га газар ухагдаж эвдэрсэн нь нийт хохирол учирсан талбайн 0.2 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 23.4 мянган га талбайгаар бага байна. Ашигт малтмалын олборлолтын улмаас хамгийн их талбай ухагдаж эвдэрсэн байна. Өөрөөр хэлбэл ухагдаж эвдэрсэн газрын 89.2 хувь буюу 11.3 мянган га газар ашигт малтмалын олборлолтод өртсөн байна.

Бусад хохирол учирсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл зам тээвэр холбооны барилга засвар, үйлчилгээний ажлаас 1.1 мянган га (8.6%), батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанаас 133.6 га (1.0%), геологийн эрэл хайгуулын ажлаас 93 га (0.7%) барилга, инженерийн шугам сүлжээ барих, засвар үйлчилгээ хийх ажлаас 39.3 га (0.3%), гэсэн үзүүлэлттэй байна /Зураг 2.5.7/.




Зураг 2.5.7: Ухагдаж эвдэрсэн газар, га-аар.

2021 оны мэдээгээр Сэлэнгэ, Улаанбаатар, Өмнөговь, Архангай, Дархан-Уул, Дундговь аймгуудад хамгийн их ухагдаж эвдэрсэн байдалтай байна.

## 2.6. ГАЗАР ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН /МАЯГТ ГТ-7/

Нийслэл, 21 аймгаас ирүүлсэн 2021 оны “Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайлан”-г ГТ-7 маягтаар хүлээн авч, улсын хэмжээнд нэгтгэн дүгнэв.

